

## **ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль нь гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх, гэм буруутай этгээдэд шударгаар ял оногдуулах, гэм буруугүй хүнийг хохироохгүй байх, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх зэрэг үндсэн зорилготой. Гэвч 2017 онд батлагдсан шинэчилсэн найруулгын хэрэгжилтийн явцад хүний эрхийн баталгааг бүрэн хангахгүй, шүүхийн өмнө талуудын эрх тэгш байдлыг алдагдуулах, нотлох баримтыг тэгш үнэлэхгүй байх зэрэг хүндрэл, зөрчил байсаар ирсэн. Иймээс энэхүү хуулийг шинэчлэх зайлшгүй шаардлага тулгарч, олон улсын жишгийг харгалзан, хүний эрхийн баталгааг хангах зорилгоор нэмэлт, өөрчлөлтийн төслийг боловсрууллаа.

### **Шударгаар шүүлгэх эрх**

Хуулийн зорилтод шударгаар шүүлгэх эрхийг тодорхой зааж өгөх шаардлагатай болсон. Учир нь Үндсэн хуулийн 16-р зүйлийн 14 болон Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 10-р зүйлд заасан 'шударгаар шүүлгэх' эрх манай хуульд бүрэн тусгагдаагүй байсан бөгөөд практикт энэ эрх хангалттай баталгаажаагүй. Иймээс уг эрхийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нэмэлтээр тусгав.

### **“Хангалттай үндэслэл” ойлголт**

Өмнөх хуульд 'хангалттай үндэслэл' гэсэн нэр томъёонд шүүхийг багтааснаар шүүхээс өмнө мөрдөн шалгах шатанд оролцогчдын хүсэлтийг татгалзах үндэслэл болгон ашиглаж байв. Энэ нь шүүгдэгчийн шударгаар шүүлгэх, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчимд нийцэхгүй. Тиймээс 'шүүх' гэсэн үгийг хасаж, зөвхөн прокурор, мөрдөгчид үлдээсэн.

### **Сонгуулийн үеийн жишээ**

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн дагуу нэр дэвшигчийг зөвхөн онцгой нөхцөлд баривчилж болно. Гэвч 2020 оны сонгуулийн үеэр зарим нэр дэвшигчийг СЕХ-ны зөвшөөрөлгүйгээр цагдан хорьсон нь хууль хэрэглээний тод жишээ болсон. Энэ асуудлыг хуульд илүү тодорхой болгох үүднээс бусад хуульд туссан зохицуулалтыг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд дагаж мөрдөх тухай заалтыг нэмж тусгав.

### **Цахим харилцааны нууц**

Техник технологийн хөгжлийн улмаас иргэдийн хувийн болон гэр бүлийн харилцаа цахим хэлбэрт шилжиж, цахим хэрэгсэл, сошиал сүлжээнд хадгалагдах болсон. Үүний улмаас цахим харилцааны мэдээллийг хуульд заавал

хамгаалах шаардлага үүссэн. Иймд цахим харилцааны мэдээллийг иргэний хувийн нууцын нэг хэсэг болгон хамгаалах заалтыг тусгасан.

### **Хяналтын шатны шүүх**

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь хүний эрхийг хязгаарлаж болзошгүй тул хяналтын шатны шүүхээс Үндсэн хуулиар баталгаажсан хүний үндсэн эрх зөрчигдсөн эсэхийг хянах зохицуулалттай байх нь чухал. Ингэснээр хүний эрхийн баталгаа хоосон тунхаглал бус, бодитоор хэрэгждэг болно.

### **Өмгөөлөгчийн оролцоо**

Өмнөх зохицуулалтаар өмгөөлөгчийн оролцоо хязгаарлагдмал байсан. Харин нэмэлт өөрчлөлтөөр өмгөөлөгчид хохирогч, гэрч, шинжээчээс урьд өгсөн мэдүүлгийг дахин тодруулах, асуултаа урьдчилан тодорхойлох зэрэг өргөтгөсөн эрх олгож байна. Энэ нь хэргийн бодит байдлыг тогтооход тэнцвэртэй оролцоог хангах ач холбогдолтой.

### **Сэжигтний эрх**

2017 оны шинэчилсэн найруулгаар 'сэжигтэн' гэх ойлголтыг хассан боловч хууль хэрэглээний явцад сэжигтний эрх зүйн байдал тодорхойгүй болж, гэрчээр мэдүүлэг авах зэрэг хүндрэл гарсан. Иймд 'сэжигтэн' гэх ойлголтыг дахин хуульчилж, түүний эрхийг шүүгдэгчтэй адил хамааруулах өөрчлөлтийг оруулсан.

### **Дуугүй байх эрх**

Мирандагийн зарчимд тулгуурлан яллагдагчийн дуугүй байх, мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхийг хуульчилсан. Учир нь иргэн өөрийн эсрэг, гэр бүлийн гишүүдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхтэй бөгөөд энэ нь шударгаар шүүлгэх эрхийн баталгаа юм.

### **Нотлох баримт**

Өмнө нь өмгөөлөгчийн цуглуулсан баримтыг нотлох баримтад тооцдоггүй байснаар талуудын тэгш байдал алдагдаж байсан. Шинэ өөрчлөлтөөр өмгөөлөгчийн хуульд заасан эрхийн хүрээнд гаргуулсан баримтыг нотлох баримтад тооцдог болгосон. Энэ нь шүүхийн өмнө талуудын тэгш байдлыг хангах үндсэн алхам юм.

### **Гомдол гаргах эрх**

Өмнөх хуульд прокурорын нэгжих, хөрөнгө битүүмжлэх зэрэг шийдвэр эцсийнх байж, шүүхийн хяналтад өртдөггүй байсан. Шинэ өөрчлөлтөөр эдгээр шийдвэрийг шүүхэд гомдол гаргаж хянуулах боломжийг нээсэн. Энэ нь эрх мэдлийн хуваарилалт болон иргэдийн шударга шүүхээр шүүлгэх эрхийг хангахад чухал ач холбогдолтой.

№	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль	Төсөл	Танилцуулга
1.1 дүгээр зүйл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилт			
1	<p>1.1 дүгээр зүйлийн 1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилт нь гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоон шударгаар ял оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсэн эрхийг сэргээхэд оршино.</p>	<p>Үг нэмэх</p> <p>1.1 дүгээр зүйлийн 1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилт нь гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоон шударгаар ял оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, <b>шударгаар шүүлгэх эрхийг хангах</b>, зөрчигдсэн эрхийг сэргээхэд оршино.</p>	<p>Үндсэн хуулийн 16-р зүйлийн 14-т “шударга шүүхээр шүүлгэх” эрхийг баталгаажуулсан. Энэхүү эрхийг Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 10-р зүйлд заасан “шударгаар шүүлгэх” эрхтэй ижил агуулгатай гэж Үндсэн хуулийн цэц 2021 оны 07 дүгнэлтэд туссан байдаг. Нэг талаас эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилт нь гэмт хэргийг илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоон шударгаар ял оногдуулах, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсэн эрхийг сэргээхэд оршдог бол нөгөө талаас гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байхад оршдог. Харин гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэм буруутай эсэхийг хянан шударгаар хянан шийдвэрлэх нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх эрх зүйн зайлшгүй нэг зорилтод хамаарна. Тиймээс Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (цаашид хууль гэх)-ийн зорилтод шударгаар шүүлгэх эрхийг хангах зорилтыг төсөлд нэмж тусгав.</p>

1.4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт		
2	1.4 дүгээр зүйлийн 1.25."хангалттай үндэслэл" гэж <b>шүүх</b> , прокурор, мөрдөгч энэ хуульд заасан шийдвэр гаргахад нөлөөлж байгаа бодит баримтад тулгуурласан нөхцөл үүссэнийг;	<p>Үг хасах</p> <p>1.4 дүгээр зүйлийн 1.25."хангалттай үндэслэл" гэж прокурор, мөрдөгч энэ хуульд заасан шийдвэр гаргахад нөлөөлж байгаа бодит баримтад тулгуурласан нөхцөл үүссэнийг;</p>
1.6 дугаар зүйл.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хууль ёсны байх		
3		<p>Хэсэг нэмэх</p> <p>1.6 дугаар зүйлийн 7.Бусад хуульд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэм хэмжээ туссан бол тухайн хуулийн холбогдох заалтыг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахад дагаж мөрдөнө.</p>
		<p>Шүүх хэргийн бодит байдлыг талуудын мэтгэлцээний үндсэн дээр тогтооно гэж эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үндсэн зарчим болгон хуульд тусгасан билээ. Гэвч мэтгэлцээнээс өмнөх ажиллагааны шатанд “хангалттай үндэслэл” бүрдсэн шалтгаанаар оролцогчдын хүсэлтийг хүлээн авахаас татгалздаг. Энэ нь шүүгдэгчийн шударгаар шүүлгэх, шүүхийн өмнө тэгш байх зарчимд үл нийцдэг. Хангалттай үндэслэл гэсэн хэсгээс шүүх гэсэн хэсгийг хасахаар тусгав. Энэ нь дээр дурдсанчлан шүүх нь бодит байдлыг талуудын тэгш мэтгэлцээний үндсэн дээр тогтоох зарчимд нийцэх юм.</p> <p>Хуулийн 1.6-р зүйлийн 1-д эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахдаа Үндсэн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, бусад хуулийн заалтыг чанд сахих тухай заасан. Зарим тохиолдолд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх харилцааг өөр хуульд зохицуулсан байдаг. Жишээ нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 35.2-т гэмт үйлдлийнх нь явцад, эсхүл хэргийн болон зөрчлийн газарт нотлох баримттай нь баривчилснаас бусад тохиолдолд нэр дэвшигчид холбогдуулан СЕХ-ны зөвшөөрөлгүйгээр эрүүгийн хэрэг хянан</p>

			<p>шийдвэрлэх ажиллагаа явуулахыг хориглох талаар заасан байдаг. Гэвч зарим тохиолдолд шүүхээс бусад хуульд заасан зохицуулалтыг зөвшөөрдөггүй. Тухайлбал 2020 оны УИХ-ын сонгуулийн сурталчилгааны явцад зарим нэр дэвшигчдийг СЕХ-ны зөвшөөрөлгүйгээр цагдан хорьж байсан билээ. Тиймээс энэ харилцааг тодорхой болгох, тодруулбал эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд бусад хуулийн заалтыг хэрэглэж болохыг тодруулан тусгав.</p>
<p>1.7 дугаар зүйл.Хэргийн бодит байдлыг тогтоох</p>			
4	<p>1.7 дугаар зүйлийн 2.Хэргийн бодит байдлыг нотлохын тулд мөрдөгч, прокурор хуульд заасан бүх арга хэмжээг авч яллагдагч, шүүгдэгчийг яллах, цагаатгах, ял хүндрүүлэх, хөнгөрүүлэх нөхцөл байдлыг эргэлзээгүй тогтооно.</p>	<p>Үг нэмэх</p> <p>1.7 дугаар зүйлийн 2.Хэргийн бодит байдлыг нотлохын тулд мөрдөгч, прокурор хуульд заасан бүх арга хэмжээг авч <b>сэжигтэн</b>, яллагдагч, шүүгдэгчийг яллах, цагаатгах, ял хүндрүүлэх, хөнгөрүүлэх нөхцөл байдлыг эргэлзээгүй тогтооно.</p>	<p>Хэргийн бодит байдлыг нотлох ажиллагаа нь зөвхөн яллагдагч, шүүгдэгчид бус сэжигтэнд мөн хамааралтай. Ялангуяа сэжигтэн этгээд гэмт хэрэг үйлдсэн этгээд мөн эсэхийг тогтоож яллах нөхцөл байдлыг тогтооход онцгой хамааралтай. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хууль тогтоомжийн практик хэрэгцээ шаардлагын улмаас сэжигтэн гэх ойлголтыг хуульчлах зайлшгүй нөхцөл бүрдэж хуульчилсан байдаг. Тиймээс энэ хэсэгт сэжигтэн гэж нэмэхээр төсөлд тусгав.</p>
5		<p>Хэсэг нэмэх</p> <p>1.7 дугаар зүйлийн 5.Өмгөөлөгч хэргийн бодит байдлыг тогтооход шаардлагатай ажиллагааг энэ хууль, Өмгөөллийн тухай хуульд</p>	<p>Хэргийн бодит байдлыг тогтоох үүрэг хуулиар мөрдөгч, прокурорт байхаар заасан ба шүүх зөвхөн талуудын мэтгэлцээний үндсэн дээр хэргийн бодит байдлыг тогтооно гэж хуулийн 1.7-р зүйлд заасан. Энэ нь хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог зарчим юм. Харин хуульд хэргийн бодит байдлыг тогтооход өмгөөлөгчийн оролцоо хязгаарлагдмал байгааг өөрчилж илүү</p>

		заасан эрхийн хүрээнд явуулах эрхтэй.	идэвхтэй байлгах шаардлагатай үүднээс энэхүү заалтыг нэмэлтээр оруулахаар тусгав.
6		<p>Хэсэг нэмэх</p> <p>1.7 дугаар зүйлийн 6.Мэтгэлцэх зарчим хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүхийн бүх шатанд хэрэгжинэ.</p>	<p>Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 8.1, 8.2-т шүүн таслах ажиллагааг мэтгэлцэх зарчмын үндсэн дээр явуулна гэж заасан ба харин шүүх прокурор ба оролцогчийг мэтгэлцэх эрхээ хэрэгжүүлэх боломжоор тэгш хангана гэж заасан байдаг бол 8.3 дахь хэсэгт “Шүүх хуралдааны үеэр мэтгэлцэх журмыг хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх холбогдох хуулиар зохицуулна.” гэж заасан.</p> <p>Харин мэтгэлцэх зарчим хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх шатанд хэрэгжих талаар Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.2, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.2-т тус тус заасан байдаг бол энэ талаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд орхигдсон байдаг. Хүн бүр хэргийн харьяаллаас үл хамаараад хууль шүүхийн өмнө эрх тэгш байх нь Үндсэн хуулийн зарчим. Тиймээс мэтгэлцэх зарчим хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх шатанд хамаарах талаар төсөлд нэмж тусгав.</p>
1.11 дүгээр зүйл.Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны мэдээллийг хамгаалах			
7	1.11 дүгээр зүйлийн 1.Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны мэдээллийг хуулиар	<p>Үг нэмэх</p> <p>1.11 дүгээр зүйлийн 1.Иргэний хувийн ба гэр бүл, захидал,</p>	Орчин үед техник технологи хөгжихийн хэрээр идэвхтэй харилцааны шинэ хэлбэрүүд үүссээр байгаагийн тод жишээ нь нийгмийн цахим сүлжээ, төрөл бүрийн цахим хэрэгслүүд юм.

	хамгаалах ба энэхүү эрхийг зөвхөн хуульд заасан үндэслэл, журмын дагуу хязгаарлаж болно.	<b>цахим хэрэгсэл, цахим харилцааны</b> мэдээллийг хуулиар хамгаалах ба энэхүү эрхийг зөвхөн хуульд заасан үндэслэл, журмын дагуу хязгаарлаж болно.	Түүгээр дамжиж иргэд асар их харилцаанд ордог болсон ба хувийн мэдээллүүд ч цахим хэрэгсэлд, интернэт сүлжээнд хадгалагдах болсон. Тиймээс хувийн мэдээлэл агуулдаг цахим хэрэгсэл болон цахим харилцааны мэдээллийг иргэний хувийн, гэр бүлийн, захидал харилцааны нууцад хамруулан хамгаалах зайлшгүй шаардлагатай болсон. Цаашлаад тухайн нотлох баримт нь зарим төрлийн гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай эсэхийг шийдвэрлэхэд онцгой нөлөөлдөг. Тиймээс мөрдөн шалгах ажиллагааны явцад тухайн баримт шаардлагатай бол хуулиар тогтоосон журмын дагуу олж авах нь хүний шударгаар шүүлгэх эрхэд нийцнэ гэж үзэв.
<b>3.1 дүгээр зүйл. Шүүх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх</b>			
8	3.1 дугаар зүйлийн 3. Хяналтын шатны шүүх хуралдаанаар гомдол, эсэргүүцлийн дагуу шүүх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд Эрүүгийн хуулийг зөв хэрэглэсэн эсэх, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэнэ.	Өгүүлбэр нэмэх 3.1 дугаар зүйлийн 3. Хяналтын шатны шүүх хуралдаанаар гомдол, эсэргүүцлийн дагуу шүүх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд Эрүүгийн хуулийг зөв хэрэглэсэн эсэх, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн эсэх, <b>Үндсэн хуулиар баталгаажсан хүний үндсэн эрх, эрх чөлөө зөрчигдсэн эсэх</b> маргааныг хянан шийдвэрлэнэ.	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх үе шатанд буюу хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүн хэлэлцэх шатанд Үндсэн хуулиар баталгаажсан иргэний үндсэн эрхийн баталгааг хангах шаардлага зүй ёсоор тулгарч байна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь хүний эрхийг хязгаарлахад тулгуурлан явагддаг. Тиймээс эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх үе шатанд хүний үндсэн эрхийн баталгааг хангах үүднээс хүний үндсэн эрхийн баталгаа хяналтын шатны шүүхийн хяналтад байхаар энэ хэсэгт тусгав. Ингэснээр Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхол хоосон тунхаглал төдий бус байх боломж бүрдэх ба

			мөрдөгч, прокурор, шүүгч ажиллагаа тутамдаа хүний үндсэн эрхийг ханган ажиллах болно.
3.2 дугаар зүйл.Шүүх хуралдааныг нээлттэй, хаалттай явуулах			
9		<p>Хэсэг нэмэх</p> <p>3.2 дүгээр зүйлийн 4.Энэ хуулийн 29.2 дугаар зүйлд заасны дагуу хэд хэдэн үйлдэл буюу хэргийг нэгтгэсэн хэргийн зарим нь хаалттай явуулах шүүх хуралдаанд хамаарч байгаа бол хаалттай явуулахаас бусад хэргийг шүүх хуралдааны хэлэлцүүлгийг нээлттэй явуулна.</p>	<p>Шүүх хуралдааны үндсэн зарчим нь нээлттэй явагдах бөгөөд хуульд заасан тохиолдолд шүүх хуралдааныг хаалттай явуулдаг. Харин хаалттай явуулах хэргээр шалтгаалан (шалтаглан) нээлттэй шүүх хуралдааныг хаалттай явуулах нь шүүх нээлттэй байх зарчимд нийцэхгүй. Тиймээс хэд хэдэн хэрэг нэгтгэж шийдвэрлэж байгаа хаалттай явагдах хэргийн хэлэлцүүлгийг зөвхөн хаалттай, бусад буюу нээлттэй явагдах хэргийн хэлэлцүүлгийг нээлттэй явагддаг байхаар төсөлд тусгав.</p>

4.2 дугаар зүйл.Прокурорын үүрэг

10		<p>Хэсэг нэмэх</p> <p>4.2 дугаар зүйлийн 3.Прокурор нь оролцогчийн хүсэлт, гомдлын үндэслэл тус бүрийг хянан шалгаж шийдвэрлэх үүрэгтэй.</p>	<p>Прокурор нотлох баримтыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор шалгаж хянасны үндсэн дээр хэргийн бодит байдлыг тогтоох үүрэгтэй гэж хуулийн 1.7-р зүйлийн 1-д заасан. Прокурорын энэхүү үүрэг нь оролцогчийн мөрдөн шалгах ажиллагааны явцад гаргасан хүсэлт, саналд хэрхэн хандах, хэрхэн шийдвэрлэхэд илүү хамааралтай байдаг. Учир нь оролцогч, түүний өмгөөлөгч бие даан мөрдөн шалгах ажиллагаа явуулах хууль эрх зүйн зохицуулалт одоогийн байдлаар манай улсын хууль тогтоомжид байхгүй бана. Тиймээс прокурорын энэхүү үүргийг тодорхой болгох үүднээс оролцогчийн хүсэлтийн үндэслэл бүрийг хянах, шийдвэрлэж байхаар төсөлд тусгав. Энэ нь хүний шударгаа шүүлгэх үндсэн эрхийг хангахад онцгой ач холбогдолтой юм.</p>
----	--	--	---

5.1 дүгээр зүйл.Өмгөөлөгчийн эрх, үүрэг

11	<p>5.1 дүгээр зүйлийн 2.2.хохилогч, шинжээчээс авахуулахаар гаргах;</p> <p>зүйлийн гэрч, мэдүүлэг хүсэлт</p>	<p>Өгүүлбэр нэмэх</p> <p>5.1 дүгээр зүйлийн 2.2.хохилогч, гэрч, шинжээчээс мэдүүлэг авахуулахаар хүсэлт гаргах, <b>түүнчлэн хэргийн байдлыг нэмж тодруулах үүднээс урьд мэдүүлэг өгсөн хохилогч, гэрч, шинжээчээс</b></p>	<p>Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаа нь зөвхөн нэг талын ажиллагаа гэж үзэх нь ерөөсгөл ойлголт болно. Өөрөөр хэлбэл хэргийн бодит үнэнийг тогтоох нь мөрдөгч, прокуророос гадна гэмт хэрэгт буруутгагдаж байгаа талын өмгөөлөгчид мөн хамааралтай юм. Энэ нь шүүх хэргийн бодит байдлыг талуудын мэтгэлцээний үндсэн дээр тогтоох зарчим хэрэгжих чухал үндэслэл болдог. Тиймээс өмгөөлөгч нь</p>
----	--	---	--

		<b>нэмж мэдүүлэг авахуулахаар хүсэлт гаргах, тэдгээрээс асуух асуултаа урьдчилан тодорхойлох;</b>	мэдүүлэг авахуулахаар хүсэлт гаргахаас гадна урд мэдүүлэг өгсөн этгээдээс асуугдаагүй үлдсэн байж болох асуулт, нэмж тодруулах шаардлагатай гэж үзсэн зүйлээ тодруулахаар хүсэлт гаргах эрхийг өмгөөлөгчид олгох байдлаар төсөлд тусгав.
12	5.1 дүгээр зүйлийн 2.8.өөрсдийнх нь зөвшөөрснөөр хүн, хуулийн этгээдээс хэрэгт ач холбогдол бүхий тайлбар, баримт бичиг, лавлагаа, тодорхойлолт гаргуулж авах;	Үг нэмэх 5.1 дүгээр зүйлийн 2.8.өөрсдийнх нь зөвшөөрснөөр хүн, хуулийн этгээдээс хэрэгт ач холбогдол бүхий тайлбар, баримт бичиг, лавлагаа, тодорхойлолт, дүгнэлт гаргуулж авах, <b>шүүх хуралдаанд дуудан оролцуулах;</b>	Өмгөөлөгч мөрдөх чиг үүргийг хүлээдэггүй тул хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ямар нэг албадлагын үйл ажиллагаа явуулдаггүй. Харин хууль, шүүхийн өмнө талуудын тэгш эрхийн хүрээнд тодорхой этгээдээс өөрийнх нь зөвшөөрснөөр нотлох ажиллагаа явуулах боломж нь нээлттэй байдаг. Энэ ч үүднээс өөрсдийнх нь зөвшөөрснөөр хүн, хуулийн этгээдээс хэрэгт ач холбогдол бүхий тайлбар, баримт бичиг, лавлагаа, тодорхойлолт гаргуулах эрхтэй байхаар хуульд заасан байдаг. Энэхүү зохицуулалтыг илүү тодруулан өөрийнх нь зөвшөөрснөөр гэдэгт гэрч, шинжээчийг нэмж оруулан, дүгнэлт гаргуулах, шүүх хуралдаанд дуудан оролцуулах талаар төсөлд нэмж тусгав. Энэ нь хэргийн бодит байдлыг мэтгэлцээний үндсэн дээр тогтоох үндсэн зарчим хэрэгжихэд чухал ач холбогдолтой гэж үзлээ.
13	2.16.энэ хуульд заасан бусад эрх	Үг нэмэх 5.1 дүгээр зүйлийн 2.16. <b>Өмгөөллийн тухай хууль болон энэ хуульд заасан бусад эрх.</b>	Өмгөөллийн тухай хуулийн зорилт нь иргэдийн хууль зүйн туслалцаа авах, өмгөөлөгчийн эрх, үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршдог. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд Өмгөөллийн тухай хуулийг хэрэгжүүлэх, өмгөөлөгчийн үйл ажиллагааны баталгааг хангах үүднээс өмгөөлөгч нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх

			ажиллагаанд Өмгөөллийн тухай хуульд заасан эрхийг мөн эдэлдэг байхыг тодруулан төсөлд тусгав.
5.4 дүгээр зүйл.Өмгөөлөгчийн үйл ажиллагаа явуулах баталгаа			
14		Хэсэг нэмэх  5.4 дүгээр зүйлийн 3.Өмгөөллийн үйл ажиллагаанд хууль бусаар санаатайгаар саад учруулахыг хориглоно.	Өмгөөллийн үйл ажиллагааны зорилго нь бусдын эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад оршдог. Энэхүү үйл ажиллагаанд хууль бусаар саад болохыг аливаа этгээдэд хориглохоор төсөлд тусгав.
7.1 дүгээр зүйл.Яллагдагч			
15	7.1 дүгээр зүйлийн 2.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа шүүгдэгчид энэ бүлэгт заасан эрх, үүрэг нэгэн адил хамаарна.	Үг нэмэх  7.1 дүгээр зүйлийн 2.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа <b>сэжигтэн</b> , шүүгдэгчид энэ бүлэгт заасан эрх, үүрэг нэгэн адил хамаарна.	2017 онд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг шинэчилсэн найруулгаар хэлбэрээр шинээр батлахад “сэжигтэн” гэх ойлголтыг үндсэнд хасаж зохицуулсан. Гэвч хууль хэрэглээний явцад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтад “сэжигтэн” гэх ойлголт зайлшгүй байх шаардлагатайг практик хэрэглээ нотолдог. Тухайлбал илтэд гэмт хэрэг үйлдсэн байж болзошгүй этгээдийг сэжигтэн гэх ойлголт хууль байхгүйн улмаас гэрчээр мэдүүлэг авах тохиолдолд маш их гарсан. Энэ ч агуулгаар сэжигтэн гэх ойлголтыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өргөн агуулгатайгээр нэмэлтээр оруулсан ба сэжигтний эрхэд шүүгдэгч, яллагдагчийн эрх хамаарахгүй гэж

			үзсэн учир энэ зохицуулалтад сэжигтэн гэсэн үг нэмэхээр төсөлд тусгав.
7.3 дугаар зүйл.Ямар хэрэгт яллагдаж байгаагаа мэдэх			
16		Хэсэг нэмэх  7.3 дугаар зүйлийн 6.Нотлох баримт шалгуулах хүсэлтээ энэ хуулийн 16.15-р зүйлийн 3 дахь хэсэгт заасан журмын дагуу шалгуулах эрхтэй.	Энэ зүйлд нотлох баримтыг шалгуулах эрхийг хэрхэн хангах талаар мөн тусгав. Нотлох баримтыг шалгуулах эрх Үндсэн хуулиар баталгаажсан хэдий ч уг хүсэлтийн дагуу нотлох баримтыг хэрхэн шалгах талаар хуульд тусгаагүй байсныг тодруулан яллагдагчийн эрх болгон төсөлд тусгалаа.
7.4 дүгээр зүйл.Мэдүүлэг өгөх, өгөхөөс татгалзах			
17	7.4 дүгээр зүйлийн 1.Яллагдагч эх хэлээрээ болон өөрийн сайн мэдэх хэлээрээ мэдүүлэг өгөх, орчуулагч, хэлмэрч авах, мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхтэй.	Үг нэмэх  7.4 дүгээр зүйлийн 1.Яллагдагч эх хэлээрээ болон өөрийн сайн мэдэх хэлээрээ мэдүүлэг өгөх, орчуулагч, хэлмэрч авах, мэдүүлэг өгөхөөс татгалзах, <b>дуугүй байх</b> эрхтэй.	Үндсэн хуулийн 16-р зүйлийн 14-т заасан “өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх” эрх нь дуугүй байх, мэдүүлэг өгөхгүй байх эрхийн үндэс болдог. Учир нь бүх хүн эрх зүйн мэдлэгтэй байх боломжгүй ба ямар мэдүүлэг нь өөрийнх нь эсрэг гэр бүлийн гишүүдийн эсрэг ашиглагдаж болохыг урьдчилан мэдэх боломжгүй. Тиймээс олон улсад дуугүй байх эрхийг баталгаажуулдаг. Энэ талаар Мирандагийн гэх зарчим байдаг. Энэ нь өмгөөлөгч авах, өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг нь танилцуулаагүй байцаалтын эцэст Э.Миранда гэх этгээдээс авсан мэдүүлгээс үүсэлтэй. Тэрээр хэргээ

			хүлээсэн хэдий ч мэдүүлэг нь хүний эрхийг зөрчсөн гэж үзэн түүний мэдүүлгийг хүчингүйд тооцсон АНУ-ын дээд шүүхийн шийдвэрээс улбаалж олон улсад үүссэн Мирандагийн зарчим юм. Тиймээс яллагдагчийн эрхэд түүний дуугүй байх эрх, мэдүүлэг өгөхгүй байх эрхийг баталгаажуулан төсөлд тусгав.
18		<p>Хэсэг нэмэх</p> <p>7.4 дүгээр зүйлийн 4.Дараахь тохиолдолд яллагдагчийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулсан гэж үзэх үндэслэл болохгүй:</p> <p>4.1. мэдүүлэг өгөхөөс татгалзах, дуугүй байх эрх болон хуульд заасан бусад эрхээ эдэлсэн;</p> <p>4.2.Энэ хуульд заасан журмыг зөрчихгүйгээр яллагдагч өөрийгөө өмгөөлөх нотлох баримт хайсан, цуглуулсан, бүрдүүлсэн.</p>	<p>Үндсэн хуулийн 16-р зүйлийн 14-т зааснаар иргэн өөрөө өөрийгөө өмгөөлөх үндсэн эрхтэй. Өөрийгөө өмгөөлөх эрх нь хүн өөрийн эрх ашгийг хамгаалах, хууль зүйн асуудалд өөрийгөө төлөөлөх, өөрийн эрх, ашиг сонирхлыг тодорхойлох, хэргийн бодит байдлыг тогтооход дэмжлэг үзүүлэх, мэтгэлцэх зэргээр хүн хуульд заасан эрх, боломжоо эдлэхийг ойлгох гэм мэтээр хэрэгжинэ. Тиймээс яллагдагч болсон иргэн өөрийгөө өмгөөлөх эрхээ эдэлж байгааг түүний буруутгах үндэслэл болгож болохгүй юм. Учир нь хуульд заасан эрх нь хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг дордуулах бус хамгаалахад чиглэнэ. Тиймээс яллагдагч эрхээ эдэлсэн нь түүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг дордуулах үндэслэл болохгүй талаар төсөлд тусгав. Энэ нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүний эрхийг хангахад чухал ач холбогдолтой гэж үзэв.</p>
9.1 дүгээр зүйл.Шинжээч			

19		<p>Хэсэг нэмэх</p> <p>9.1 дүгээр зүйлийн 6.Өмгөөлөгч нь Шүүх шинжилгээний тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан шинжилгээ хийх эрх бүхий бусад этгээдийн өөрийнх нь зөвшөөрснөөр шинжилгээ хийлгэж болно.</p>	<p>Нэг талын буюу яллах талын бүрдүүлсэн нотлох баримт, тухайлбал тэр талын сонгосон шинжээчийн дүгнэлтийг үндэслэн бодит байдлыг тогтоох нь “хэргийн бодит байдлыг талуудын мэтгэлцээний үндсэн дээр тогтоох зарчим”-д харш юм. Тиймээс төрийн шинжилгээний байгууллагаас бусад шинжилгээ хийх боломжтой эрх бүхий этгээдээс өөрийнх нь зөвшөөрлөөр шинжилгээ хийлгэх, шинжээчийн дүгнэлт гаргуулах эрхийг өмгөөлөгчид олгон төсөлд тусгав. Энэ нь шүүхийн өмнө талууд тэгш эрхтэйгээр мэтгэлцэх боломжийг нээж өгч байгаа харилцаа юм.</p>
9.6 дугаар зүйл.Гэрч			
20		<p>Хэсэг нэмэх</p> <p>9.6 дугаар зүйлийн 9.Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч тухайн хэрэгт урьд гэрчээр мэдүүлэг өгсөн бол түүний гэрчийн мэдүүлгийг нотлох баримтаар тооцохгүй бөгөөд хавтаст хэргийн материалаас хасна.</p>	<p>Хүн өөрийнхөө болон гэр бүлийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхтэй. Гэрч бол зөвхөн үнэнийг мэдүүлэх, худал хэлбэл хариуцлага хүлээдэг. Харин сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч нь ийм үүрэг хүлээдэггүй, хэргийн байдлыг нотлох ч үүрэггүй. Гэтэл түүнээс урьд авсан гэрчийн мэдүүлэг нь гэмт хэргийн байдлыг нотлох шинж чанартай болдог учир нь яллагдагчийн эрх зүйн байдлыг дордуулах боломжтой. Тиймээс яллагдагч урд нь гэрчийн мэдүүлэг өгсөн бол уг мэдүүлгийг нотлох баримтаар тооцохгүй байж хэргийн материалаас хасахаар төсөлд тусгав.</p>

10.2 дугаар зүйл.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүгч дахин оролцож болохгүй үндэслэл

21		<p>Хэсэг нэмэх</p> <p>10.2 дугаар зүйлийн 4.Эрүүгийн хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэхэд оролцсон шүүгч шийдвэр хүчингүй болсны улмаас уг хэргийг дахин анхан шатны журмаар хянан шийдвэрлэхэд оролцож болохгүй.</p>	<p>Шүүгч хараат бус, хөндлөнгийн байх нь шударга шүүхийн үндсэн зарчим. Улмаар шүүгч өөрийн дотоод итгэлээр нотлох баримтаар үнэлж, маргаан бүхий үйл баримтыг тогтоон хуульд захирагдан хэрэг маргааныг шийдвэрлэдэг. Нэгэнт тодорхой хэрэг маргааныг анхан шатны шүүхийн шүүгч өөрийн дотоод итгэлээр үнэлж шийдвэрлэсэн боловч хүчингүй болсны улмаас тухайн хэлэлцэх үед тухайн шүүгч тухайн хэрэг маргааны өөрөө дахин “шинээр шүүх” нь тухайн шүүгч өөрийн дотоод итгэлтэй зөрчилдөх нөхцөл үүсэж болзошгүй байдаг. Тодруулбал урьдын дотоод итгэлээ дагах уу, эсхүл дээд шатны шүүхийн шийдлийг дагах уу зэрэг асуудал үүсэж болзошгүй ба энэ нь шүүгчийн хараат бус байдалд ч нөлөөлж болох эрсдэл үүсгэдэг. Тиймээс анхан шатын шүүхийн шийдвэр хүчингүй болсны улмаас дахин хэлэлцэх бол тухайн хэрэг маргааны урьд шийдвэрлэсэн шүүгч дахин шийдвэрлэж болохгүй талаар төсөлд тусгалаа.</p> <p>Энэ талаар Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 84.1-д “Дараахь үндэслэл байвал шүүгч хэрэг хянан шийдвэрлэхэд үл оролцох ба өөрөө татгалзан гарах үүрэгтэй: 84.1.6.анхан болон давж заалдах журмаар хэргийг хянан шийдвэрлэхэд оролцсон шүүгч уг хэргийг тухайн шатны журмаар хянан</p>
----	--	---	--

			шийдвэрлэхэд дахин оролцох болсон.” гэж заасан байдаг.
10.3 дугаар зүйл.Шүүгчийг татгалзан гаргах			
22		<p>Хэсэг нэмэх</p> <p>10.3 дугаар зүйлийн 3.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгч захирамж, шүүх бүрэлдэхүүн тогтоол гаргасан нь шүүгчийг татгалзан гаргах үндэслэл болохгүй.</p> <p>4. Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасныг зөрчиж гаргасан шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг татгалзан гаргах хүсэлтийг гаргаагүйд тооцон, шүүх хуралдааныг үргэлжлүүлнэ.</p>	<p>Үндсэн хуулийн 47-р зүйлийн 1-д зааснаар Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ гэсэн. Энэхүү эрх мэдэл нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад болон хэргийг хянан шийдвэрлэж шүүх бүрэлдэхүүн шийдвэр (захирамж, тогтоол, шийдвэр) гаргахыг ойлгодог. Харин шийдвэр хууль тогтоомжид нийцээгүй, хүний эрхийг зөрчсөн бол давж заалдах журмаар шүүхийн шийдвэр хүчингүй болох, өөрчлөгдөх боломжтой байдаг. Энэ нь шүүх эрх мэдлийн үндсэн зарчим юм. Тиймээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгч, шүүх бүрэлдэхүүн шийдвэр гаргасныг шүүх эрх мэдлийг хэрэгжүүлж байгаатай утгачлан ойлгож болох тул эрх мэдлээ хэрэгжүүлсэн нь тухайн шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг татгалзан гаргах үндэслэл болохгүй талаар төсөлд тусгав.</p>
11.11 дүгээр зүйл.Эрүүгийн хэргийн хавтаст хэрэг			
23		Хэсэг нэмэх	Мөрдөгч, прокурор нотлох баримтыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор шалгах чиг үүргийн

		<p>11.11 дүгээр зүйлийн 7. Мөрдөгч, прокурор энэ хуулийн 1.7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан арга хэмжээг авахдаа яллах болон цагаатгах нотлох баримтыг хавтаст хэрэгт тус тусад нь тусгана.</p>	<p>хүрээнд цагаатгах болон яллах баримт цуглуулан хянасны үндсэн дээр хэргийн бодит байдлыг тогтоох хуулиар тогтоосон үүрэгтэй байдаг билээ. Харин мөрдөн шалгах ажиллагааны явцад олдсон цагаатгах баримтыг хэрхэн хавтаст хэрэгт тусгах талаар хуульд зохицуулсан хэм хэмжээ байдаггүй. Үүний улмаас цагаатгах ба яллах баримт хавтаст хэрэгт холилдох, ач холбогдох л яллах баримтад дарагдах, бүдгэрэх мэт үр дагавар үүсдэг. Тиймээс мөрдөн шалгах ажиллагааны явцад мөрдөгч, прокурор нь дотоод итгэлийн хүрээнд баримтыг үнэлэх эрхийн хүрээнд үнэлж цагаатгах ба яллах баримтыг тус тусад нь тусган хавсаргах талаар төсөлд тусгав.</p>
24		<p>Хэсэг нэмэх</p> <p>11.11 дүгээр зүйлийн 8.Таслан сэргийлэх арга хэмжээ авахтай холбоотой хэргийн материалыг эрүүгийн хэргийн бусад материалаас тусад нь эрүүгийн хавтаст хэрэгт хавсаргана.</p>	<p>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь таслан сэргийлэх арга хэмжээний зорилго, түүний зориулалт нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хэвийн, шуурхай явагдахад бодитойгоор саад учруулж буй, эсхүл саад учруулж болзошгүй яллагдагч, шүүгдэгчийн үйлдлийг гаргуулахгүй байх, тэдгээрээс урьдчилан сэргийлэх, түүнчлэн хуулийг үндэслэлтэй, шударгаар хэрэгжүүлэх явдлыг хангахад чиглэгддэг. Өөрөөр хэлбэл таслан сэргийлэх арга хэмжээ авах үндэслэл болсон үйл баримт нь тухайн эрүүгийн хэрэгт шалгаж байгаа үйлдэл, эс үйлдэхүй /гэмт хэрэг/-д хамааралгүй юм. Тиймээс хоорондоо шууд хамааралгүй тусдаа үйл баримтыг нотолж байгаа баримт мэдээллийг холихгүйгээр тусад</p>

			нь зааглан эрүүгийн хэрэгт хавсаргаж байхаар төсөлд тусгав.
15.1 дүгээр зүйл.Хүсэлт, гомдол гаргах			
25		<p>Хэсэг нэмэх</p> <p>15.1 дүгээр зүйлийн 3.Нэгжих болон эд хөрөнгө битүүмжлэх талаарх мөрдөгч, прокурорын шийдвэр үйл ажиллагаанд гаргасан гомдлыг хянан шийдвэрлэсэн дээд шатны прокурорын шийдвэрийг эс зөвшөөрвөл эрх, хууль ёсны ашиг сонирхлоо зөрчигдсөн гэж үзэж байгаа хүн, хуулийн этгээд шүүхэд гомдол гаргах эрхтэй.</p>	<p>Үндсэн хуулийн 16-р зүйлд “Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч <b>нэгжих</b>, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно.” гэж заасан байдаг ба баривчлах, хорих, эрх чөлөөг нь хязгаарлах асуудлыг зөвхөн шүүх шийдэхээр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан байдаг. Харин нэгжих, эд хөрөнгө битүүмжлэх шийдвэрийг прокурор гаргаж, прокурорт эцэслэн шийдвэрлэх зохицуулалттай байсаар байна. Прокурор нь аливаа асуудлыг шийдэхэд талуудыг оролцуулдаггүй, хэлэлцүүлэг, хуралдаан, мэтгэлцээн явуулахгүйгээр шийддэг бол шүүх мэтгэлцэх зарчмаар асуудлыг шийддэг. Нөгөө талаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж үзсэн этгээд шүүхэд гомдол гаргах эрхтэй талаар Үндсэн хуульд, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан хэдий ч нэгжих, эд хөрөнгө битүүмжлэх прокурорын шийдвэрт гомдол гаргах эрх зүйн зохицуулалт байхгүй. Тиймээс нэгжих, эд хөрөнгө битүүмжлэх шийдвэр хууль зөрчсөн гэж үзвэл шүүхэд гомдол гаргах эрхтэй байхаар төсөлд тусгав.</p>
15.4 дүгээр зүйл.Хүсэлтийг шийдвэрлэх			

26	<p>Хэсэг нэмэх</p> <p>15.4 дүгээр зүйлийн 3. Тухайн хэрэгт хамааралтай хуульд заасны дагуу цуглуулж, бэхжүүлсэн нотлох баримт нь хэргийг хянан шийдвэрлэхэд хангалттай эсэх нь оролцогчийн нотлох баримт гаргуулах, мөрдөн шалгах ажиллагаа явуулах тухай хүсэлтийг шийдвэрлэхээс татгалзах үндэслэл болохгүй.</p>	<p>Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гэм буруугийн талаар хөдөлбөргүй үнэн гэж урьдчилан тогтоосон ямар ч нотлох баримт байж болдоггүй. Хэрэв тийм бол шүүхээс гэм буруутайг нь тогтоогоогүй хэнийг ч гэм буруутайд тооцож үл болох зарчимд нийцэхгүй. Тиймээс хэрэгт нотлох баримт байгаа нь өөр бусад нотлох баримт байгаа, хангалттай эсэх нь оролцогчийн гаргасан хүсэлт, гомдлыг шийдвэрлэхээс татгалзах үндэслэл болохгүй гэж төсөлд тусгав.</p>
<p>15.7 дугаар зүйл. Мөрдөгч, прокурорын шийдвэр, ажиллагаанд гаргасан гомдлыг хянах</p>		
27	<p>Хэсэг нэмэх</p> <p>15.7 дугаар зүйлийн 6. Дараах шийдвэр, үйл ажиллагаанд гаргасан гомдлыг шийдвэрлэсэн дээд шатны прокурорын шийдвэрийг эс зөвшөөрвөл эрх, хууль ёсны ашиг сонирхлоо зөрчигдсөн гэж үзэж байгаа хүн, хуулийн этгээд шүүхэд гомдол гаргах эрхтэй:</p> <p>6.1. нэгжих;          6.2. эд хөрөнгө битүүмжлэх;          6.3. хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан, хэрэг</p>	<p>Үндсэн хуулийн 16-р зүйлд “Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно.” Гэж заасан байдаг. Энэ заалтаас баривчлах, хорих, эрх чөлөөг нь хязгаарлах асуудлыг зөвхөн шүүх шийдэхээр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан байдаг.</p> <p>Харин нэгжих, эд хөрөнгө битүүмжлэх шийдвэрийг прокурор гаргаж, прокурорт эцэслэн шийдвэрлэх зохицуулалттай байсаар байна. Прокурор нь аливаа асуудлыг шийдэхэд талуудыг оролцуулдаггүй, хэлэлцүүлэг, хуралдаан, мэтгэлцээн явуулахгүйгээр шийддэг бол шүүх мэтгэлцэх зарчмаар асуудлыг</p>

		<p>бүртгэлтийн хэргийг хаасан 6.4.эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон.</p> <p>Хэсэг нэмэх</p> <p>7.Энэ зүйлийн 6 дахь хэсэгт заасны дагуу гаргасан гомдлыг шүүх хүлээн авсан өдрөөс хойш 7 хоногийн дотор прокурор, оролцогчийг байлцуулж шүүгч дангаар захирамж гарган шийдвэрлэнэ.</p> <p>Хэсэг нэмэх</p> <p>8. Энэ зүйлийн 6 дахь хэсэгт заасны дагуу гаргасан гомдлыг хэлэлцэхэд энэ хуульд заасан ердийн журмыг баримтлана.</p> <p>Хэсэг нэмэх</p> <p>9. Энэ зүйлийн 7 дахь хэсэг заасны дагуу гаргасан шүүгчийн захирамжид гомдол гаргахгүй.</p>	<p>шийддэг. Нөгөө талаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсэн гэж үзсэн этгээд шүүхэд гомдол гаргах эрхтэй талаар Үндсэн хуульд, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан хэдий ч нэгжих, эд хөрөнгө битүүмжлэх прокурорын шийдвэрт гомдол гаргах эрх зүйн зохицуулалт байхгүй. Тиймээс нэгжих, эд хөрөнгө битүүмжлэх шийдвэр хууль зөрчсөн гэж үзвэл шүүхэд гомдол гаргах боломжийг нээхээр төсөлд тусгав.</p> <p>Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлэх үндсэн хуультай. Прокурор нь онолын хувьд гүйцэтгэх эрх мэдэлд хамаардаг гэж үздэгч Монгол Улсын Үндсэн хуульд шүүх эрх мэдэл гэсэн бүлэгт прокурор хамаардаг. Гэсэн хэдий ч прокурор шүүх биш учир эрхзүйн маргааныг эцэслэн шийдвэрлэх нь учир дутагдалтай. Өөрөөр хэлбэл хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан, хаасан, эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон прокурорын шийдвэр хэзээ ч шүүхэд хянагдах боломжгүй болж, эрх зүйн хувьд эцсийн шийдвэр болж байна. Харин бусад тохиолдолд ямар нэг хэмжээгээр шүүх мөрдөгч, прокурорын шийдвэрийг процессын хувьд хянах боломжтой байдаг. Тиймээс хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан, хаасан, эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон прокурорын шийдвэрт шүүхэд гомдол гаргах эрхтэй байхаар төсөлд мөн тусгав.</p> <p>Хэрэг үүсгэхээс татгалзсан шийдвэрийг шүүхэд хянаж болдог тогтолцоо нь эрх мэдэл</p>
--	--	--	--

			<p>хуваарилалтын зарчим болон хохирогчийн эрхийг хамгаалах онол дээр тулгуурладаг.</p> <p>Эрх мэдэл хуваарилалтын онол (Separation of Powers)-эрүүгийн эрх зүйн онолд прокурор бол яллах эрх мэдлийг хэрэгжүүлэгч гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага бол шүүх бол шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч, хууль ёсны хяналт тавигч байгууллагад тооцогддог. Хэрэв прокурорын шийдвэрийг зөвхөн прокурорын шатлал дотроо эцэслэгдэж байгаа нь нэг төрийн байгууллагын дотоод хяналт болж, эрх мэдлийн тэнцвэр алдагдах үндэслэл болдог. Тиймээс шүүхийн хяналт оруулснаар хоёр өөр төрийн эрх мэдэл хоорондын харилцан тэнцвэр бий болж, прокурорын шийдвэрийн хууль ёсны байдалд шүүхийн /хуулийн/ хяналт орно гэж үздэг.</p> <p>Түүнчлэн Хохирогчийн эрхийг хамгаалах онол (Victim Protection Theory) буюу хохирогч хэргийн бие даасан оролцогч гэж үздэг онолын ойлголт бий. Хэрэв прокурор “хэрэг үүсгэхгүй” гэж шийдвэл хохирогчийн шударга шүүхээр шүүлгэх эрх (fair trial) шууд хаагддаг. Шүүхэд гомдол гаргах боломж нь хохирогчид төрийн яллах үйл ажиллагаанд оролцох хоёрдогч хаалга (secondary access to justice) нээж өгдөг.</p> <p>Үүнээс гадна “Хяналт, тэнцвэрийн механизм” (Checks and Balances) гэсэн ойлголт байна. Прокурорын шийдвэр бол бодит байдал, нотлох баримт, хууль хэрэглэсэн байдлыг дангараа үнэлдэг субъектив шинжтэй шийдвэр юм. Шүүхийн хяналт орсноор энэ субъектив үнэлгээг</p>
--	--	--	---

			гадны, илүү обектив шинжтэй болно. Энэ нь зөвхөн шударга ёсыг хангахаас гадна иргэдийн хууль сахих байгууллагад итгэх итгэлийг нэмэгдүүлнэ гэж үздэг.
<b>15.8 дугаар зүйл.Шүүхийн шийдвэрт гомдол гаргах</b>			
28	15.8 дугаар зүйлийн 3.Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад шүүгч дангаар гаргасан шийдвэрийн талаархи гомдлыг тухайн шатны шүүхийн Ерөнхий шүүгч, түүний эзгүйд томилсон шүүгч даруй хянан шийдвэрлэнэ. Энэхүү шийдвэр эцсийн байна.	Хэсэг өөрчлөн найруулах  15.8 дугаар зүйлийн 3.Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад шүүгч дангаар гаргасан шийдвэрийн талаархи гомдлыг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногт багтаан тухайн шатны шүүх гурван шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр шийдвэрлэж, дараахь тогтоол гаргана. Энэхүү шийдвэр нь эцсийн байна.	Үндсэн хуулийн 52.1-д “Бүх шатны шүүх хэрэг, маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ.” гэж заасан. .Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад шүүгч дангаар гаргасан шийдвэр нь маргаантай буюу уг шийдвэрт гомдолтой бол оролцогч хуульд заасан үндэслэл журмын дагуу гомдол гаргадаг. Харин одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 15.8 дугаар зүйлийн 3-т зааснаар Ерөнхий шүүгч, түүний эзгүйд томилсон шүүгч хянан шийдвэрлэхээр заасан байдаг нь маргааныг хамтын зарчмаар шийдвэрлэх Үндсэн хуулийн хэм хэмжээнд нийцдэггүй. Тиймээс тухайн маргаантай асуудлыг гурван шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр тухайн шатны шүүх шийдвэрлэхээр төсөлд тусгав.
29		15.8 дугаар зүйлийн 4.Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан гомдлыг хянан шийдвэрлэхэд тухайн шатны шүүхийн бүрэлдэхүүн хүрэлцэхгүй бол тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс тойргийн журмаар томилогдсон шүүгч	Шүүхийн хүний нөөц, зохион байгуулалтаас шалтгаалан зарим анхан шатны шүүхүүд гомдлын шүүх хуралдааныг хийхэд бүрэлдэхүүн хүрэлцэхгүй байх тохиолдол байдаг. Тиймээс энэ тохиолдолд гомдлыг тухайн шүүгчдийн зөвлөгөөнөөс томилогдсон аль нэг шүүгч дангаар шийдвэрлэж болохоор төсөлд тусгав.

		дангаар хянан шийдвэрлэж болно.	
16.1 дүгээр зүйл.Нотлох баримт			
30	<p>16.1 дүгээр зүйлийн 2.Баримтат мэдээлэл нь гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн мэдүүлэг, эд мөрийн баримт, баримт бичиг, шинжээчийн дүгнэлт, мэдүүлэг, мөрдөгчийн магадлагаа, энэ хуульд заасны дагуу бэхжүүлсэн кино ба гэрэл зураг, зураглал, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг, эрх бүхий байгууллагын цахим мэдээллийн сангаас цахим гарын үсгээр баталгаажуулж авсан лавлагаа, тодорхойлолт, ул мөрөөс авсан хэв, мөрдөн шалгах ажиллагааны болон шүүх хуралдааны тэмдэглэл,</p>	<p>Үг нэмэх</p> <p>16.1 дүгээр зүйлийн 2.Баримтат мэдээлэл нь гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн мэдүүлэг, эд мөрийн баримт, баримт бичиг, шинжээчийн дүгнэлт, мэдүүлэг, <b>хүн, хуулийн этгээдийн хэрэгт ач холбогдол бүхий тайлбар, баримт бичиг, лавлагаа, тодорхойлолт,</b> мөрдөгчийн магадлагаа, энэ хуульд заасны дагуу бэхжүүлсэн кино ба гэрэл зураг, зураглал, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг, эрх бүхий байгууллагын цахим мэдээллийн сангаас цахим гарын үсгээр баталгаажуулж авсан лавлагаа, тодорхойлолт, ул мөрөөс авсан хэв, мөрдөн шалгах ажиллагааны болон шүүх хуралдааны тэмдэглэл,</p>	<p>Шүүхийн өмнө мэтгэлцэгч талууд эрх тэгш байх нь нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим. Монгол Улсад эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд мөрдөх, яллах чиг үүрэг бүхий мөрдөгч, прокурор нь идэвхтэй үйл ажиллагаа явуулах, хэргийн бодит байдлыг тогтоох, нотлох үндсэн үүргийг хэрэгжүүлдэг. Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйд шүүгчид энэ үндсэн чиг үүрэг байсан хэдий 2017 оны өөрчлөлтөөс хойш шүүгч нь хөндлөнгийн шинжтэй болж, хэргийн бодит байдлыг талуудын мэтгэлцээний үндсэн дээр тогтоох зарчимд шилжсэн.</p> <p>Хуульд зааснаар өмгөөлөгч нь өөрсдийнх нь зөвшөөрснөөр хүн, хуулийн этгээдээс хэрэгт ач холбогдол бүхий тайлбар, баримт бичиг, лавлагаа, тодорхойлолт гаргуулж авах эрхтэй хэдий ч уул баримтуудыг нотлох баримтад тооцох, нотлох баримтаар үнэлэх эрх зүйн зохицуулалт орхигдсон. Үүний улмаас шүүхийн өмнө талуудын тэгш байдал алдагдах, яллах тал давуу байдалтай болох зэрэг Үндсэн хуулийн зөрчил үүсэх болсон. Тиймээс өмгөөлөгчийн хуульд заасан эрхийн дагуу гаргасан, цуглуулсан</p>

	хүн, хуулийн этгээд, албан тушаалтнаас ирүүлсэн гэмт хэргийн талаархи гомдол, мэдээлэл болон энэ хуульд заасан бусад баримтаар тогтоогдоно.	хүн, хуулийн этгээд, албан тушаалтнаас ирүүлсэн гэмт хэргийн талаархи гомдол, мэдээлэл болон энэ хуульд заасан бусад баримтаар тогтоогдоно.	баримтыг нотлох баримтад тооцохоор төсөлд тусгав.
31	16.1 дүгээр зүйлийн 13.Шүүх, прокурор, мөрдөгч тухайн хэрэгт хамааралтай энэ хуульд заасны дагуу цуглуулж, бэхжүүлсэн нотлох баримтыг хэргийг хянан шийдвэрлэхэд хангалттай эсэхийг бүхэлд нь үнэлнэ.	Хэсэг өөрчлөн найруулах 16.1 дүгээр зүйлийн 13.Прокурор, мөрдөгч тухайн хэрэгт хамааралтай энэ хуульд заасны дагуу цуглуулж, бэхжүүлсэн нотлох баримтыг хэргийг хянан шийдвэрлэхэд хангалттай эсэхийг бүхэлд нь үнэлнэ. Ийнхүү үнэлсэн нь оролцогчоос гаргасан нотлох баримт гаргуулах, өөр бусад мөрдөн шалгах ажиллагаа явуулах хүсэлтийг хангахаас татгалзах үндэслэл болохгүй.	Шударга шүүхийн үндсэн шинж нь аливаа хэрэг маргааныг талуудын тэгш мэтгэлцээн, шүүхийн хэлэлцүүлэг, хууль ёсоор хэрэгт авагдсан нотлох баримтад тулгуурлан, хуульд захирагдан шийдвэр гаргахад оршдог. Харин түүнээс өмнө нотлох баримт хангалттай эсэхийг шүүх нягтлан шийдвэрлэвэл нь шүүхийн өмнөх тэгш байдлыг алдагдуулах, урьдаас хөдөлбөргүй үнэн гэсэн нотлох баримт байж болохгүй гэсэн зарчимд нийцэхгүй юм. Тиймээс энэ хэсэгт шүүх гэснийг хасаж төсөлд тусгав. Түүнчлэн мөрдөгч, прокурор мөрдөн шалгах ажиллагааны явцад нотлох баримт хангалттай эсэхийг бүхэлд нь үнэлж хэргийг дараагийн шатанд шилжүүлэх боломжтой гэж үзсэн хэдий ч энэ нь оролцогчийн нотлох баримт гаргуулах, нэмэлт мөрдөн шалгах ажиллагаа явуулахаас татгалзах үндэслэл болохгүй байхаар төсөлд тусгав. Учир нь мөрдөн шалгах ажиллагаанд оролцогч, түүний өмгөөлөгчийн оролцоо маш хязгаарлагдмал байдаг нөгөө талаас шүүхийн өмнө тэгш байдлыг хангах шаардлагатай гэж үзэн төсөлд тусгав.

32	<p>16.1 дүгээр зүйлийн 14.Нотлох баримтыг шинжлэн судлах явцад хэрэгт ач холбогдолтой, хамааралтай эсэхэд эргэлзэх үндэслэл байвал тухайн нотлох баримтыг шүүх, прокурорын шийдвэрийн үндэслэл болгохгүй.</p>	<p>Үг нэмэх</p> <p>16.1 дүгээр зүйлийн 14.Нотлох баримтыг шинжлэн судлах явцад хэрэгт ач холбогдолтой, хамааралтай эсэхэд эргэлзэх үндэслэл байвал тухайн нотлох баримтыг шүүх, прокурорын шийдвэрийн үндэслэл болгохгүй <b>бөгөөд эргэлзэх үндэслэлээ шүүх, прокурорын шийдвэрт тусгана.</b></p>	<p>Шүүх эрх мэдэл буюу шүүх засаглал нь төрийн бусад эрх мэдлээс (хууль тогтоох, гүйцэтгэх) ялгаатай, өөрийн тусгай чиг үүрэг, зохион байгуулалт, үйл ажиллагааны тусгай зарчимтай бөгөөд шударга ёсыг хэрэгжүүлэх, хүний эрхийг хамгаалах, хангах, сэргээх, хууль ёсыг хангах үндсэн зорилготой. Тиймээс шүүх эрх мэдлийг хэрэгжүүлж байгаа этгээд нь өөрийн гаргасан шийдвэрийн үндэслэлийг зайлшгүй тайлбарлах шаардлагатай байдаг нь тухайн эрх мэдлийн онцлог шинж юм. Монгол Улсын Үндсэн хуулийн хуваарилалтаар шүүх эрх мэдэлд шүүхээс гадна прокурорыг оруулсан байдаг. Тиймээс шүүхээс гадна прокурор ч мөн гаргасан шийдвэрийн үндэслэлээ зайлшгүй тайлбарлан дурдах талаар төсөлд тусгав.</p>
33		<p>Хэсэг нэмэх</p> <p>16.1 дүгээр зүйлийн 16.Шүүх хуралдаанаар шинжлэн судалсан боловч шүүхийн шийдвэрийн үндэслэл болгоогүй бол шалтгааныг шүүхийн шийдвэрт тайлбарлан тусгах үүргийг шүүх хүлээнэ.</p>	<p>Дээр дурдсантай ижил агуулгатай. Шударгаар шүүлгэх, шүүхийн өмнө эрх тэгш байх үндсэн зарчим нь мэтгэлцэгч талууд өөрийн үнэн, зөв гэж үзсэн нотлох баримтыг шүүхийн хэлэлцүүлэгт судлуулж, улмаар шүүхээр үнэлүүлэхэд оршдог. Харин шүүх нь тухайн нотлох баримтыг үнэлэхгүй орхигдуулбал шударгаар шүүлгэх эрх алдагдах бөгөөд нэг талын баримтыг үнэлсэн атлаа нөгөө талын баримтыг үнэлэхгүй орхигдуулах нь эрх тэгш байх зарчимд ч нийцэхгүй. Түүнчлэн тодорхой нэг үйл баримтыг нотолсон баримтууд хэд хэд байгаад тэдгээр нь зөрүүтэй тохиолдолд шүүгч аль нэгийг нь дотоод итгэлийн хүрээнд авч хэргийг шийдэх боломжтой байдаг. Харин бусад баримтыг нь яагаад үгүйсгэсэн, яагаад шүүхийн</p>

			шийдвэрийн үндэслэл болоогүй гэдгийг шүүх тайлбарлан тусгаж байж шударга шүүхийн шинж хангагдана. Тиймээс үгүйсгэсэн тухай үндэслэлээ шийдвэртэй тусгах үүргийг шүүхэд хүлээлгэн төсөлд тусгав.
		Хэсэг нэмэх  16.1 дүгээр зүйлийн 17.Энэ зүйлийн 14, 16 дахь хэсэгт заасан үндэслэл, шалтгааныг прокурор, шүүхийн шийдвэрт тусгаагүй бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчилд тооцно.	Нотлох баримтыг үнэлээгүй орхигдуулсан бол түүнийгээ тайлбарлах үүргийг шүүх, прокурорт хүлээлгэхээр тусгасан. Хэрэг тухайн үүргээ зөрчвөл хэрхэн үзэх талаар төсөлд тусгав.
34		Хэсэг нэмэх  16.1 дүгээр зүйлийн 18.Хөдөлбөргүй үнэн гэж урьдчилан тогтоосон ямар ч нотлох баримт байж болохгүй.	Энэ заалтад дурдсан хэм хэмжээ хуулийн 7.2-р зүйлийн 1-д дурдагдсан хэдий ч нотлох баримт гэсэн бүлэгт тодотгон заахаар төсөлд тусгав. Энэ зарчим нь зөвхөн яллагдагчид хамааралтай заалт биш ба гэм буруутай нь шүүхээр тогтоогдоогүй хэнийг ч гэм буруутайд тооцож үл болох Үндсэн хуулийн зарчимтай утга агуулга нэг зарчим учир төсөлд тусгав.
16.2 дугаар зүйл.Нотолбол зохих байдал			

35		<p>Заалт нэмэх</p> <p>16.2 дугаар зүйлийн 1.7.цагаатгах нөхцөл байдал.</p>	<p>Хуулийн 1.7-р зүйлийн 2-т зааснаар мөрдөгч нь яллагдагчийн яллах, цагаатгах нөхцөл байдлыг эргэлзээгүй тогтоох үүрэг хүлээдэг. Тиймээс нотолбол зохих байдлын хүрээнд цагаатгах нөхцөл байдал нь нотолбол зохих байдалд тооцон нэмэхээр төсөлд тусгав.</p>
<p>16.8 дугаар зүйл.Мөрдөн шалгах нууц ажиллагааны үр дүнг нотлох баримтаар тооцох</p>			
36	<p>16.8 дугаар зүйлийн 1.Хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулсан мөрдөн шалгах нууц ажиллагааны үр дүнг нотлох баримтаар тооцох ба нотлох баримтыг цуглуулж, бэхжүүлэх ажиллагааны арга, хэрэгсэл, эх сурвалж нууц байна.</p>	<p>Үг нэмэх</p> <p>16.8 дугаар зүйлийн 1.<b>Энэ</b> хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулсан мөрдөн шалгах нууц ажиллагааны үр дүнг нотлох баримтаар тооцох ба нотлох баримтыг цуглуулж, бэхжүүлэх ажиллагааны арга, хэрэгсэл, эх сурвалж нууц байна.</p>	<p>Мөрдөн шалгах нууц ажиллагаа гэдэг нь прокурорын зөвшөөрлөөр нууцаар явуулах Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан ажиллагааг хэлэх талаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.10-т заасан. Тиймээс энэ хэсэгт энэ хууль гэж тодруулан заахаар төсөлд нэмж тусгав.</p> <p>Түүнчлэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.1 дүгээр зүйлийн 4-т “Мөрдөгч <b>ЭНЭ ХУУЛЬД</b> заасан үндэслэл, журмын дагуу нотлох баримт цуглуулж, шалгаж, бэхжүүлнэ.” Гэж нотлох баримт цуглуулах, шалгах, бэхжүүлэхэд хэрэглэх хуулийн заалтыг тодруулж заасан байдаг.</p>
<p>16.11 дүгээр зүйл.Нотлох баримтаар тооцохгүй байх</p>			

37		<p>Хэсэг нэмэх</p> <p>16.11 дүгээр зүйлийн 4.Гэрчээр мэдүүлэг өгсөн этгээд тухайн гэмт хэрэгт сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч болсон бол түүний гэрчээр өгсөн мэдүүлгийг нотлох баримтаар тооцохгүй.</p>	<p>Хүн өөрийнхөө болон гэр бүлийн гишүүнийхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхтэй. Гэрч зөвхөн үнэнийг мэдүүлэх, худал хэлбэл хариуцлага хүлээдэг бол сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч нь ийм үүрэг хүлээдэггүй. Түүнчлэн яллагдагч нь хэргийн байдлыг нотлох үүрэг хүлээдэггүй. Өөрөөр хэлбэл гэрч ба яллагдагч түүний эрх зүйн байдал эрс өөр. Яллагдагчаас урд нь гэрчээр авсан мэдүүлэг нь гэмт хэргийн байдлыг нотлох шинж чанартай болж болзошгүй байдаг. Энэ нь яллагдагчийн эрх зүйн байдлыг дордуулах боломжтой. Тиймээс яллагдагч урд нь гэрчийн мэдүүлэг өгсөн бол уг мэдүүлгийг нотлох баримтаар тооцохгүй байхаар төсөлд тусгав.</p>
16.15 дугаар зүйл.Нотлох баримтыг шалгаж үнэлэх			
38		<p>Хэсэг нэмэх</p> <p>16.15 дугаар зүйлийн 4.Оролцогчийн шинжлэн судлуулсан нотлох баримтыг шүүх үнэлэхгүй, шийдвэрт тусгахгүй орхигдуулж болохгүй.</p>	<p>Шүүхийн өмнө эрх тэгш байх зарчим нь шүүхийн өмнө талууд өөр өөрийн зөв гэж үзсэн баримтаа гарган мэтгэлцэхэд оршдог. Харин шүүх нь шийдвэр гаргахдаа талуудын хэн алиных нь санал болгосон, мэтгэлцээний үндэслэл болгож байгаа баримтыг орхигдуулж болохгүй юм. Иймд учраас оролцогчийн шинжлэн судлуулсан нотлох баримтыг шүүх үнэлэхгүй орхигдуулж болохгүй байх талаар төсөлд тусгав.</p>
21.2 дугаар зүйл.Эд хөрөнгө битүүмжлэх			

39		<p>Хэсэг нэмэх</p> <p>21.2 дугаар зүйлийн 7.Эд хөрөнгө битүүмжлэхдээ аж ахуйн хэвийн үйл ажиллагааг хангах эд зүйлийг ашиглахыг хориглох байдлаар битүүмжилж болохгүй.</p>	<p>Эд хөрөнгө битүүмжлэх асуудал нь хохирлыг нөхөн төлүүлэх, хор уршгийг арилгуулах болон хөрөнгө, орлого хураах албадлагын арга хэмжээг хангах зорилгоор хийгддэг ажиллагаа хэдий ч уг ажиллагаа нь хүний амьдралын энгийн хэрэглээг алдагдуулах байдлаар хийгдэж болдоггүй. Үүнтэй адилаар эд хөрөнгө битүүмжлэхэд аж ахуйн хэвийн үйл ажиллагааг алдагдуулж болохгүй талаар төсөлд тусгав.</p>
<p>23.1 дүгээр зүйл.Үзлэг хийх</p>			
40		<p>Хэсэг нэмэх</p> <p>23.1 дүгээр зүйлийн 11.Үзлэг нь хүний хувийн ба гэр бүл, захидал, цахим хэрэгсэл, цахим харилцаа зэрэг халдашгүй байдал, хувийн нууцад хамааралтай бол үзлэгийг прокурорын зөвшөөрлөөр хийнэ.</p>	<p>Үндсэн хуулийн 16-р зүйлийн 13-т “иргэний захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална” гэж заасан. Зарим тохиолдолд үзлэг нь нэгжлэгийн шинжийг агуулдаг. Орчин үед иргэн хоорондын харилцаа ялангуяа захидал харилцаа цахим хэлбэрээр явагдах болсон. Тиймээс хүний эд зүйл буюу гар утас, компьютер гэх мэт цахим хэрэгслүүд нэгдүгээрт өөртөө мэдээлэл хадгалдаг, хоёрдугаарт цахим захидал харилцааны хэрэгсэл болдог учир цахим хэрэгсэл, цахим харилцаа зэрэгт үзлэг хийх бол прокурорын зөвшөөрөл авч байхаар төсөлд тусгав. Энэ нь Үндсэн хуульд заасан захидал харилцааны нууцыг хуулиар хамгаалах заалтад нийцнэ гэж үзэн төсөлд тусгав.</p>

24.1 дүгээр зүйл.Нэгжлэг хийх		
41		<p>Хэсэг нэмэх</p> <p>24.1 дүгээр зүйлийн 6. Хойшлуулшгүйгээс бусад тохиолдолд нэгжлэг хийх газар нэгжүүлэх этгээд, түүний төлөөлөл байгаа бол прокурорын зөвшөөрлийн хувийг гардуулж, урьдчилан танилцах боломжоор хангана.</p>
		<p>Үндсэн хуулийн 16-р зүйлийн 13-т “иргэний захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална” гэж заасан. Аливаа нэгжлэг нь хуулийн 24.1-р зүйлийн 4-т зааснаар хайж байгаа зүйлийг илрүүлсэн бол нэгжлэгийг даруй зогсоодог ба энэ нь иргэний орон байрны халдашгүй байдал нэг талаас хангагдах үндэслэл болох юм. Нөгөө талаас нэгжлэгээр прокурорын зөвшөөрөлд зааснаас бусад зүйлийг илрүүлэх зорилгоор явуулахыг хориглодог. Тиймээс орон байр, бусад газар, эд юмсын эзэн нь нэгжлэгээр юу хайж байгааг халдашгүй эрхийн хүрээнд мэдэх эрхтэй. Нэгжлэг хийж байгаа этгээд дураар аашлахаас сэргийлж прокурорын зөвшөөрлийг орон байр, бусад газар, эд юмсын эзэнд заавал танилцуулж байхаар төсөлд тусгав.</p>
25.1 дүгээр зүйл.Мэдүүлэг авах		
42	<p>25.1 дүгээр зүйлийн 1.Гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, шинжээч, сэжигтэн, яллагдагчаас мэдүүлэг авахад энэ <b>бүлэгт</b> заасан нийтлэг журмыг баримтална.</p>	<p>Үг өөрчлөх</p> <p>25.1 дүгээр зүйлийн 1.Гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, шинжээч, сэжигтэн, яллагдагчаас мэдүүлэг авахад энэ <b>хуульд</b> заасан нийтлэг журмыг баримтална.</p>
		<p>Мэдүүлэг авахтай холбоотой харилцаа хуулийн зөвхөн 25-р бүлгээр үл хязгаарлагдана. Бусад бүлэгт ч мөн мэдүүлэг авах, өгөх харилцааг зохицуулсан байдаг. Тиймээс мэдүүлэг өгөх, авахад хуульд заасан журмыг баримтлах талаар төсөлд тусгав. Жишээ нь хуулийн 1.9-р зүйлийн 2-т “Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч, гэрчээс мэдүүлэг авахдаа тэдэнтэй хүнлэг</p>

			бусаар харьцаж, нэр төр, алдар хүнд, бие махбод, сэтгэл санаанд хохирол учруулах арга хэрэглэхийг хориглоно.” гэж мэдүүлэг авах харилцааг зохицуулсан байдаг.
43		<p>Хэсэг нэмэх</p> <p>25.1 дүгээр зүйлийн 18.Мөрдөгч, прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаалтын явцад урьдчилж олж мэдсэн зүйлээ батлах зорилгоор мэдүүлэг авахыг хориглоно.</p>	Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулж байгаа этгээд нь мөрдөн шалгах ажиллагааны явцад шаардлагатай бүхий л баримтыг цуглуулж тухайн үйл явдлын талаар тодорхой мэдээлэлтэй болдог. Харин үүнийг ашиглаж, эсхүл уг мэдээллээ батлах зорилгоор мэдүүлэг авах нь хууль бусад тооцогдох талаар төсөлд тусгав.
44		<p>Хэсэг нэмэх</p> <p>25.1 дүгээр зүйлийн 19.Гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, шинжээч, сэжигтэн, яллагдагчаас мэдүүлэг авахад өөр бусад оролцогчийн өмгөөлөгч байлцах эрхтэй. Мэдүүлэг авахад байлцах хүсэлт гаргасан боловч мэдүүлэг авах хугацаанд хүрэлцэн ирээгүй нь мэдүүлэг авахыг хойшлуулах үндэслэл болохгүй.</p>	Өмгөөлөгчийг зөвхөн өөрийн үйлчлүүлэгчийн, эсхүл өөрийн хүсэлтээр явагдаж байгаа мөрдөн шалгах ажиллагаанд оролцуулахаар хязгаарлах өмгөөлөх ба яллах талуудын тэгш байдлыг алдагдуулдаг. Ялангуяа мөрдөгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд давуу байдал олж авах, хууль бусаар мэдүүлэг авах гэх мэт зүй бус үр дагавар гардаг. Тиймээс талуудын тэгш оролцоо, хяналтыг хангах үүднээс өмгөөлөгч нь хэрэгт хамааралтай аливаа мэдүүлэг авах ажиллагаанд оролцох эрхийг ханган төсөлд тусгав.

45		<p>Хэсэг нэмэх</p> <p>25.1 дүгээр зүйлийн 20.Мэдүүлэг авахын өмнө болон дараа нь мэдүүлэг авах эрх бүхий этгээд нь тухайн оролцогч, бусад оролцогчтой тухайн хэргийн талаар ярилцах, санал бодлоо хуваалцах, асуулт асуухыг хориглоно.</p>	<p>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад мэдүүлэг авахад иргэний нэр төрийг гутаан доромжлох, хүнлэг бус хэрцгий харьцах, айлган сүрдүүлэх, тулган шаардах, хуурч мэхлэхийг хориглодог. Аливаа мэдүүлэг нь зориулалтын байранд явагддаг тул тэнд хууль бус үйл ажиллагаа гарах боломжгүй. Харин камергүй хаалттай хэсэгт ийм үйлдэл гарч болзошгүй тул мэдүүлэг өгч байгаа этгээдийн эрх хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үүднээс мэдүүлэг авах ажиллагаа эхлэхээс өмнө ба дараа нь мөрдөгчөөс хэргийн үйл баримтын талаар ярилцахыг хориглохоор төсөлд тусгав.</p>
46		<p>Хэсэг нэмэх</p> <p>25.1 дүгээр зүйлийн 21.Согтуурсан, мансуурсан болон сэтгэл санааны хямралд орсон хүнээс мэдүүлэг авахыг хориглоно.</p>	<p>Мансуурсан, согтуурсан болон сэтгэл санааны хямралд орсон хүний сэтгэл санаа, оюун ухаан нь хэвийн бус болсон, сарнисан, ухамсарт нөлөөлсөн байдаг. Түүнчлэн энэ тохиолдолд ухаан санаа нь бодит байдлыг зөвөөр ойлгох чадваргүй болсон байдаг. Тиймээс ийм хүнээс мэдүүлэг авах нь бодитой, үнэн зөв байх нь эргэлзээтэй тул мэдүүлэг авахыг хориглохоор төсөлд тусгав.</p>
<p>30.12 дугаар зүйл.Хэрэг бүртгэлтийн хугацаа</p>			

47	<p>30.12 дугаар зүйлийн 2.Хэрэг бүртгэлтийн нийт хугацаа нь Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлд заасан хөөн хэлэлцэх хугацаагаар хязгаарлагдана.</p>	<p>Хэсэг өөрчлөн найруулах</p> <p>30.12 дугаар зүйлийн 2.Хэрэг бүртгэлтийн хэрэг үүсгэснээс хойш Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан тухайн хэргийг хөөн хэлэлцэх хугацааг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хугацаа өнгөрсөн бол хэрэг бүртгэлтийн хугацааг сунгахгүй.</p>	<p>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг ерөнхийд нь авч үзвэл дараах үндсэн үе шаттай. Үүнд:</p> <p>1/гэмт хэргийг илрүүлэх 2/үйлдсэн этгээдийг олж тогтоох 3/ял сонсгох 4/ял оногдуулах</p> <p>Эрүүгийн байцаан шийтгэх хууль (2002)-д хэрэг бүртгэх ажиллагааны явцад гэмт хэрэг үйлдсэн этгээдийг заавал олж тогтоосон байхыг шаарддаггүй байсан ба гэмт хэрэг гарсан эсэхийг тогтооход хэрэг бүртгэлтийн ажиллагаа үндсэндээ чиглэгдэж байв. Хэрэв гэмт хэрэг гарсан нь тогтоогдвол эрүүгийн хэрэг үүсгэхээр заасан байсан.(166.1) Улмаар мөрдөн байцаалтыг эрүүгийн хэрэг үүсгэсний дараа эхлүүлэхээр заасан байсан.(181.1) Харин Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2017) хэрэг бүртгэлт гэдгийг гэмт хэргийг илрүүлэхээс гадна үйлдсэн этгээдийг олж тогтоох зорилгоор чиглэгдсэн ажиллагааг хэлэхээр заасан. (30.1.1) Өөрөөр хэлбэл хэрэг бүртгэлтийн үндсэн зорилго нь гэмт хэргийг илрүүлэх, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтооход оршдог. “Хэрэгтэн”-ийг олчихоод дараа нь гэмт хэрэг үйлдсэн эсэхийг тогтоох, нотлох ажиллагаа явуулах зүй бус бөгөөд “хүнийг нь олоод хэргийг нь олох”-той агаар нэг юм. Тиймээс гэмт хэргийг илрүүлэх, үйлдсэн этгээдийг эргэлзээгүйгээр олж тогтоох нь мөрдөн шалгах ажиллагааны гол цөм болж</p>
----	---	--	---

			хугацаа их шаардагддаг. Тиймээс гэмт хэрэг үйлдсэн этгээдийг олж илрүүлэх, олж тогтоох, нотлох зэрэг ажиллагаанд буюу хэрэг бүртгэлтийн хугацааг нэмэгдүүлэх байдлаар төсөлд тусгав.
31.11 дүгээр зүйл.Сэжигтнээс мэдүүлэг авах			
48	31.11 дүгээр зүйлийн 1.1.өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх;	Үг нэмэх  31.11 дүгээр зүйлийн 1.1.өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, <b>дуугүй байх;</b>	Хүн бүр эрх зүйн мэдлэг боловсролтой байх боломжгүй. Өөрийн хэлсэн үг, өгсөн мэдүүлэг нь өөрийнх болон гэр бүлийн гишүүнийх нь эсрэг ашиглагдах эсэхийг урьдчилан мэдэх боломжгүй. Тиймээс эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд холбогдогч дуугүй байх, нөгөө талаас гэмт хэргийг нотлох үүргийг хүлээдэггүй. Тиймээс холбогдогчийн эрхийг хамгаалах зорилгоор “дуугүй байх” эрхийг баталгаажуулдаг. Энэ хүрээнд төсөлд сэжигтний эрхэд дуугүй байх эрхийг тодотгон тусгав.
31.13 дугаар зүйл.Мөрдөн байцаалтын хугацаа			
49	31.13 дугаар зүйлийн 1.Гэмт хэрэг үйлдсэнээс хойш Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан тухайн хэргийг хөөн хэлэлцэх хугацааг хөөр дахин	Үг хасах  31.13 дугаар зүйлийн 1.Гэмт хэрэг үйлдсэнээс хойш Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан тухайн хэргийг хөөн хэлэлцэх	Гэмт хэргийг үйлдсэн этгээдийг олж тогтоосноор хэрэг бүртгэлтийн хэрэг дуусаж мөрдөн байцаах ажиллагаа эхлэхээр хуульд зохицуулсан. Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг олж тогтоох нь түүнийг гэмт хэрэг үйлдсэн гэдгийг хангалттай нотлох баримтууд хэрэг бүртгэлтийн хэрэгт авагдсан, цугларсан эсэхээс шалтгаална. Харин гэмт хэрэг

	<p>нэмэгдүүлсэнтэй тэнцэх хугацаа өнгөрсөн бол мөрдөн байцаалтын хугацааг сунгаж болохгүй. Энэ хуулийн 31.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу мөрдөн байцаалтыг түдгэлзүүлсэн, эсхүл хэргийг прокурорт шилжүүлсэн бол мөрдөн байцаалтын хугацааг зогсооно. Түдгэлзүүлсэн хэргийг сэргээсэн, эсхүл хэрэгт нэмэлт ажиллагаа хийлгэхээр прокуророос мөрдөгчид хэргийг буцааснаас эхлэн мөрдөн байцаалтын хугацааг үргэлжлүүлэн тоолно.</p>	<p>хугацаа өнгөрсөн бол мөрдөн байцаалтын хугацааг сунгаж болохгүй. Энэ хуулийн 31.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу мөрдөн байцаалтыг түдгэлзүүлсэн, эсхүл хэргийг прокурорт шилжүүлсэн бол мөрдөн байцаалтын хугацааг зогсооно. Түдгэлзүүлсэн хэргийг сэргээсэн, эсхүл хэрэгт нэмэлт ажиллагаа хийлгэхээр прокуророос мөрдөгчид хэргийг буцааснаас эхлэн мөрдөн байцаалтын хугацааг үргэлжлүүлэн тоолно.</p>	<p>үйлдсэн этгээдийг олж тогтоосны дараа гэмт хэрэг үйлдсэн гэдгийг нотлох ажиллагаа явуулах нь бусдыг хэлмэгдүүлэх үндэслэл болдог гэж үздэг. “Хүн нь байвал хэрэг нь олдож” болохгүй. Хэрэв хүнээ олчихоод дараа нь гэмт хэрэг үйлдсэн гэдгийг нотлохоор ажиллаж эхэлбэл энэ нь ноцтой гажуудал үүсгэнэ. Мөрдөн байцаах ажиллагаа нь гэмт хэрэг үйлдсэн гэдгийг нотлоход бус (гэмт хэрэг үйлдсэн нь хэрэг бүртгэлтийн явцад тогтоогдсон) харин бусад нөхцөл байдлыг олж тогтооход чиглэх нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой гажуудал үүсэхээс урьдчилан сэргийлэгдэнэ. Тиймээс гэмт хэрэг үйлдсэн этгээдийг олж тогтоох буюу хэрэг бүртгэлтийн хугацааг урт болгож, түүнээс хойш хийгдэх ажиллагаа буюу мөрдөн байцаах ажиллагааны нийт хугацааг багасгах байдлаар төсөлд тусгав.</p>
<p>32.1 дүгээр зүйл.Хавтаст хэргийн материал танилцуулах</p>			
50		<p>Хэсэг нэмэх</p> <p>32.1 дүгээр зүйлийн 13.Мөрдөгч мөрдөн шалгах бүх ажиллагааг хийж дууссан, хэргийн бодит байдлыг бүрэн нотолж тогтоосон гэж үзсэн нь энэ</p>	<p>Мөрдөн шалгах ажиллагааны зорилго нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг олж тогтоох, улмаар гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай эсэхийг шүүхээр шийдүүлэхэд оршдог. Өөрөөр хэлбэл мөрдөн шалгах ажиллагаа нь нэг талын буюу төр /мөрдөгч, прокурор/-ийн хийх ажиллагаа байдаг. Нэг талын цуглуулсан, нотолсон гэх аливаа</p>

		зүйлийн 6.1, 6.3-т заасны дагуу гаргасан хүсэлтийг хангахгүй байх үндэслэл болохгүй.	баримт сэлтийг хангалттай гэж үзэх нь өрөөсгөл ба оролцогчийн хүсэл, саналыг үл харгалзах нь шүүхийн өмнө тэгш байх зарчимд ноцтой харшилна. Тиймээс мөрдөгчийн зүгээс дотоод итгэлийн хүрээнд хэргийг хангалттай гэж үзсэн нь оролцогчийн хүсэлт, гомдлыг шийдвэрлэхээс шүү үндэслэл болохгүй байхаар төсөлд тусгав.
32.8 дугаар зүйл.Хэрэгсэхгүй болгосон хэргийг сэргээх			
51	<p>32.8 дугаар зүйлийн 1.Энэ хуулийн 41.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэл тогтоогдсон бол хэргийг хэрэгсэхгүй болгосон, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тухай тогтоолыг хүчингүй болгосон прокурорын шийдвэрийг дээд шатны прокурор хүчингүй болгож, хэргийг мөрдөн байцаалтад шилжүүлнэ.</p> <p>2.Энэ хуулийн 32.4 дүгээр зүйлийн 2.4-т заасан тохиолдолд эрүүгийн хэрэг үүсгэж өөр хүнийг яллагдагчаар татсан бол энэ зүйлийн 1 дэх хэсэг хамаарахгүй.</p>	<p>Зүйл өөрчлөн найруулах</p> <p>32.8 дугаар зүйлийн 1.Энэ хуулийн 41.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан шинээр илэрсэн нөхцөл байдал илэрсэн бол эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тухай тогтоолыг хүчингүй болгосон прокурорын шийдвэрийг хүчингүй болгох эсэхийг шүүх шийдвэрлэнэ.</p> <p>2.Энэ хуулийн 41.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан шинээр илэрсэн нөхцөл байдал үүсвэл прокурор шинэ нөхцөл байдал илэрсэн гэж үзэн эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тухай тогтоолыг хүчингүй болгох саналаа холбогдох баримтын хамт шүүхэд хүргүүлнэ.</p>	<p>Шүүх тодорхой хэрэг маргаантай асуудлыг шийдвэрлэхэд эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдөж байгаа этгээдийг оролцоог хангах, тайлбар авах гэх мэт ажиллагааг явуулсны үндсэн дээр шийдвэр гаргадаг. Энэ нь иргэний шударгаар шүүлгэх эрхийг хангах үндсэн нөхцөл болдог. Харин яллах талаас аливаа шийдвэр гаргахад талуудын оролцоог төдийлөн хангадаггүй. Дотоод итгэлээрээ асуудалд мөрдөгч, прокурорын зүгээс хандах боломжийг хууль олгодог. Хэргийг хэрэгсэхгүй болгосон прокурорын тогтоолыг шинээр илэрсэн нөхцөл улмаас хүчингүй болгоход тухайн хэрэгт сэжигтэн, яллагдагчаар татагдсан байсан этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зайлшгүй хөндөгддөг. Тиймээс талуудын тэгш байдлыг хангах, шударгаар шүүлгэх эрхийг хангах үүднээс яллагдагчаар татах тухай тогтоолыг хүчингүй болгосон прокурорын шийдвэрийг шинээр илэрсэн нөхцөлийн улмаас дахин хянах шаардлагатай гэж үзвэл уг асуудлыг шүүх шийдвэрлэж байхаар төсөлд тусгав.</p>

		<p>3.Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас прокурорын гаргасан саналыг шийдвэрлэхэд энэ хуулийн Гучин дөрөвдүгээр бүлэгт заасан шүүх хуралдааны ерөнхий нөхцөл хамаарна.</p> <p>4.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан шүүхийн шийдвэрт гомдол, эсэргүүцэл гаргахгүй.</p> <p>5.Тухайн хэрэгт өөр этгээдийг холбогдуулан мөрдөн шалгах ажиллагаа явуулахад энэ зүйл хамаарахгүй.</p>	
32.10 дугаар зүйл.Яллах дүгнэлт үйлдэж хэргийг шүүхэд шилжүүлэх			
52		<p>Заалт нэмэх</p> <p>32.10 дугаар зүйлийн 3.3 гэм буруугийн хэлбэр;</p> <p>3.4.гэмт хэргийн ангилал, сэдэлт, зорилго, шинж;</p> <p>3.5.хэд хэдэн яллагдагчид холбогдуулан яллах дүгнэлт үйлдсэн бол яллагдагч тус бүрийн үйлдэл, оролцоо, гэмт</p>	<p>Прокурор нь шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс яллах чиг үүрэгтэйгээр оролцдог. Яллах дүгнэлтээр гэм буруугийн асуудлыг шийдвэрлэдэггүй хэдий төрөөс иргэн, хуулийн этгээдийг гэмт хэрэг үйлдсэн гэж үзэх төрийн шийдвэр болдог агуулгаар шүүхийн өмнө мэтгэлцэх үндсэн баримт бичиг болдог. Яллах дүгнэлт үйлдэхэд гэмт хэрэг үйлдсэн талаарх бүхий л асуудлыг нэг бүрчлэн тусган, хариуцлагатай хандах нь иргэний шударгаар шүүлгэх эрх хангагдах урьдач нөхцөл болох ба нөгөө талаас эрх зүйт төрийн шинж чанарыг</p>

		хэрэгт хамтран оролцсон хэлбэр.	баталгаажуулах юм. Тиймээс яллах дүгнэлтийн тэмдэглэх хэсэгт гэмт хэргийн талаар дэлгэрэнгүй тусган дүгнэж байх шаардлагатай гэж үзэн, энэ заалтыг нэг бүрчлэн нарийвчлан байдлаар төсөлд тусгав.
33.1 дүгээр зүйл.Яллагдагчийг шүүхэд шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх			
53	33.1 дүгээр зүйлийн 12.Шүүхийн шатнаас урьдчилсан хэлэлцүүлэг рүү хэрэг буцаахгүй.	<p>Хэсэг хүчингүй болгож агуулгын хувьд өөр зүйлд шилжүүлэх</p> <p>33.1 дүгээр зүйлийн 12.Шүүхийн шатнаас урьдчилсан хэлэлцүүлэг рүү хэрэг буцаахгүй.</p> <p>Заалт нэмэх</p> <p>33.1 дүгээр зүйлийн 6.18.яллах дүгнэлт энэ хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 32 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасанд нийцэхгүй байгаа тухай гомдол;</p> <p>6.19.хуульд заасан шаардлага хангаагүй нотлох баримтыг хавтаст хэргээс хасах тухай гомдол;</p>	<p>Шударгаар шүүлгэх иргэний эрхийг хангахад яллах дүгнэлт хуульд заасан шаардлага хангасан, хэргийн талаар тодорхой дурдсан байх шаардлагатай. Энэ тохиолдолд шүүхийн өмнө тэгш мэтгэлцэх, мэтгэлцээний үндсэн дээр хэргийн бодит байдлыг тогтоох боломж бүрдэх юм. Тиймээс яллах дүгнэлт хуульд заасан шаардлага хангаагүй, асуудал тус бүрийг шийдвэрлээгүй орхигдуулсан бол энэ талаар гомдол гаргах, яллах дүгнэлтийг зөвтгөх үүднээс оролцогч нь яллах дүгнэлт хуульд заасан шаардлага хангаагүй талаар шүүхэд гомдол гаргах, гомдлыг шүүх урьдчилсан хэлэлцүүлгээр шийдвэрлэх шаардлагатай гэж үзэн төсөлд тусгав.</p> <p>Аливаа хэрэг маргааныг хууль ёсны, хуульд заасан шаардлага хангасан нотлох баримтыг үндэслэн шийдвэрлэх нь шударга шүүхийн үндсэн шинж юм. Үүнээс гадна тухайн хэрэг хэзээ үйлдэгдсэнээс хамаарч тухайн үед хүчин төгөлдөр үйлчилж байсан хууль хэрэглэх</p>

		6.20.Эрүүгийн хуулийн 1.8 дугаар зүйлд заасан хууль үйлчлэх цаг хугацааны асуудал.	асуудал үүсдэг. Энэ нь хууль дээдлэх, хууль захирагдах зарчим хэрэгжихэд чухал ач холбогдолтой ба гэм буруугийн асуудлаас тусдаа харилцаа юм.
54		<p>Хэсэг нэмэх</p> <p>33.1 дүгээр зүйлийн 13. Энэ хуулийн 32.10 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасны дагуу гаргасан санал, хүсэлтийг хэрэгт хавсаргасан бол тухайн санал, хүсэлтийг урьдчилсан хэлэлцүүлгийн үед шүүх шийдвэрлэнэ.</p> <p>33.1 дүгээр зүйлийн 14. Хэрэг авагдсан нотлох баримт нь хэргийг хянан шийдвэрлэхэд хангалттай үндэслэлээр энэ зүйлд заасны дагуу гаргасан санал, хүсэлт, гомдлыг хангахгүй орхихыг хориглоно.</p>	<p>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 32.10 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасны дагуу гаргасан хүсэлт, гомдлыг шүүхэд шилжүүлсэн тохиолдолд тэрхүү хүсэлт, гомдлыг хэрхэн шийдвэрлэх нь тодорхойгүй үлдсэн. Тиймээс уг шийдвэрлэгдээгүй хүсэлт, гомдлыг урьдчилсан хэлэлцүүлэгт шүүх шийдвэрлэхээр төсөлд тусгав. Шүүхэд урьдаас хөдөлбөргүй үнэн гэж үзсэн баримт байж болдоггүй. Тиймээс хэрэгт авагдсан баримтууд юуг ямар хэмжээгээр нотолж байгаагаас үл хамааран урьдчилсан хэлэлцүүлгийн үед гаргасан хүсэлт, гомдлыг хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдолтой талаас нь үнэлж шийдвэрлэж байх шаардлагатай тул шүүхээс нотлох баримт хангалттай үндэслэлээр хүсэлт, гомдлыг шийдэхгүй орхигдуулахыг хориглохоор төсөлд тусгав. Энэ нь оролцогчийн хувьд шүүхийн өмнө эрх тэгш байх зарчимд нийцэх юм.</p>
33.3 дугаар зүйл.Хэргийг прокурорт буцаах			

55	<p>33.3 дугаар зүйлийн 1.Урьдчилсан хэлэлцүүлгийн үед дараахь үндэслэлээр шүүх өөрийн санаачилгаар, эсхүл хэргийг буцаах тухай прокурорын санал, яллагдагч, хохирогч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтийг харгалзан хэргийг прокурорт буцаахаар шийдвэрлэнэ:</p> <p>1.1.хэргийг буруу тусгаарласан бол;</p> <p>1.2.шүүх хуралдаанаар нөхөн гүйцэтгэх боломжгүй мөрдөн шалгах ажиллагааг хийлгэх бол;</p> <p>1.3.мөрдөн шалгах ажиллагаа явуулахад Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн бол.</p> <p>2.Хэргийг прокурорт буцаасан шийдвэрийг прокурор, яллагдагч, хохирогч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч,</p>	<p>Зүйл өөрчлөн найруулах</p> <p>33.3 дугаар зүйлийн 1.Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр яллах дүгнэлтэд заасан гэмт хэргийн хүрээнд талуудын гаргасан санал, хүсэлт, гомдол үндэслэлтэй гэж үзсэн, эсхүл шүүгч өөрийн санаачилгаар асуудлыг хянан шийдвэрлэсэн нь нэмэлт мөрдөн шалгах ажиллагаа явуулахад хамааралтай бол хэргийг прокурорт буцаана.</p> <p>2.Мөрдөн шалгах ажиллагааг шүүх хуралдаанаар нөхөн гүйцэтгэх боломжтой гэж шүүх үзвэл энэ зүйлийн 1 дэх хэсэг хамаарахгүй.</p> <p>3.Хэргийг буруу тусгаарласан, буруу нэгтгэсэн, яллах дүгнэлт хуульд заасан шаардлага хангаагүй нь хэргийг прокурорт буцаах үндэслэл болно.</p> <p>4.Хэргийг прокурорт буцаасан шийдвэрт гомдол, эсэргүүцэл гаргахгүй.</p>	<p>Шүүхийн шатнаас урьдчилсан хэлэлцүүлэг рүү хэрэг буцаахгүй байхаар хуульд заасан. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн шатанд талуудын хэрэгт хамааралтай гэж үзсэн бүхий л нотлох баримтыг бүрдүүлэх нь шударгаар шүүлгэх эрхийг хангах үндэс болдог. Талууд аль алиных нь хувьд хэрэгт авагдсан баримт хангалттай гэж үзсэний дараа шүүх хуралдааныг үргэлжлүүлэх нь талуудын тэгш байдлыг хангах нэг үндэс болно. Тиймээс урьдчилсан хэлэлцүүлгийн явцад талуудын гаргасан хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн нь хэргийг шүүхэд шилжүүлэх боломжгүй нөхцөл байдал үүсгэсэн бол хэргийг прокурорт буцаахаар төсөлд тусгав. Харин мөрдөн шалгах ажиллагааг шүүх хуралдаанаар нөхөн гүйцэтгэх боломжтой бол хэргийг прокурорт буцаахгүй байхаар төсөлд тусгав. Мөн түүнчлэн хэргийг прокурорт буцаасан тохиолдолд давж заалдах гомдол гаргахгүй байхаар тусгав. Хэргийн бодит байдлыг талуудын мэтгэлцээний үндсэн дээр тогтоох тул нэг талд шаардлагагүй гэж үзсэн ч нөгөө талд шаардлагатай гэж үзсэн бол тэрхүү шаардлагатай мөрдөн шалгах ажиллагааг зайлшгүй хийх нь шүүх хэргийг шударгаар шийдвэрлэх, талуудын эрх тэгш байдлыг хангах нөхцөл болох юм. Нөгөө талаас процессын явцад гаргасан шийдвэрт давж заалдахгүй байх нь хүний шүүхийн шийдвэрт давж заалдах эрхийг зөрчихгүй гэж үзэв. Энэ талаар Үндсэн хуулийн цэцийн 2021 оны 07 дүгнэлтэд “шүүхийн шийдвэрийг давж заалдах эрх нь тухайн эрх зүйн</p>
----	--	--	---

	<p>өмгөөлөгч эс зөвшөөрвөл уг шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдөрт багтаан эсэргүүцэл бичих, гомдол гаргах эрхтэй.</p>		<p>маргааныг хянан хэлэлцээд эцэслэн шийдвэрлэж гаргасан шүүхийн шийдвэрт хамаарах ойлголт бөгөөд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын (талуудын) хууль ёсны ашиг сонирхлыг хангахад чиглэгдсэн завсрын шинжтэй шийдвэрт гомдол гаргах нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад заасан шүүхийн шийдвэрийг давж заалдах эрхийг шууд хөндөхгүй болно.” гэж дүгнэсэн байдаг.</p>
<p>34.3 дугаар зүйл.Шүүх хуралдааныг тасралтгүй явуулах</p>			
<p>56</p>	<p>34.3 дугаар зүйлийн 1.Шүүх хуралдааныг <b>өдрийн цагаар явуулах</b> ба амрах зайлшгүй шаардлагатайгаас бусад цагт тасралтгүй явуулна.</p>	<p>Үг өөрчлөх 34.3 дугаар зүйлийн 1.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол шүүх хуралдааныг <b>ажлын цагаар явуулах ба энэ хуульд заасны дагуу шүүх хуралдааныг завсарлуулсан болон</b> амрах зайлшгүй шаардлагатайгаас бусад цагт тасралтгүй явуулна.</p>	<p>Шүүх хуралдааныг энэ хуульд өөрөөр заагүй бол зөвхөн ажлын цагаар явуулахаар төсөлд тусгалаа. Шүүх хуралдаан нь зөвхөн шүүгчийн хөдөлмөрийн асуудал биш ба хуралдаанд оролцож байгаа оролцогч тус бүрийн хөдөлмөрийн асуудал мөн хөндөгдөнө. Хөдөлмөрийн тухай хуульд нэг хоногт ажиллах ажлын цагийг 8 цаг байхаар тогтоосон байдаг. Үүнээс гадна шүүх хуралдаан хуульд заасан үндэслэл, нөхцөл байдал, давагдашгүй нөхцөл байдлын улмаас тодорхой хугацаагаар завсарлаж болдог. Хуралдаан завсарласан үеийг шүүх хуралдаан тасралтгүй үргэлжилж байна гэж үзэх үндэслэл болохгүй. Тиймээс шүүх хуралдаан завсарлах, амрах шаардлагатайгаа бусад цагт шүүх хуралдаан тасралтгүй үргэлжлэх талаар төсөлд тусгав.</p>

			<p>Шөнийн цагаас бусад цагт шийдвэрлэх зайлшгүй шаардлагатай зарим асуудлыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хуулийн 14.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.3, 1.5 дахь заалт, 31.4, 31.5 дугаар зүйлд заасан байдаг тул асуудлыг хянан шийдвэрлэх ажиллагааг хуанлийн өдөр бүр шөнийн цагаас бусад цагт тасралтгүй хэрэгжүүлэхээр заасан байдаг тул “энэ хуульд өөрөөр заагаагүй бол” гэж тодруулсан.</p>
<p>34.14 дүгээр зүйл.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэмжээ хязгаар</p>			
57		<p>Хэсэг нэмэх</p> <p>34.14 дүгээр зүйлийн 3.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад ноцтой зөрчил гарсан нь оролцогчийн эрх зүйн байдлыг дордуулах нөхцөл болсон гэж үзсэнээс бусад тохиолдолд шүүхийн аль ч шатнаас хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаахгүй.</p>	<p>Энэ зүйлийн 12 дахь хэсэгт шүүхийн шатнаас урьдчилсан хэлэлцүүлэгт буцаахгүй талаар заасан. Харин шүүхийн шатнаас хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд хэргийг буцааж болох асуудал нээлттэй үлдсэн. Учир нь хуулийн 39.8 дугаар зүйлд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль ноцтой зөрчих гэсэн зохицуулалт хэвээр хадгалагдаж байгаа. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шатанд процессын хууль зөрчсөн нь тогтоогдвол тухайн зөрчлийг арилгах шаардлага зүй ёсоор тулгарна. Энэ нь хууль дээдлэх, хуульд захирагдах зарчимд нийцэх юм. Тиймээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гарсан зөрчил</p>

		<p>4.Шүүхийн аль ч шатнаас хэргийг шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг рүү хэрэг буцаахгүй.</p>	<p>нь шүүгдэгчийн эрх зүйн байдлыг дордуулсан тохиолдолд л хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцааж болохоор төсөлд тусгав.</p> <p>Түүнчлэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.1 дүгээр зүйлийн 12 дахь заалтад “Шүүхийн шатнаас урьдчилсан хэлэлцүүлэг рүү хэрэг буцаахгүй.” Гэснийг агуулгын хувьд энэ зүйлд шилжүүлэн тусгахаар төсөлд тусгав. Учир нь хуулийн 33.1 дүгээр зүйл нь шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн явцад гаргах шийдвэртэй холбоотой харилцааг зохицуулдаг бол 34.1 дүгээр зүйл нь урьдчилсан хэлэлцүүлгийн дараагийн буюу гэм буруугийн асуудлыг шийдвэрлэх шүүх хуралдааны ерөнхий нөхцлийг зохицуулдаг.</p>
<p>34.20 дугаар зүйл.Шүүх хуралдааны дэг</p>			
58	<p>34.20 дугаар зүйлийн 2.Шүүх хуралдаанд оролцогч шүүхэд хандаж үг хэлэх, мэдүүлэг өгөхдөө суудлаасаа босно.</p>	<p>Хэсэг өөрчлөн найруулах</p> <p>34.20 дугаар зүйлийн 2. Шүүхийн хуралдааны танхимын зохион байгуулалт, техникийн шаардлагын улмаас шүүх хуралдаанд оролцогч шүүхэд хандаж үг хэлэх, тайлбар, мэдүүлэг өгөх, дүгнэлт гаргахдаа шүүх хуралдаан даргалагчийн зөвшөөрснөөр босож эсхүл суудлаасаа мэдүүлэг өгнө.</p>	<p>Хуульд оролцогч гэж сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, хуулийн этгээд, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийг хэлэхээр заасан. Тодруулбал прокурор нь оролцогчид хамаардаггүй. Шүүхийн өмнө талууд бүх талаараа эрх тэгш байх нь Үндсэн хуулийн зарчимд нийцнэ. Оролцогчдын эрх зүйн байдлыг харгалзан үг хэлэхдээ шүүгдэгч босож үг хэлдэг байдлаар хуулийн төсөлд тусгав.</p>

59	<p>34.20 дугаар зүйлийн 3.Шүүх оролцогч хуралдаанд оролцогч хүндэтгэн үзэх шалтгаантай бол шүүх хуралдаан даргалагчийн зөвшөөрснөөр суугаагаар мэдүүлэг өгч, үг хэлж болно.</p>	<p>Хэсэг хүчингүй болгох  <del>34.20 дугаар зүйлийн 3.Шүүх хуралдаанд оролцогч хүндэтгэн үзэх шалтгаантай бол шүүх хуралдаан даргалагчийн зөвшөөрснөөр суугаагаар мэдүүлэг өгч, үг хэлж болно.</del></p>	<p>Хуулийн 34.20 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг өөрчлөн найруулсантай холбогдуулан энэ хэсгийг хүчингүй болгохоор төсөлд тусгав.</p>
<p>35.23<sup>1</sup> дугаар зүйл.Хэлэлцүүлгийн үед үүссэн нөхцөл байдалтай холбоотой санал, хүсэлт гаргах /зүйл нэмэх/</p>			
60		<p>Зүйл нэмэх</p> <p>35.23<sup>1</sup> дугаар зүйл.Хэлэлцүүлгийн үед үүссэн нөхцөл байдалтай холбоотой санал, хүсэлт гаргах</p> <p>35.23<sup>1</sup> дугаар зүйлийн 1.Шүүхийн хэлэлцүүлгээр мөрдөн шалгах ажиллагааны явцад тогтоогдоогүй нөхцөл байдал үүссэн, эсхүл нотлох баримт шинжлэн судлах явцад үндэслэл бүхий эргэлзээ үүссэн гэж үзвэл энэ талаарх үндэслэлээ тайлбарлаж шүүх хуралдаан завсарлуулах хүсэлтийг оролцогч, түүний өмгөөлөгч гаргах эрхтэй.</p>	<p>Хуулийн 33.1-р зүйлийн 2-т шүүхийн шатнаас урьдчилсан хэлэлцүүлэг рүү хэрэг буцаахгүй гэж өөрчилсөн. Түүнчлэн хуулийн 36.2-р зүйлд хэргийг шүүх шийдвэрлэхдээ нэмэлт мөрдөн байцаалтад буцаах талаар шийдвэр гаргах талаар хуульд тусгайлан заагаагүй. Харин шүүхийн хэлэлцүүлгийн явцад явцад мөрдөн шалгах ажиллагааны явцад тогтоогдоогүй шинэ нөхцөл байдал үүсэх, нотлох баримтад үндэслэл бүхий эргэлзээ үүсвэл хэрхэн шийдвэрлэх талаар заагаагүй. Тухайлбал гэрч урьд өгсөн мэдүүлгээс өөр мэдүүлэг өгөх, нотлох баримтууд зөрүүтэй байх гэх мэт нөхцөл байдал үүсэж болно. Учир нь урьдчилсан хэлэлцүүлгээр нотлох баримтыг нэг бүрчлэн шинжлэн судалдаггүй бол шүүхийн хэлэлцүүлгийн үеэр баримт бүрийг шинжлэн судлах ажиллагаа явагддаг.</p>

		<p>2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу гаргасан хүсэлтийг шүүх хангаж шийдвэрлэсэн бол энэ талаар шүүгч захирамж, шүүх бүрэлдэхүүн тогтоол гаргана. Захирамж, тогтоолд нэмж гаргуулах нотлох баримтын талаар, шүүх хуралдаанаар нөхөн гүйцэтгэх боломжтой ямар мөрдөн шалгах ажиллагаа явуулах талаар болон шүүх хуралдааныг хэзээ, хаана үргэлжлүүлэх талаар оролцогчдод уншиж сонсгоно.</p> <p>3.Энэ зүйлд заасан журмын дагуу нотлох баримт шинээр гаргасан нотлох баримт, явуулсан мөрдөн шалгах ажиллагааны үр дүнг нотлох баримтаар тооцож, шинжлэн судална.</p> <p>4.Шүүх хуралдаан завсарласан нь шүүгч, прокурор өөр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулах, өмгөөлөгч өөр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоход саад болохгүй.</p>	<p>Тиймээс оролцогчийн эрх зүйн байдлыг дээрдүүлэх шаардлагатай гэж үзсэн өмгөөлөгч санал хүсэлт гаргах байдлаар тухайн эргэлзээтэй нөхцөл байдлыг арилгах боломжийг төсөлд тусгалаа.</p> <p>Энэ нь шударгаар шүүлгэх эрх, өөрийгөө өмгөөлөх эрх хангагдах, тэгш мэтгэлцээний үндсэн дээр бодит байдлыг тогтоох зарчмыг хэрэгжихэд чухал ач холбогдолтой гэж үзлээ.</p>
<p>35.25 дугаар зүйл.Шүүгдэгчийн эцсийн үг /үг өөрчлөх/</p>			

61	<p>35.25 дугаар зүйлийн 1.Улсын яллагч дүгнэлт, өмгөөлөгч санал, тэдгээрийг тайлбар хэлж дууссаны дараа <b>эцсийн үг</b> хэлэхийг шүүх хуралдаан даргалагч шүүгдэгчид зөвшөөрөх ба шүүгдэгч <b>эцсийн үг</b> хэлж байхад түүнд асуулт тавьж болохгүй.</p> <p>2.Шүүгдэгчээс хэлэх <b>эцсийн үгийг</b> цагаар хязгаарлаж болохгүй.</p>	<p>Үг өөрчлөх</p> <p>35.25 дугаар зүйл.Шүүгдэгчийн <b>сүүлийн мэдүүлэг</b></p> <p>35.25 дугаар зүйлийн 1.Улсын яллагч дүгнэлт, өмгөөлөгч санал, тэдгээрийг тайлбар хэлж дууссаны дараа <b>сүүлийн мэдүүлэг</b> өгөхийг шүүх хуралдаан даргалагч шүүгдэгчид зөвшөөрөх ба шүүгдэгч <b>сүүлийн мэдүүлэг өгч</b> байхад түүнд асуулт тавьж болохгүй.</p> <p>2.Шүүгдэгчээс хэлэх <b>сүүлийн мэдүүлгийг</b> цагаар хязгаарлаж болохгүй.</p>	<p>Шүүгдэгч нь ямар ч тохиолдолд гэмт хэргийн байдлыг нотлох үүрэг хүлээдэггүй. Гэхдээ гэмт хэргийн байдлаа мэдүүлэг өгөх эрх нь өөрт хадгалагдана. Энэ нь мэтгэлцээний нэмэлт механизм болж шүүгдэж байгаа этгээдэд боломж олгодог. Шүүгдэгч нь мэдүүлгээрээ өөрийгөө өмгөөлж тайлбар гаргаж болно, эсхүл гэм буруугаа хүлээн зөвшөөрч болно. Тиймээс шүүх хуралдаанд шүүгдэгчийн үг гэсэн агуулга хууль зүйн агуулгын хувьд мэдүүлэг тул эцсийн мэдүүлэг гэж өөрчлөхөөр төсөлд тусгав. Монгол хэлний ойлголт, агуулгын хувьд ч гэсэн эцсийн үг гэдэг нь үхэхийн өмнө хэлдэг үг, санамж, гэрээслэл гэсэн агуулгыг илэрхийлдэг тул эцсийн үг гэснийг сүүлийн мэдүүлэг гэж өөрчлөхөөр төсөлд тусгав.</p>
<p>35.27 дугаар зүйл.Тогтоол гаргахаар шүүх бүрэлдэхүүн зөвлөлдөх тасалгаанд орох</p>			

62	<p>35.27 дугаар зүйлийн 1.Шүүгдэгчийн <b>эцсийн үгийг</b> сонссоны дараа шүүх шийдвэр гаргахаар зөвлөлдөх тасалгаанд орох ба шүүх хуралдаан даргалагч энэ тухай зарлан мэдэгдэнэ.</p>	<p>Үг өөрчлөх</p> <p>35.27 дугаар зүйлийн 1.Шүүгдэгчийн <b>сүүлийн мэдүүлгийг</b> сонссоны дараа шүүх шийдвэр гаргахаар зөвлөлдөх тасалгаанд орох ба шүүх хуралдаан даргалагч энэ тухай зарлан мэдэгдэнэ.</p>	Дээрхтэй ижил.
63		<p>Хэсэг нэмэх</p> <p>35.27 дугаар зүйлийн 2.Шүүх зөвлөлдөхөд хуралдааны тэмдэглэл шаардлагатай гэж үзвэл тэмдэглэл бичгээр бүрэн гарах хүртэл шүүх хуралдааныг завсарлуулж болно.</p>	<p>Шүүхийн хэлэлцүүлэг нь гэм буруугийн асуудлыг хянан шийдвэрлэх зорилгоор шүүхээс зохион байгуулж буй албан ёсны хуралдааны үйл ажиллагаа юм. Энэ нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нэг зайлшгүй хэсэг бөгөөд талуудын байр суурийг сонсох, нотлох баримтыг судлах, хууль зүйн маргааныг шийдвэрлэх чухал үе шат болдог. Түүнчлэн гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн шүүхийн хэлэлцүүлэгт мэдүүлсэн мэдүүлэг нь нотлох баримт болох боломжтой байдаг. Нөгөө талаас шүүгч өндөр ой ухаан санамжтай байсан ч шүүх хуралдааны үед хэлсэн үг бүрийг нэг бүрчлэн санах боломжгүй, үг бүрийг тэмдэглэн хөтлөх боломжгүй байдаг. Энэ ч утгаараа шүүх хуралдаан бүрд тэмдэглэл хөтлөх нарийн бичгийн ажилтан ажилладаг. Тиймээс хэргийг шийдвэрлэхэд оролцогчдын мэдүүлэг, тайлбар, яллах болон өмгөөллийн хууль зүйн дүгнэлт нэг бүрчлэн шаардлагатай гэж үзвэл шүүхээс хуралдааны тэмдэглэл гарах хүртэл хүртэл хугацаагаар хуралдааныг завсарлуулж, улмаар тэмдэглэл гарсны дараа шийдвэр гаргах боломжтой болох нөхцөлийг</p>

			бүрдүүлэх үүднээс энэ зохицуулалтыг төсөлд шинээр тусгав. Энэ нь шүүх шийдвэр гаргахад талуудын оролцоо, байр суурийг хангахад чухал ач холбогдолтой гэж үзэв.
36.1 дүгээр зүйл.Шийдвэр гаргахаар зөвлөлдөх			
64	<p>36.1 дүгээр зүйлийн 5.1.шүүх хуралдаанаар тогтоогдсон хэргийн нөхцөл байдал нь гэмт хэрэг мөн эсэх;</p> <p>5.2.тухайн гэмт хэрэгт шүүгдэгч гэм буруутай эсэх;</p>	<p>Заалт өөрчлөн найруулах</p> <p>36.1 дүгээр зүйлийн 5.1.шүүх хуралдаанаар улсын яллагч, өмгөөлөгч, иргэдийн төлөөлөгчийн дүгнэлт;</p> <p>5.2.гэмт хэргийн талаарх дараах нөхцөл байдал. Үүнд:</p> <p>а/шүүх хуралдаанаар тогтоогдсон шүүгдэгчийн үйлдэл, эс үйлдэхүй гэмт хэрэг мөн эсэх;</p> <p>б/тухайн гэмт хэрэгт шүүгдэгч гэм буруутай эсэх;</p> <p>в/гэмт хэрэг үйлдэгдсэн газар, цаг хугацаа;</p> <p>г/гэм буруугийн хэлбэр;</p> <p>д/гэмт хэргийн ангилал, сэдэлт, зорилго;</p>	<p>Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болох нь Үндсэн хууль, хүний эрхийн үндсэн зарчим. Хүнийг гэм буруутайд тооцох эсэхийг судлан шийдвэрлэх хэсэг бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны гол цөм болдог. Зөвлөлдөх тасалгаанд шүүгдэгчийн гэм буруутайд тооцох эсэхийг хянан шийдвэрлэхдээ ач холбогдол бүхий хэсэг бүрийг орхигдуулахгүйгээр хэлэлцэх нь шүүхийн шийдвэр шударга, хууль ёсны, үндэслэл бүхий гарахад чухал ач холбогдолтой. Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиар шүүхийн шийдвэр гарах үйл ажиллагаа хоёр шаттай байх агуулгатай. Эхний шатанд буюу зөвлөлдөх тасалгаанд хэргийн товч агуулгыг судалж шийдвэрлэх, хоёр дахь шатанд буюу шийдвэрийг цаасаар гаргахдаа хэргийг дэлгэрүүлж судалж шүүхийн шийдвэрийг бичгээр гаргах. Энэ нь шүүх шийдвэр гаргахдаа хэргийн агуулгыг бүхэлд нь, талуудын мэтгэлцээнд өгүүлсэн мэдүүлэг, үгийг бүрэн судлахгүйгээр шийдвэр гарах нөхцөлийг бүрдүүлж болзошгүй эрх зүйн үр дагаврыг үүсгэдэг.</p>

		е/шүүх хэд хэдэн шүүгдэгчид холбогдох хэргийг шийдвэрлэж байгаа бол шүүгдэгч тус бүрийн үйлдэл, оролцоо, гэмт хэрэгт хамтран оролцсон хэлбэр;	Тиймээс шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэг буюу гэм буруутайд тооцох эсэх хэсгийг дэлгэрэнгүйгээр зөвлөлдөх тасалгаанд хэлэлцэн шийдвэрлэж байхаар төсөлд тусгав.
36.2 дугаар зүйл.Шүүхийн шийдвэрийн хэлбэр, бүтэц			
65	36.2 дугаар зүйлийн 2.Шүүхийн шийдвэр нь удиртгал, <b>тодорхойлох</b> , тогтоох хэсгээс бүрдэнэ.	36.2 дугаар зүйлийн 2.Шүүхийн шийдвэр нь удиртгал, <b>үндэслэх</b> , тогтоох хэсгээс бүрдэнэ.	Аливаа шүүхийн шийдвэр нь шүүх хуралдаанаар хэлэлцэгдэж, хэргийг хянан шийдвэрлэхэд үндэс болсон нотлох баримтад үндэслэн гардаг. Өөрөөр хэлбэл хуульд туссан тодорхойлох хэсэгт шүүхийн шийдвэр гарах болсон үндэслэл, түүний хууль зүйн үндэслэлийн талаар дурдагдсан нь агуулгын хувьд шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэг юм.  Тиймээс хууль зүйн нэршилийг зөвтгөж тодорхойлох хэсэг гэснийг үндэслэх хэсэг болгон өөрчлөхөөр төсөлд тусгав. 1963-2017 оны хугацаанд хүчин төгөлдөр үйлчилж байсан Эрүүгийн байцаан шийтгэх хуульд шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэг гэж байгаагүй ба тодорхойлох хэсэгтээ шийдвэрийн үндэслэлээ дурддаг байсан. Энэ нь “байцаан шийтгэх” зарчимд илүү хамааралтай юм.
36.7 дугаар зүйл.Шүүхийн шийтгэх тогтоолын <b>тодорхойлох</b> хэсэг			

66	<p>36.7 дугаар зүйл.Шүүхийн шийтгэх тогтоолын <b>тодорхойлох</b> хэсэг</p> <p>36.7 дугаар зүйлийн 1.Шүүхийн шийтгэх тогтоолын <b>тодорхойлох</b> хэсэг нь шүүгдэгчийг гэм буруутайд тооцох, эрүүгийн хариуцлага хүлээлгэх гэсэн хоёр хэсгээс бүрдэнэ.</p>	<p>Үг өөрчлөх</p> <p>36.7 дугаар зүйл.Шүүхийн шийтгэх тогтоолын <b>үндэслэх</b> хэсэг</p> <p>Үг өөрчлөх</p> <p>36.7 дугаар зүйлийн 1.Шүүхийн шийтгэх тогтоолын <b>үндэслэх</b> хэсэг нь шүүгдэгчийг гэм буруутайд тооцох, эрүүгийн хариуцлага хүлээлгэх гэсэн хоёр хэсгээс бүрдэнэ.</p>	Дээрхтэй ижил агуулгатай.
67	<p>36.7 дугаар зүйлийн 2.4.шүүх хуралдаанаар тогтоогдсон хэргийн нөхцөл байдалд хийсэн хууль зүйн дүгнэлт;</p>	<p>Өгүүлбэр нэмэх</p> <p>36.7 дугаар зүйлийн 2.4.шүүх хуралдаанаар тогтоогдсон хэргийн нөхцөл байдалд хийсэн хууль зүйн дүгнэлт, <b>Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, бусад хууль тогтоомж бодит нөхцөл байдалд хэрхэн тайлбарлаж хэрэглэсэн талаар;</b></p>	<p>Хууль зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах эрх Дээд шүүхэд хамаардаг. Дээд шүүхээс гаргасан тайлбар нь хууль зүйн эх сурвалж болдог. Харин хэрэг маргаан шийдвэрлэхдээ тухайн хэрэгт хамаарах хуулийн заалтыг ойлгож, утга агуулгыг нь тодорхойлж тайлбарлан хэрэглэх нь тухайн хэрэг маргааныг хянан шийдвэрлэж байгаа шүүх /шүүгч, шүүх бүрэлдэхүүн/-д байдаг. Энэ нь тухайн хэрэгт хууль хэрхэн үйлчлэхийг ойлгож, тайлбарлаж хэрэглэх бөгөөд зөвхөн тэр хэрэгт үйлчилнэ, бусдад заавал дагаж мөрдөхгүй. Энэ ч агуулгаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.15 дугаар зүйлийн 2-т “Эрүүгийн хэрэгт хамааралтай бүхий л нотлох баримтыг шалгасан боловч сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн гэм буруутай эсэхэд, түүнчлэн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Эрүүгийн</p>

			<p>хууль, энэ <b>хуулийг тайлбарлах, хэрэглэхэд</b> эргэлзээ гарвал түүнийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтанд ашигтайгаар шийдвэрлэнэ.” гэсэн байдаг. Тиймээс шийдвэрийн үндэслэх хэсэгт шүүхийн хууль зүйн дүгнэлтээс гадна хуулийг тайлбарлаж хэрэглэсэн талаарх үндэслэлийг тухайн заалтад нэмэхээр төсөлд тусгав.</p> <p>Тодорхой гэмт хэрэг үйлдэгдсэн эсэхийг тогтооход бусад хууль тогтоомж зөрчигдсэн эсэхийг тодорхойлох шаардлага үүсдэг. Тухайлбал Эрүүгийн хуулийн 27.10 дугаар зүйлд заасан гэмт хэргийг тогтооход тээврийн хэрэгслийн жолооч хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн эсэхийг тодорхойлох шаардлага үүсдэг. Тиймээс Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиас гадна бусад хууль тогтоомжийг тайлбарлан хэрэглэх шаардлага зүйл ёсоор шүүхэд үүсдэг.</p>
68	36.7 дугаар зүйлийн 2.3.шүүгдэгчийг гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутайд тооцсон шүүхийн шийдвэрийн үндэслэл болсон нотлох баримтын агуулга, шүүх тухайн нотлох баримтыг хэрэгт хамааралтай, ач холбогдолтой, хууль	<p>Заалт өөрчлөн найруулах</p> <p>36.7 дугаар зүйлийн 2.3.шүүхийн шийдвэрийн үндэслэл болсон нотлох баримтын асуудал. Үүнд:</p> <p>а/шүүгдэгчийг гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутайд тооцсон шүүхийн шийдвэрийн үндэслэл</p>	<p>Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болох талаар Үндсэн хуулийн 16-р зүйлийн 14-т заасан. Энэ талаар Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 11.1-д “Гэмт хэрэгт буруутгагдаж буй хэн боловч өмгөөлөх бүх боломжоор хангагдсан нээлттэй шүүх хурлаар гэм буруутайг нь хуулийн дагуу тогтоох</p>

	<p>ёсны гэж үзсэн улсын яллагчийн дүгнэлт, өмгөөлөгчийн саналын үндэслэл болгосон баримт, иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг няцаан үгүйсгэсэн үндэслэл;</p>	<p>болсон нотлох баримт түүний агуулга;</p> <p>б/улсын яллагч ба өмгөөлөгчийн дүгнэлтийн үндэслэл болгосон нотлох баримтыг авсан эсхүл няцаан үгүйсгэсэн үндэслэл;</p> <p>в.улсын яллагч ба өмгөөлөгчийн хууль зүйн дүгнэлтийг авсан болон няцаасан үндэслэл;</p> <p>г/иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг няцаан үгүйсгэсэн үндэслэл;</p>	<p>хүртэл гэм буруугүй гэж тооцогдох эрхтэй.” гэж заасан.</p> <p>Тодруулбал хүнийг гэм буруутайд тооцох хэсэг бол шүүхийн шийдвэр гарах гол үндэслэл болдог. Тиймээс шүүгдэгчийг гэм буруутайд тооцох эсэхийг шийдвэрлэх шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэг тодорхой, дэлгэрэнгүй байх нь шүүх шударга байх, түүнээс гарах шийдвэр нь хууль ёсны, үндэслэл бүхий байхад чухал ач холбогдолтой.</p> <p>Үүний учир шүүхийн шийдвэрийн гэм буруутайд тооцох хэсгийг дэлгэрүүлж дэд заалтууд болгон төсөлд тусгав.</p>
<p>36.9 дүгээр зүйл.Шүүхийн цагаатгах тогтоол</p>			
69	<p>36.9 дүгээр зүйлийн 1.Шүүхийн цагаатгах тогтоолын <b>тодорхойлох</b> хэсэгт дараахь зүйлийг тусгана:</p> <p>3.Шүүхийн шийдвэрийн <b>тодорхойлох</b> хэсэгт гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийн</p>	<p>Үг өөрчлөх</p> <p>36.9 дүгээр зүйлийн 1.Шүүхийн цагаатгах тогтоолын <b>үндэслэх</b> хэсэгт дараахь зүйлийг тусгана:</p> <p>Үг өөрчлөх</p> <p>3.Шүүхийн шийдвэрийн <b>үндэслэх</b> хэсэгт гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийн талаар шүүхээс</p>	<p>Энэ хэсэгт мөн тодорхойлох гэснийг үндэслэх болгон өөрчлөхөөр төсөлд тусгав. Дээд хэсэгт энэ талаар дурдсан.</p>

	талаар шүүхээс гаргасан шийдвэрийн үндэслэлийг заана.	гаргасан шийдвэрийн үндэслэлийг заана.	
38.2 дугаар зүйл.Давж заалдах журмаар гомдол, эсэргүүцэл гаргах			
70		<p>Хэсэг нэмэх</p> <p>38.2 дугаар зүйлийн 9.Шүүгдэгч, түүний өмгөөлөгчөөс бусад оролцогч нь хэргийн зүйлчлэл, ялын хэмжээний асуудлаар давж заалдах гомдол гаргах эрх эдлэхгүй.</p>	<p>Үндсэн хуулийн 56-р зүйлд зааснаар прокурор нь шүүх хуралдаанд төрийн өмнөөс оролцдог бол шүүх нь Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 22.1-д заасанчлан шийдвэрээ Монгол Улсын нэрийн өмнөөс гаргадаг. Тодруулбал гэмт хэрэг үйлдсэн этгээдийг яллах эрх хэмжээ нь төр түүнийг төлөөлж прокурорт оногддог. Харин шүүгдэгчийн гэм буруутай эсэх, ял оногдуулах эрх хэмжээ нь улсын нэрийн өмнөөс Үндсэн хуулийн дагуу шүүхэд оногддог. Нөгөө талаас шүүхийн шийтгэх тогтоолын улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж болзошгүй этгээд нь шүүгдэгч юм. Харин шүүгдэгчээс бусад оролцогчид хэргийн зүйлчлэл, ялын хэмжээ шууд хамааралгүй учир шүүгдэгч, түүний өмгөөлөгчөөс бусад оролцогч нь хэргийн зүйлчлэл, ялын хэмжээний асуудлаар давж заалдах гомдол гаргах эрх эдлэхгүй талаар төсөлд тусгав. Харин улсын яллагч давж заалдах журмаар эсэргүүцэл гаргадаг учир энэ зохицуулалтад хамаарахгүй.</p>
39.1 дүгээр зүйл.Давж заалдах шатны шүүхийн эрх хэмжээ			

71	<p>39.1 дүгээр зүйлийн 1. Давж заалдах шатны шүүх гомдол, эсэргүүцлийг хянан шийдвэрлэхдээ тухайн хэргийн бүх ажиллагаа, шийдвэрийг бүхэлд нь хянанана.</p>	<p>Үг өөрчлөх</p> <p>39.1 дүгээр зүйлийн 1. Давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэж буй шүүх зөвхөн гомдол, эсэргүүцэлд дурдсан үндэслэлээр хязгаарлалгүй хэргийг бүхэлд нь <b>хянан үзэх бөгөөд давж заалдах шатны шүүх хуралдаанаар хэлэлцээгүй асуудлыг шийдвэрийн үндэслэл болгохгүй.</b></p>	<p>Шүүх нь Үндсэн хуулиар тогтоосон зарчим болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тусгай зарчимд захирагдаж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулдаг. Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим болдог бол хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх, шүүгч хараат бус байж гагцхүү хуульд захирагдах, хэрэг маргааныг хамтын зарчмаар шийдвэрлэх гэсэн зарчмууд нь шүүх эрх мэдлийн Үндсэн хуулийн зарчимд хамаардаг. Харин талуудын зарчим, мэтгэлцэх буюу шүүх хөндлөнгийн байх, шүүх хуралдааныг нээлттэй, тасралтгүй явуулах, монгол хэл дээр явуулах, эх хэлээрээ мэдүүлэг тайлбар өгөх, шүүхийн шийдвэр заавал биелэгдэх гэсэн зарчмууд нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тусгай зарчим гэж үздэг. Эдгээр зарчмууд нь шүүхийн бүх шатанд хангагдаж байж шударга шүүхийн үндсэн шинж хадгалагдана. Шүүх хуралдаанаар хэлэлцээгүй асуудлаар шүүх шийдвэр гаргах нь шүүх хөндлөнгийн байх зарчимд үл нийцнэ. Ялангуяа давж заалдах шатны журмаар хэрэг хянан шийдвэрлэх үед шүүх хуралдаанаар хэлэлцээгүй асуудлаар шүүх шийдвэр гаргах нь хэргийн оролцогч нөгөө талын давж заалдах гомдол гаргах үндсэн эрхтэй зөрчилдөнө. Нөгөө талаас шүүх нь мөрдөн шалгах чиг үүргийг хүлээдэггүй дурдах нь зүйтэй. Тиймээс давж заалдах шатны шүүх хуралдаанаар хэлэлцээгүй асуудал давж</p>
----	---	---	---

			заалдах шатны шүүхийн шийдвэрийн үндэслэл болохгүй байх талаар төсөлд тусгав.
39.8 дугаар зүйл.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль ноцтой зөрчих			
72	39.8 дугаар зүйлийн 1.10.илт үндэслэлгүйгээр хэргийг хэрэгсэхгүй болгосон.	Заалт өөрчлөн найруулах 39.8 дугаар зүйлийн 1.10.талуудаас шүүхийн хэлэлцүүлэгт шинжлэн судалсан нотлох баримтыг үнэлэхгүй орхигдуулсан.	Шүүх нь аливаа хэрэг маргааны нөхцөл байдлыг нотлох баримтад тулгуурлан үндэслэж, хуульд захирагдан шийдвэрлэдэг. Шүүхийн шийдвэр үндэслэлгүй байх хэм хэмжээг хуулийн 39.6-р зүйлээр, хууль буруу хэрэглэх асуудлыг хуулийн 39.7-р зүйлд нэгэнт зохицуулсан. Тиймээс хуулийн 39.8-р зүйлийн 1.10 дахь заалт нь давхацсан гэж үзэн өөрчлөлт оруулахаар төсөлд тусгав.  Шүүх хэргийн бодит байдлыг талуудын мэтгэлцээний үндсэн дээр тогтоох зарчмын агуулга нь талуудын үндэслэл болгож, хуралдаанд шинжлэн судалж байгаа баримтыг нэг бүрчлэн шүүх үнэлж шийдвэр гаргахад оршино. Тиймээс талуудын тэгш байдлыг хангах үүднээс талуудын мэтгэлцээний үндэслэл болгож байгаа аль ч баримтыг үнэлэхгүй орхигдуулж болохгүй, хэрэв орхигдуулсан бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчилд тооцохоор төсөлд тусгав.
39.9 дүгээр зүйл.Давж заалдах шатны шүүхийн шийдвэр			

73		<p>Заалт нэмэх</p> <p>39.9 дүгээр зүйлийн 1.3.Энэ хуулийн 39.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил тогтоогдсон бол анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож дахин хэлэлцүүлэхээр буцаах;</p>	<p>Эрүүгийн хэргийг давж заалдах журмаар хянан шийдвэрлэж байхад хуульд заасан ноцтой зөрчил илэрсэн тохиолдолд давж заалдах шатны шүүх тухайн хэргийг хэрхэн шийдвэрлэх талаар хуульд тодорхой тусгаагүй.</p> <p>Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчилтэй байхад давж заалдах шатны шүүхийг “цагаатга эсхүл ялла” гэхээс өөр сонголтыг хуулиар өгөхгүй байх нь нэг талаас шүүгдэгч хэлмэгдэх нөгөө талаас ял завших зайлшгүй нөхцөлийг бүрдүүлнэ. Тиймээс процессын явцад гарсан ноцтой зөрчил нь шүүгдэгчийн эрх зүйн байдлыг дордуулсан гэж үзсэн тохиолдолд давж заалдах шатны шүүх хуралдаанаар тогтоогдсон нөхцөлд тухайн хэрийг дахин хэлэлцүүлэхээр буцаах боломжтой байхаар төсөлд тусгав.</p>
40.1 дүгээр зүйл.Хяналтын журмаар гомдол, эсэргүүцэл гаргах			
74	<p>40.1 дүгээр зүйлийн 1.2.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн;</p>	<p>Заалт өөрчлөн найруулах</p> <p>40.1 дүгээр зүйлийн 1.2.Энэ хуулийн 39.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил нь шүүхийн шийдвэрт ноцтой нөлөөлсөн;</p>	<p>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ноцтой зөрчил гэж ямар зөрчлийг хамааруулах талаар хуулийн 39.8-р зүйлд тусгайлан заасан. Гэсэн хэдий ч хяналтын журмаар гомдол гаргахад ямар зөрчлийг ноцтой зөрчил гэж үзэн гомдол гаргах, хяналтын шатны шүүх ямар зөрчлийг ноцтой зөрчил гэж үзэх талаар тодорхой дурдаагүй. Тиймээс нэгэнт хуульд процессын ажиллагааны ямар зөрчлийг ноцтой тооцох талаар заасан тул хяналтын журмаар гомдол гаргах, нөгөө талаас хяналтын шатны шүүх уг гомдлыг хянан шийдвэрлэхэд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн</p>

			39.8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлахаар төсөлд тусгав.
75		<p>Заалт нэмэх</p> <p>40.1 дүгээр зүйлийн 1.5. хууль зөрчсөн.</p>	<p>Үндсэн хуулийн цэцийн 2017-04-12-ны өдрийн 03 дүгнэлтэд "...Хяналтын шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зөвхөн анхан болон давж заалдах шатны шүүх эрүүгийн хэргийг шийдвэрлэхдээ Эрүүгийн хуулийг зөв хэрэглэсэн эсэх, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн эсэх тухай хууль хэрэглээний асуудлыг хянан хэлэлцдэг онцлогоос хамаарч..." гэсэн байдаг. Өөрөөр хэлбэл эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд хяналтын шатны шүүхийн хяналтын цар хүрээнд Эрүүгийн хуулийг зөв хэрэглэсэн эсэх нь зайлшгүй багтдаг. Тиймээс Эрүүгийн хуулийг зөв хэрэглэсэн эсэх талаарх асуудлаар буюу хууль зөрчсөн эсэх асуудлаар хяналтын шатны шүүхэд гомдол, эсэргүүцэл гаргах эрхтэй байдлаар төсөлд тусгав.</p>
76		<p>Хэсэг нэмэх</p> <p>40.1 дүгээр зүйлийн 11. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль ноцтой зөрчсөн зөрчлийн улмаас анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг прокурорт, эсхүл дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцаасан давж заалдах шатны шүүхийн магадлалд</p>	<p>Шүүх хэргийн бодит байдлыг талуудын мэтгэлцээний үндсэн дээр тогтооно. Энэхүү зарчим нь дан ганц анхан шатны шүүхэд хамааралтай бус бөгөөд шүүхийн бүхий л шатанд хамааралтай. Давж заалдах шатны шүүх нь хэргийг агуулгын хувьд хянан шийдвэрлээгүй байхад тухайн хэргийг агуулгын хувьд хяналтын шатны шүүх авч хэлэлцэн шийдвэрлэх нь хэргийн нөхцөл байдлыг талуудын мэтгэлцээний үндсэн дээр тогтоон шийдвэрлэх зарчимд үл нийцнэ. Өөрөөр хэлбэл талууд гомдол гаргаагүй, тайлбар өгөөгүй асуудлыг шүүх бие даан, сайн дураараа санаачилгаараа шийдвэрлэх нь шүүх</p>

		хяналтын журмаар гомдол гаргахгүй.	хөндлөнгийн байх зарчимд нийцдэггүй. Энэ нь өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, шүүх хөндлөнгийн байх зарчимд үл нийцнэ гэж үзэн энэхүү заалтыг төсөл тусгав.
40.2 дугаар зүйл.Хяналтын журмаар гаргасан гомдол, эсэргүүцлийг хүлээн авах			
77	40.2 дугаар зүйлийн 3.Хяналтын шатны шүүх гомдол, эсэргүүцлийг хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор танхимын нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцэж дөрөв, түүнээс дээш шүүгч хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх талаар санал гаргавал энэ тухай тогтоол гаргана.	Хэсэг өөрчлөн найруулах 40.2 дугаар зүйлийн 3. Хяналтын шатны шүүх гомдол, эсэргүүцлийг хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор энэ хуулийн 40.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлээр гомдол гаргасан эсэхийг танхимын нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцэж, хуульд заасан үндэслэл, журмын дагуу гомдол гаргасан гэж дөрөв, түүнээс дээш шүүгч санал гаргавал хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тогтоол гаргана.	Үндсэн хуулийн цэцийн гишүүний 2020 оны 07-р тогтоолд дурдагдсан Хууль зүйн сургуулийн профессор, хууль зүйн ухааны доктор Д.Баярсайхан дүгнэлтэд "1.Эрүүгийн процессын эрх зүйн шинжлэх ухаанд эрүүгийн хэргийг хяналтын журмаар хүлээн авч шийдвэрлэх Улсын дээд шүүхийн бүрэн эрхийг: а)Процедурын болон завсрын шийдвэр гаргах, б)Хэргийг эцэслэх буюу сүүлчийн шийдвэр гаргах гэж хоёр ангилалд ялган авч үздэг. Завсрын процесс гэдэг нь хяналтын журмаар гомдол эсэргүүцлийг Улсын дээд шүүхэд гаргасныг хуульд заасан харьяаллын болон түүний шаардлагыг хангасан эсэхийг урьдчилан хянаж хэсэгчлэн томилсон бүрэлдэхүүн бүхий шүүгч нарын (3 шүүгч) хэлэлцүүлгээр оруулж, Улсын дээд шүүхийн чиглэлийн шүүгч нарын хуралдаанд оруулах эсэхийг шийдвэрлэнэ. Энэ нь хэргийг шийдэх процесс биш, зөвхөн тухайн гомдол, эсэргүүцлийг хуульд заасан харьяаллын дагуу гаргасан эсэхийг хянан тогтооход чиглэгдсэн үйл явц юм. Харин хэргийг эцэслэн шийдэх Улсын дээд шүүхийн хуралдаан болон түүнээс гарах шийдвэр нь Улсын дээд шүүхийн эцсийн шийдвэр болно." гэж дүгнэсэн байдаг. Тиймээс хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцэх эсэх асуудлыг

			<p>шийдвэрлэхдээ хуульд заасан үндэслэлээр гомдол гаргасан эсэхийг хянадаг байдлыг тодруулан төсөлд тусгав. Одоо байгаа хуулийн үйлчлэл нь тодорхойгүй, хуульд заасан үндэслэлээр гомдол гаргасан эсэх нь ач холбогдолгүй байхаар хуульчлагдсан. Тодруулбал хяналтын шатны шүүхийн 4 ба түүнээс дээд шүүгч санал гаргаагүй л бол хуульд заасан журмын дагуу гаргасан эсэхээс үл хамааран гомдол, эсэргүүцэл хяналтын шатны шүүх хуралдаанаар агуулгын хувьд хянан шийдвэрлэгдэх боломжгүй байдал үүссэн.</p>
40.8 дугаар зүйл.Хяналтын шатны шүүхийн шийдвэр			
78	<p>40.8 дугаар зүйлийн 1.Хяналтын шатны шүүх дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана:</p>	<p>Хэсэг өөрчлөн найруулах</p> <p>40.8 дугаар зүйлийн 1.Хяналтын шатны шүүх хяналтын журмаар гаргасан гомдол, эсэргүүцлийн үндэслэл, шаардлагын хүрээнд дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана:</p>	<p>“Шүүх нь Үндсэн хуулиар тогтоосон зарчим болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тусгай зарчимд захирагдаж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулдаг. Хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх, шүүгч хараат бус байж гагцхүү хуульд захирагдах, хэрэг маргааныг хамтын зарчмаар шийдвэрлэх гэсэн зарчмууд нь Үндсэн хуулийн зарчим гэх бөгөөд харин талуудын зарчим, мэтгэлцэх буюу шүүх <b>хөндлөнгийн байх</b>, шүүх хуралдааныг нээлттэй, тасралтгүй явуулах, монгол хэл дээр явуулах, эх хэлээрээ мэдүүлэг тайлбар өгөх, шүүхийн шийдвэр заавал биелэгдэх гэсэн зарчмуудыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тусгай зарчим гэж үздэг. Дээрх зарчмууд нь “... хүмүүнлэг иргэний ардчилсан нийгмийг цогцлуулан хөгжүүлэх” Үндсэн хуулийн эрхэм зорилгод хүрэхийн тулд шүүхээс шударга</p>

			<p>ёсыг тогтооход үндсэн үзэл баримтлал нь болдог. Тиймээс шүүхийн шударга байдал нь процессын шударга байдлаар тодорхойлогддог учиртай.” Гэж Үндсэн хуулийн цэцэд гаргасан хүсэлтдээ Улсын дээд шүүх дурдсан байдаг. (Цэцийн 2018-02-02-ны өдрийн №02 дүгнэлт) Шүүх хөндлөнгийн байх зарчим нь зөвхөн анхан шатны шүүхэд хамааралтай биш ба бусад шатны шүүхэд ч мөн хамааралтай. Мөн түүнчлэн шүүх хөндлөнгийн байх зарчим нь эрүү, иргэн, захиргааны аль маргааны төрөл байхаас үл хамаараад аль ч хэргийн харьяаллын шүүхэд хамааралтай зарчим юм. Тиймээс хяналтын шатны шүүхэд гаргасан гомдол, эсэргүүцэлд дурдагдсан шаардлагаас гадуур буюу хяналтын шатны шүүх өөрөө дур мэдэн шийдвэр гаргах нь шүүх хөндлөнгийн байх зарчимд үл нийцэх тул хяналтын шатны шүүхийн шийдвэр гаргах хүрээ хязгаарыг зөвхөн гомдол, эсэргүүцлийн шаардлагаар хязгаарлахаар төсөлд тусгав. Энэ нь маргалдагч талуудын шүүхийн өмнө эрх тэгш байх, мэтгэлцэх зарчимд мөн хамааралтай гэж үзэв.</p>
79		<p>Заалт нэмэх</p> <p>40.8 дугаар зүйлийн 1.3.Энэ хуулийн 39.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил тогтоогдсон бол шийдвэр, магадлалыг хүчингүй болгож хэргийг дахин хэлэлцүүлэхээр</p>	<p>Үндсэн хуулийн цэцийн 2017-04-12-ны өдрийн 03 дүгнэлтэд “Хяналтын шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зөвхөн анхан болон давж заалдах шатны шүүх эрүүгийн хэргийг шийдвэрлэхдээ Эрүүгийн хуулийг зөв хэрэглэсэн эсэх, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн эсэх тухай хууль хэрэглээний асуудлыг хянан хэлэлцдэг онцлогтой” гэж дүгнэсэн байдаг. Өөрөөр хэлбэл</p>

		хэргийг тухайн шатны шүүхэд буцаах.	<p>хяналтын шатны шүүх нь процессын хууль зөрчсөн зөрчлийг хянан шийдвэрлэх эрх мэдэлтэй. Нөгөө талаас хуульд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль ноцтой зөрчих үндэслэл бүрийг тогтоон хуульчилсан, энэ талаар хяналтын журмаар гомдол гаргах эрхийг мөн хуульчилсан. Тиймээс тухайн асуудлыг шийдвэрлэх шийдвэр хуульд тусгагдаагүй байгааг харгалзан хуульд оруулахаар төсөлд тусгав.</p> <p>Түүнчлэн энэ талаар дээд шүүхийн 2006-03-20 №10 тогтоолд “1. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 326 дугаар зүйлийн 326.1 дэх хэсэгт заасан "Давж заалдах шатны шүүхийн магадлалыг уншиж сонсгомогц нэн даруй заавал биелүүлнэ" гэдгийг "Хэргийг анхан шатны шүүхээр дахин хэлэлцүүлэхээр болон нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаахтай холбогдуулж давж заалдах шатны шүүхээс гаргасан магадлал нь нэн даруй заавал биелэгдэх ба энэ магадлалд хяналтын шатны журмаар гомдол, эсэргүүцэл гаргаж болохгүй" гэж ойлгосугай.” гэж хууль зөв хэрэглэх талаар тайлбар гаргаж байсан.</p>
80	40.8 дугаар зүйлийн 4.Хяналтын шатны шүүхийн тогтоол шүүхийн эцсийн шийдвэр байх ба уг тогтоолд гомдол гаргахгүй.	<p>Хэсэг өөрчлөн найруулах</p> <p>40.8 дугаар зүйлийн 4.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хяналтын шатны шүүхийн тогтоолд гомдол гаргахгүй.</p>	<p>Үндсэн хуулийн 50-р зүйлийн 2-т “Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ. Хэрэв Улсын дээд шүүхийн шийдвэр хуульд харшилбал түүнийг Улсын дээд шүүх өөрөө хүчингүй болгоно.” гэж заасан. Хяналтын шатны шүүхийн тогтоол эцсийн байх нь Үндсэн хуульд нийцэхгүй. Энэ талаар Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 05 тогтоол гарсан байдаг.</p>

			<p>Тогтоолын тогтоох хэсэгт “1. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийн “Хяналтын шатны шүүхийн тогтоол эцсийнх байна. ...” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд ... Хэрэв Улсын дээд шүүхийн шийдвэр хуульд харшилбал түүнийг Улсын дээд шүүх өөрөө хүчингүй болгоно. ...” гэсэн заалтыг зөрчсөн байх тул хүчингүй болгосугай.” гэсэн байдаг. Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн байдаг. Иймд хяналтын шатны шүүхийн шийдвэр эцсийн байх зохицуулалтын Үндсэн хууль, Цэцийн шийдвэрт нийцүүлэн, тодорхой үндэслэлээр хяналтын шатны шүүхийн тогтоолд гомдол гаргах эрхийг хангах байдлаар төсөлд тусгав.</p>
81		<p>Хэсэг нэмэх</p> <p>40.8 дугаар зүйлийн 6. Хяналтын журмаар гаргасан гомдол, эсэргүүцэлд дурдагдаагүй, түүнчлэн хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцээгүй асуудлыг зөвлөлдөх тасалгаанд хэлэлцэж болохгүй бөгөөд шийдвэрийн үндэслэл болгохгүй.</p>	<p>Шүүх хэргийн бодит байдлыг талуудын мэтгэлцээний үндсэн дээр тогтоох нь шүүх хөндлөнгийн байх үндсэн зарчим. Шүүх хуралдаанаар хэлэлцээгүй асуудал зөвлөлдөх тасалгаанд хэлэлцэгдэж улмаар шүүхийн шийдвэрийн үндэслэл болох нь шүүх хөндлөнгийн байх зарчимд нийцэхгүй. Шүүх эрх мэдлийн этгээдийн гүйцэтгэх эрх мэдлийн этгээдээс ялгагдах үндсэн шинж нь тодорхой маргаантай асуудлыг өөрөө санаачилагаар шийдэхгүй байх, талуудын байр суурь тайлбарыг</p>

		сонсох, талуудын оролцоог хангах, мэтгэлцээний тэгш байдлыг хангасны үндсэн дээр хуульд захирагдан шийдвэр гаргахад оршдог. Тиймээс хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцээгүй асуудлыг зөвлөлдөх тасалгаанд хэлэлцэхгүй байх, хяналтын шатны шүүхийн шийдвэрийн үндэслэл болохгүй байх талаар төсөлд тусгав.
40.10 дугаар зүйл.Хяналтын шатны шүүхийн шийдвэрт гомдол гаргах		
82	<p>Зүйл нэмэх</p> <p><b>40.10 дугаар зүйл.Хяналтын шатны шүүхийн шийдвэрт гомдол гаргах</b></p> <p>40.10 дугаар зүйлийн 1.Хяналтын шатны шүүхийн шийдвэр Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн гэж үзвэл шүүгдэгч, түүний өмгөөлөгч уг шийдвэрийг гардан авснаас хойш 30 хоногийн дотор Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчид гомдол гаргаж болно.</p> <p>2.Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч гомдлыг хянан үзэж 30 хоногийн дотор дүгнэлт гаргана. Дүгнэлтэд гомдол үндэслэлтэй, эсхүл</p>	<p>Монгол Улсын Үндсэн хуулийн 16-р зүйлийн 13, 14-т хүний эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх харилцаан дахь үндсэн эрх болгон баталгаажуулсан байдаг. Тухайлбал халдашгүй, чөлөөтэй байх, хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх зэрэг үндсэн эрх. Үүнээс гадна зарим харилцааг шууд зохицуулсан байдаг. Тухайлбал өрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглох, гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг</p>

		<p>үндэслэлгүй талаар тусгасан байна.</p> <p>3.Гомдол үндэслэлтэй гэж дүгнэлт гарсан бол Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн дүгнэлтийг хэлэлцэнэ.</p> <p>4. Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн дүгнэлт үндэслэлтэй гэж Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаас үзвэл дагуу хяналтын шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгоно.</p> <p>5.Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн дүгнэлт Үндсэн хууль зөрчсөн эсэх маргааныг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд заасан журмын дагуу хянан шийдвэрлэнэ.</p> <p>6. Улсын дээд шүүхийн шийдвэр эцсийн байна. Улсын дээд шүүхийн шийдвэр хуульд харшилбал түүнийг Улсын дээд шүүх өөрөө хүчингүй болгоно.</p>	<p>үйлдсэн гэм буруутайд тооцож үл болох, гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглох, хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгөх, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглох, хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй байх, баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэх, иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаалах зэрэг харилцааг шууд Үндсэн хуульд заан хуульчилсан.</p> <p>Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шатанд хүний үндсэн эрх буюу Үндсэн хуулийн холбогдох зохицуулалт зөрчигдсэн тохиолдолд уг эрхийг хэрхэн хангах, хамгаалах талаар хуульд тусгагдахгүй байсаар өнөөдрийг хүрсэн. Үүнээс шалтгаалж хэрэг хянан шийдвэрлэх эрх бүхий этгээдийн зүгээс үндсэн эрхийг буюу Үндсэн хуулийг “үл ойшоох” хандлага ажиглагддаг. Энэ ч үүднээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шатанд үндсэн эрх зөрчигдөх тохиолдолд Үндсэн хуулийн 66.2.3 дахь заалтад Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Үндсэн хууль зөрчсөн эсэх асуудлыг Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэхээр заасан байдаг. Энэ нь Үндсэн хууль нь хэрэг хянан шийдвэрлэх бүх шатанд бүрнээ хэрэгжих,</p>
--	--	--	--

			<p>түүний хэлбэрэлтгүй дагаж мөрдөн үндэс болдог. Тиймээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Үндсэн хууль зөрчигдсөн, тэр нь залруулагдаагүй тохиолдолд Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчид гомдол гаргах, Ерөнхий шүүгч дүгнэлт гаргах, Үндсэн хуулийн цэцэд тухайн асуудлаар өргөдөл гаргаж хүний үндсэн эрхийг хамгаалах боломжийг бүрдүүлэхээр төсөлд тусгав.</p>
--	--	--	---

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29.3-т “Шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулна.” Гэсний дагуу Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулсантай холбогдуулан бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай дагалдах хуулийн төсөл боловсруулсан ба дараах байдлаар танилцуулж байна. Үүнд:

**ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

	Хууль	Төсөл	Танилцуулга
<b>1 дүгээр зүйл.Хуулийн зорилт</b>			
1	1 дүгээр зүйлийн 1.1.Энэ хуулийн зорилт нь иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын хооронд үүссэн иргэний эрх зүйн маргааныг шүүх иргэний хэрэг үүсгэн хянан <b>шийдвэрлэхтэй</b> холбогдсон харилцааг зохицуулахад оршино.	Үг өөрчлөх  1 дүгээр зүйлийн 1.1.Энэ хуулийн зорилт нь иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын хооронд үүссэн иргэний эрх зүйн маргааныг шүүх иргэний хэрэг үүсгэн хянан <b>шийдвэрлэх, хэргийн оролцогчийн шударгаар шүүлгэх эрхийг хангахтай</b> холбогдсон харилцааг зохицуулахад оршино.	Үндсэн хуулийн 16-р зүйлийн 14-т “шударга шүүхээр шүүлгэх” эрхийг баталгаажуулсан. Энэхүү эрхийг Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 10-р зүйлд заасан “шударгаар шүүлгэх” эрхтэй ижил агуулгатай гэж Үндсэн хуулийн цэц 2021 оны 07 дүгнэлтэд туссан байдаг. Шударга шүүх буюу шударгаар шүүлгэх гэдэг нь хуулийн болон ёс суртахууны хувьд тухайн хэрэг, маргааныг тэгш, тал засалгүй, баримт нотолгоонд тулгуурлан, хуулийн дагуу шийдвэрлэхийг хэлэх бөгөөд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль нь бүхэлдээ иргэний шударга шүүхээр шүүлгэх эрхийг хангатай холбоотой харилцаа юм. Тиймээс хуулийн зорилтод энэхүү зарчмыг оруулахаар төсөлд тусгав.
<b>9 дүгээр зүйл.Шүүх хуралдааныг тасралтгүй явуулах</b>			
2	9 дүгээр зүйлийн 9.1.Бүх шатны шүүхийн шүүх хуралдааныг <b>өдрийн цагаар</b> , амрах зайлшгүй	Үг өөрчлөх  9 дүгээр зүйлийн 9.1.Бүх шатны шүүхийн шүүх хуралдааныг <b>ажлын цагаар явуулах ба энэ</b>	Шүүх хуралдааныг энэ хуульд өөрөөр заагаагүй бол зөвхөн ажлын цагаар явуулахаар төсөлд тусгалаа. Шүүх хуралдаан нь зөвхөн шүүгчийн хөдөлмөрийн асуудал биш ба хуралдаанд оролцож байгаа оролцогч тус бүрийн хөдөлмөрийн асуудал мөн

	шаардлагатайгаас бусад цагт тасралтгүй явуулна.	<b>хуульд заасны дагуу шүүх хуралдааныг завсарлуулсан болон</b> амрах зайлшгүй шаардлагатайгаас бусад цагт тасралтгүй явуулна.	хөндөгдөнө. Хөдөлмөрийн тухай хуульд нэг хоногт ажиллах ажлын цагийг 8 цаг байхаар тогтоосон байдаг. Үүнээс гадна шүүх хуралдаан хуульд заасан үндэслэл, нөхцөл байдал, давагдашгүй нөхцөл байдлын улмаас тодорхой хугацаагаар завсарлаж болдог. Хуралдаан завсарласан үеийг шүүх хуралдаан тасралтгүй үргэлжилж байна гэж үзэх үндэслэл болохгүй. Тиймээс шүүх хуралдаан завсарлах, амрах шаардлагатайгаа бусад цагт шүүх хуралдаан тасралтгүй үргэлжлэх талаар төсөлд тусгав.
3	9 дүгээр зүйлийн 9.2.Шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч шүүх хуралдаанаар нэгэнт хэлэлцэж эхэлсэн хэргийг хянан шийдвэрлэж дуусах буюу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хойшлуулах, түдгэлзүүлэх хүртэл өөр хэргийг хянан шийдвэрлэх эрхгүй.	Үг нэмэх 9 дүгээр зүйлийн 9.2.Шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч шүүх хуралдаанаар нэгэнт хэлэлцэж эхэлсэн хэргийг хянан шийдвэрлэж дуусах буюу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хойшлуулах, түдгэлзүүлэх, <b>энэ хуульд заасны дагуу шүүх хуралдааныг завсарлуулах</b> хүртэл өөр хэргийг хянан шийдвэрлэх эрхгүй.	Шүүх хуралдаан хойшлох шалтгаан, нөхцөлийг тодруулах нь сэдэвт судалгааг Шүүхийн захиргааны сургалт, судалгааны төвөөс хийж гүйцэтгэсэн байдаг. Уг судалгаанд шүүх хурал нь хойшилж байсан нийт 68 оролцогчоос 63% нь иргэний хэргийн анхан шатны шүүхээр үйлчлүүлсэн иргэдийн 63%-д нь нь хүндрэлтэй байдал үүсгэсэн байна гэжээ. Улмаар судалгаанд хурал хойшилсон шалтгаануудыг харахад өмгөөлөгч авах хүсэлт гаргасан, хэргийн оролцогчид нотлох баримт гаргуулах хүсэлт гаргасан, шүүх хуралдаанд шинжээч ирээгүй, нотлох баримт гаргуулах хүсэлт гаргасан, нэхэмжлэлийн шаардлагаа нэмсэн буюу өөрчилсөн гэсэн байна. Үүнээс харахад иргэн шүүхийн журмаар асуудлаа шийдвэрлүүлэхэд цаг хугацаа маш их зарцуулдаг болох нь харагдаж байна гэжээ. Өөрөөр хэлбэл хэргийн зохигч талуудаас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрхэн хариуцлагатай хандахаас шалтгаалж шүүх хуралдаан хойшлох, улмаар хэрэг хянан шийдвэрлэх явц үр дүнгүй шалтгаанаар дахин дахин хойшилдог

			<p>нөхцөл байдал судалгааны дүнгээс тодорхойлогдож байна. Шүүх хуралдаан хойшлох болгонд шинээр эхлэх бол шүүх хуралдаан бүрийн өмнө талуудаас шинэ шинэ хүсэлт гаргаж, түүнийг шийдвэрлэхэд багагүй хугацаа зарцуулагддаг. Тиймээс шүүх хуралдаан зарлагдсаны дараа бус иргэний хэрэг үүссэний дараа зохигч талууд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ач холбогдол өгч оролцдог болох шаардлагатай. Энэ үүднээс шүүх хуралдаан хойшлохоос гадна завсарлах гэсэн ойлголтыг хуульд нэмэлт оруулахаар төсөлд тусгав. Шүүх хуралдаан богино ба урт хугацаагаар завсарладаг процессын жишиг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байдаг. Энэ нөхцөл байдлыг харгалзан шүүх хуралдаан эхэлсний талууд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай ямар нэг хүсэлт гаргасан, түүнийг нь шийдвэрлэх шаардлагатай тохиолдол үүссэн үед тухайн асуудал шийдэгдэх хугацаагаар (хэрэг түдгэлзүүлэхээс бусад тохиолдолд) шүүх хуралдааныг завсарлуулж, улмаар шүүх хуралдааныг завсарлуулсан үеэс шүүх хуралдааныг үргэлжлүүлдэг байдлаар төсөлд тусгав.</p>
<p><b>62 дугаар зүйл.Нэхэмжлэлийн бүрдүүлбэр</b></p>			
4		<p>Хэсэг нэмэх</p> <p>62 дугаар зүйлийн 62.4.Нэхэмжлэлд нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдийн утасны дугаар, цахим хаяг, цахим сүлжээн дэх харилцаа холбооны</p>	<p>Харилцаа холбооны шинэ цахим хэлбэрүүд үүсэж байгаатай холбогдуулан шүүх ба хэргийн оролцогч хоорондын харилцаа холбоог хялбар, түргэн болгох боломжтой болгох үүднээс энэхүү заалтыг хуульд нэмэлт оруулахаар төсөлд тусгав.</p>

		программ хангамжид холбогдсон утасны дугаарыг хавсарган ирүүлж болно.	
<b>65 дугаар зүйл.Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах</b>			
5	65.1.8.уг нэхэмжлэлтэй холбоотой хэргийг эрүүгийн журмаар шалгаж байгаа;	Үг өөрчлөх 65 дугаар зүйлийн 65.1.8.уг нэхэмжлэлтэй холбоотой хэргийг эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байгаа.	2017 онд шинээр батлагдсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар хэрэг бүртгэлийн хэрэг, эрүүгийн хэрэг гэж зааглан ялгасан. Тухайлбал гэмт хэргийг илрүүлэх, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоох зорилгоор гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл хүлээн авснаас эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах хүртэл явуулж байгаа энэ хуульд заасан ажиллагааг хэрэг бүртгэлт гэхээр заасан. Харин эрүүгийн хэрэг гэдэг нь яллагдагчаар татах тогтоол үйлдсэнээс хэргийг шүүхэд шилжүүлэх хүртэл хэргийн талаар нотлогдвол зохих байдлыг тогтоох зорилгоор явуулж байгаа энэ хуульд заасан ажиллагааг хэлэхээр заасан. Тиймээс гэмт хэрэг үйлдсэн этгээд нь тогтоогдож, яллагдагчаар татаж, эрүүгийн хэрэг үүсгэсэн бол тухайн маргаантай үйл баримттай холбоотой асуудлыг иргэний журмаар шүүх шийдэхгүй, тухайн маргаантай холбоотой нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах байдлаар төсөлд тусгав.
<b>67 дугаар зүйл.Хэрэг үүсгэсэн шүүгчийн ажиллагаа</b>			
6	67 дугаар зүйлийн 67.1.1.зохигч, гуравдагч	Хэсэг өөрчлөн найруулах	Дийлэнх тохиолдолд зохигчид шүүх хуралдаанд эсхүл өмнө нь эрх үүрэгтэйгээ танилцаж, шүүхээр шийдвэрлүүлэх шаардлагатай хүсэлтээ шүүх

	этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгчид шаардлага ба татгалзлаа үндэслэж буй нотлох баримтаа өөрөө гаргаж нотлох үүрэгтэйг танилцуулж, эдлэх эрхийг нь тайлбарлан өгөх;	67 дугаар зүйлийн 67.1.1.зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгчийг дуудан ирүүлж шаардлага ба татгалзлаа үндэслэж буй нотлох баримтаа өөрөө гаргаж нотлох үүрэгтэйг танилцуулж, хуульд заасан эдлэх эрхийг нь тайлбарлан өгч энэ тухайгаа баримтжуулах;	хуралдаанд гаргадаг. Тиймээс зохигч талуудын хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх үүднээс хэрэг үүсгэсэн шүүгчийн ажиллагааны хүрээнд талуудыг дуудан ирүүлж, эрх үүргийг танилцуулан энэ талаар албажуулах шаардлагатай талаар төсөлд тусгав.
<b>69 дүгээр зүйл.Шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах</b>			
7	69 дүгээр зүйлийн 69.1.Шүүгч нэхэмжлэгчийн хүсэлтийг үндэслэн шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах дараахь арга хэмжээг <b>хэрэг үүсгэхдээ буюу үүсгэсний дараа</b> захирамж гарган авах эрхтэй:	Үг өөрчлөх  69 дүгээр зүйлийн 69.1.Шүүгч нэхэмжлэгчийн хүсэлтийг үндэслэн шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах дараахь арга хэмжээг <b>шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр</b> захирамж гарган авах эрхтэй:	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг оруулахаар төсөлд тусгасан. Үнтэй холбоотойгоор шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах асуудлыг урьдчилсан хэлэлцүүлгээр буюу талуудыг байлцуулан, байр суурийг сонсож мэтгэлцүүлэн шүүх хөндлөнгийн журмаар шийдвэрлэхээр төсөлд тусгав. Шүүхээс гарах шийдвэрийг баталгаажуулах нь нэхэмжлэгийн эрх хууль ёсны ашиг сонирхлыг хангах зорилготой хэдий ч нөгөө талдаа хариуцагч этгээдийн эрх хууль ёсны ашиг сонирхлыг дордуулахгүй, зөрчихгүй байх үүднээс уг асуудлыг шүүхийн хэлэлцүүлгээр шийдвэрлэж байхаар төсөлд тусгав.
<b>ДОЛДУГААР БҮЛЭГ <sup>2</sup> ШҮҮХИЙН УРЬДЧИЛСАН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ /бүлэг нэмэх/</b>			
8		Бүлэг нэмэх  <b>ДОЛДУГААР БҮЛЭГ <sup>2</sup> ШҮҮХИЙН УРЬДЧИЛСАН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ</b>	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд “урьдчилсан хэлэлцүүлгийн шүүх хуралдаан” байх нь маргааныг үр дүнтэй, хурдан, шударгаар шийдвэрлэхэд ач холбогдолтой байдаг.

		<p>75<sup>12</sup> дугаар зүйл. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг явуулах журам</p> <p>75<sup>12</sup>.1.Шүүгч дараахь хүсэлтийг урьдчилсан хэлэлцүүлгээр хянан хэлэлцэнэ:</p> <p>75<sup>12</sup>1.1.зохигч талуудын өөрөө олж авах боломжгүй нотлох баримтыг шүүхийн журмаар гаргуулах;</p> <p>75<sup>12</sup>1.2.шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах;</p> <p>75<sup>12</sup>1.3.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх;</p> <p>75<sup>12</sup>1.4.нэхэмжлэл хүлээн авахаас татгалзах үндэслэл байгаа үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгож, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах;</p> <p>75<sup>12</sup>1.5.тэмдэгтийн хураамжийн хэмжээний асуудал;</p> <p>75<sup>12</sup>1.6.хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх асуудал;</p> <p>75<sup>12</sup>1.7.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой бусад асуудал;</p>	<p>Урьдчилсан хэлэлцүүлэг нь анхан шатны шүүх хуралдааны өмнө явагдах “тусгай шүүх хуралдаан” хэлбэртэй бай маргааны хүрээ, гол асуудлыг тодорхойлох, нотлох баримтыг тодруулах, зохион байгуулах, эвлэрүүлэх боломжийг судлах, процессын хэмжээ, хугацааг тодорхой болгох зорилготой. Тодруулбал</p> <p>Процессын үр ашиг: Хурлын өмнө талуудын байр суурийг тодруулж, маргааны гол цөмийг тодорхойлсноор хэрэг хуралдаан үр ашигтай болдог. Шүүх, талууд шаардлагагүй маргаанаас зайлсхийж, анхаарлаа зөв асуудалд төвлөрүүлнэ.</p> <p>Шүүхийн ачааллыг бууруулах: Бэлтгэлгүй, дутуу нотолгоотой хэрэг маргаан шүүх хурлын үр ашгийг бууруулж, удаашруулах үндэслэл болдог. Урьдчилсан хуралдаан нь хэрэг бэлэн биш бол хойшлуулах, шаардлага хангахгүй баримтыг илрүүлэх боломж олгоно.</p> <p>Талуудыг эвлэрүүлэх: Олон улсад урьдчилсан хэлэлцүүлгийн үеэр шүүгч талуудад эвлэрэх санал тавьж, маргааныг шийдвэрлэх эрт боломжийг бүрдүүлнэ. Энэ нь шүүхийн шийдвэрээс хамааралгүйгээр хурдан шийдэлд хүрэх давуу талтай.</p> <p>Эрх зүйн зарчмыг хангах: Хариуцагч, нэхэмжлэгчид эрхээ бүрэн эдлэх, хариу өгөх, хамгаалах боломж олгодог тул шударгаар шүүлгэх эрх хангагдах нэг үндэслэл болно.</p> <p>Манай улсад эрүү, захиргааны процессын ажиллагаанд урьдчилсан хэлэлцүүлгийн талаарх хэм хэмжээ ороод багагүй хугацаа өнгөрсөн ба тодорхой үр дүнтэй механизм болж чадсан билээ.</p>
--	--	---	---

		<p>75<sup>12</sup>1.8.шүүх хуралдаан товлох асуудал;</p> <p>75<sup>12</sup>.2.Шүүх хуралдааныг товлон зарлахад урьдчилсан хэлэлцүүлэг хийнэ.</p> <p>75<sup>12</sup>.3.Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн товыг гурваас доошгүй хоногийн өмнө хэргийн оролцогчид, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчид мэдэгдэнэ.</p> <p>75<sup>12</sup>.4.Хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч урьдчилсан хэлэлцүүлэгт оролцохгүй тухай шүүхэд мэдэгдэх бөгөөд мэдэгдээгүй нь урьдчилсан хэлэлцүүлэг явуулахад саад болохгүй.</p> <p>75<sup>12</sup>.5.Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг мэтгэлцэх зарчмаар явагдах бөгөөд хэргийн оролцогчид гаргасан хүсэлт, татгалзлын үндэслэлээ нотолно.</p> <p>75<sup>12</sup>.6.Хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй нь шүүхийн</p>	<p>Иймд иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйд урьдчилсан хэлэлцүүлэг гэх шинэ бүлэг нэмэхээр тусгав.</p> <p>Урьдчилсан хэлэлцүүлгээр хэрэг хянан шийдвэрлэхээс бусад процессын үед авч хэрэгжүүлдэг ажиллагааг шийдвэрлэж байхаар төсөлд тусгасан болно.</p>
--	--	--	---

		<p>урьдчилсан хэлэлцүүлгийг хойшлуулах үндэслэл болохгүй.</p> <p>75<sup>12</sup>.7.Шаардлагатай бол энэ хуулийн 70.1-д заасан хугацааг нэг удаа 10 хүртэл хоногоор шүүгч сунгаж болно.</p> <p>75<sup>12</sup>.8.Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг шүүгч дангаар удирдан явуулах бөгөөд шүүхийн хэлэлцүүлгийн тэмдэглэлтэй хэргийн оролцогч танилцаж болно.</p> <p>75<sup>12</sup>.9.Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр маргааны үйл баримт, нэхэмжлэлийн шаардлагатай холбоотой асуудлыг хэлэлцэхгүй.</p> <p>75<sup>12</sup>.10.Хариуцагчийн тайлбар гаргах хуульд заасан хугацаа дууссан нь шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг явуулах үндэслэл болно.</p> <p>75<sup>12</sup>.11.Хариуцагч сөрөг нэхэмжлэл гаргасан, нэхэмжлэгч нэхэмжлэлийн шаардлагаа нэмэгдүүлсэн, өөрчилсөн бол урьдчилсан хэлэлцүүлгийг хойшлуулж, хариуцагч тал тайлбар өгөх боломжоор шүүх хангана.</p>	
--	--	--	--

**76 дугаар зүйл.Шүүх хуралдааны бэлтгэл хангах шүүгчийн ажиллагаа**

9	<p>76 дугаар зүйлийн 76.1.1.хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдолтой нотлох баримт хангалттай бүрдсэн гэж шүүгч үзсэн, эсхүл энэ хуулийн 71.1-д заасан хугацаа дууссан, түүнчлэн шаардлагатай гэж үзсэн бусад тохиолдолд шүүгч уг хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай захирамж гаргаж, шүүх хуралдаан хэзээ, хаана болохыг товлох;</p>	<p><b>Заалт өөрчлөн найруулах</b></p> <p>76 дугаар зүйлийн 76.1.1.хариуцагч хариу тайлбараа ирүүлсэн, эсхүл хуульд заасан 14 хоногийн дотор буюу шүүгчээс тогтоосон хугацаанд хариу тайлбараа ирүүлээгүй, түүнчлэн шаардлагатай бусад тохиолдолд шүүх хуралдааныг хэзээ, хаана болохыг урьдчилсан хэлэлцүүлгийн журмаар товлож, долоо, түүнээс доошгүй хоногийн өмнө зарлаж, хэргийн оролцогч, бусад оролцогчид хурлын товыг мэдэгдэнэ.</p>	<p>Нэхэмжлэл гардаж авсан хариуцагч хариу тайлбарыг 14 хоногт гаргаж өгөх үүрэгтэй байдаг. Энэ хугацаанд хариуцагч тайлбар гаргаж өгсөн хэдий ч шүүхээс хуульд хугацаандаа баригдан буюу 60+30 хоногт багтаан шүүх хуралдааныг товлон зарлах нь дийлэнх болдог. Тухайн хугацаанд шүүх хуралдаан зарлагдсан байсан тодорхой шалтгааны улмаас дахин дахин шүүх хуралдаан хойшилж болдог ба үүнээс шалтгаалж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа үр дүнгүйгээр буюу механикаар уртсах үндэслэл болдог. Нөгөө талаас хариуцагч хариу тайлбараа заасан хугацаанд ирүүлээгүй бол нэхэмжлэлийн шаардлага хүлээн зөвшөөрсөнд тооцохоор хуульд заасан хэдий ч энэ зохицуулалт тэр бүр хэрэгждэггүй. Тиймээс нэгэнт хариуцагч хариу тайлбараа ирүүлсэн, эсхүл хуульд заасан 14 хоногийн дотор буюу шүүгчээс тогтоосон хугацаанд хариу тайлбараа ирүүлээгүй, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг явуулах хүсэлт ирүүлээгүй бол шүүх хуралдааныг товлон зарлаж байх нь зохигч талууд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүндэтгэлтэй хандах, хариуцлагатай хандах нөхцөл болно гэж үзэв.</p>
---	--	---	--

**77 дугаар зүйл.Шүүхийн мэдэгдэх хуудас**

10	<p>77 дугаар зүйлийн 77.1.Зохигч, түүнчлэн шүүх хуралдаанд ирвэл зохих бусад оролцогчдод</p>	<p>Үг өөрчлөх</p>	<p>Нэгэнт эхэлсэн шүүх хуралдаан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой тодорхой асуудлыг шийдвэрлэсний улмаас олон дахин хойшлох, тэр болгон шүүх хуралдаан шинээр эхлэх</p>
----	--	-------------------	--

	<p>шүүх хуралдаан <b>хэзээ, хаана болохыг</b> шүүхийн мэдэгдэх хуудсаар тэдгээрийн оршин суугаа буюу ажлын газрын хаягаар мэдэгдэнэ. Хүрэлцэн ирээгүйгээс гарах үр дагавар болон энэ хуулийн 100 дугаар зүйлд зааснаар хэргийг хянан шийдвэрлэж болохыг шүүхийн мэдэгдэх хуудсанд заана.</p>	<p>77 дугаар зүйлийн 77.1.Зохигч, түүнчлэн шүүх хуралдаанд ирвэл зохих бусад оролцогчдод шүүх хуралдаан <b>хэзээ, хаана болох, үргэлжлэх талаар</b> шүүхийн мэдэгдэх хуудсаар тэдгээрийн оршин суугаа буюу ажлын газрын хаягаар мэдэгдэнэ. Хүрэлцэн ирээгүйгээс гарах үр дагавар болон энэ хуулийн 100 дугаар зүйлд зааснаар хэргийг хянан шийдвэрлэж болохыг шүүхийн мэдэгдэх хуудсанд заана.</p>	<p>шаардлагатай болдог. Харин төсөлд шүүх хуралдаан “завсарлах” гэсэн ойлголтыг хуульд оруулахаар тусгасантай холбогдуулан энэ заалтад шүүх хуралдаан хэзээ хаана үргэлжлэн хуралдах талаар мэдэгдэх харилцааг тусгав.</p>
11	<p>77 дугаар зүйлийн 77.2.Шүүхийн мэдэгдэх хуудсыг зохигч талын оршин суугаа буюу ажлын газрын хаягаар баталгаат шуудангаар, эсхүл шүүхийн ажилтнаар биечлэн хүргүүлнэ. Шаардлагатай тохиолдолд шүүхийн мэдэгдэх хуудсыг утас, факс, цахилгаан буюу олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан мэдэгдэж болно. Ийнхүү мэдэгдсэнээ баримтжуулсан байна.</p>	<p>Үг нэмэх</p> <p>77 дугаар зүйлийн 77.2.Шүүхийн мэдэгдэх хуудсыг зохигч талын оршин суугаа буюу ажлын газрын хаягаар баталгаат шуудангаар, эсхүл шүүхийн ажилтнаар биечлэн хүргүүлнэ. Шаардлагатай тохиолдолд шүүхийн мэдэгдэх хуудсыг утас, <b>мессеж, цахим сүлжээн дэх харилцаа холбооны программ хангамж, цахим хаяг</b>, факс, цахилгаан буюу олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан мэдэгдэж баримтжуулна. Ийнхүү баримтжуулсан нь шүүхийн</p>	<p>Орчин үед харилцаа холбооны шинэ цахим хэлбэрүүд үүсэж байгаатай холбогдуулан шүүх ба хэргийн оролцогч хоорондын харилцаа холбоог хялбар, түргэн болгох боломжтой болгох үүднээс энэхүү заалтыг хуульд нэмэлт оруулахаар төсөлд тусгав.</p>

		мэдэгдэх хуудсыг хүргүүлсэнд тооцох үндэслэл болно.	
<b>84 дүгээр зүйл.Иргэний хэрэг хянан шийдвэрлэхэд шүүгч дахин оролцож болохгүй үндэслэл</b>			
12		<p>Хэсэг нэмэх</p> <p>84 дүгээр зүйлийн 84.3.Иргэний хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэхэд оролцсон шүүгч шийдвэр хүчингүй болсны улмаас уг хэргийг дахин анхан шатны журмаар хянан шийдвэрлэхэд оролцож болохгүй.</p>	<p>Шүүгч хараат бус, хөндлөнгийн байх нь шударга шүүхийн үндсэн зарчим. Улмаар шүүгч өөрийн дотоод итгэлээр нотлох баримтаар үнэлж, маргаан бүхий үйл баримтыг тогтоон хуульд захирагдан хэрэг маргааныг шийдвэрлэдэг. Нэгэнт тодорхой хэрэг маргааныг анхан шатны шүүхийн шүүгч өөрийн дотоод итгэлээр үнэлж шийдвэрлэсэн боловч хүчингүй болсны улмаас тухайн хэлэлцэх үед тухайн шүүгч тухайн хэрэг маргааны өөрөө дахин “шинээр шүүх” нь тухайн шүүгч өөрийн дотоод итгэлтэй зөрчилдөх нөхцөл үүсэж болзошгүй байдаг. Тодруулбал урьдын дотоод итгэлээ дагах уу, эсхүл дээд шатны шүүхийн шийдлийг дагах уу зэрэг асуудал үүсэж болзошгүй ба энэ нь шүүгчийн хараат бус байдалд ч нөлөөлж болох эрсдэл үүсгэдэг. Тиймээс анхан шатын шүүхийн шийдвэр хүчингүй болсны улмаас дахин хэлэлцэх бол тухайн хэрэг маргааны урьд шийдвэрлэсэн шүүгч дахин шийдвэрлэж болохгүй талаар төсөлд тусгалаа. Энэ талаар Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 84.1-д “Дараахь үндэслэл байвал шүүгч хэрэг хянан шийдвэрлэхэд үл оролцох ба өөрөө татгалзан гарах үүрэгтэй: 84.1.6.анхан болон давж заалдах журмаар хэргийг хянан шийдвэрлэхэд оролцсон шүүгч уг хэргийг тухайн</p>

			шатны журмаар хянан шийдвэрлэхэд дахин оролцох болсон.” гэж заасан байдаг.
<b>90 дүгээр зүйл. Шүүх хуралдааны нийтлэг журам</b>			
13	90 дүгээр зүйлийн 90.2. Шүүх хуралдаанд оролцогч мэдүүлэг, тайлбар өгөх, дүгнэлт гаргахдаа суудлаасаа босно. Хуралдаанд оролцогч өвчний улмаас хуралдаан даргалагчийн зөвшөөрлөөр суугаагаараа үг хэлэх буюу мэтгэлцэхэд оролцож болно.	Хэсэг өөрчлөн найруулах 90 дүгээр зүйлийн 90.2. Шүүхийн хуралдааны танхимын зохион байгуулалт, техникийн шаардлагын улмаас шүүх хуралдаанд оролцогч тайлбар, мэдүүлэг өгөх, дүгнэлт гаргахдаа шүүх хуралдаан даргалагчийн зөвшөөрснөөр босож эсхүл суудлаасаа мэдүүлэг өгнө.	Оролцогчид шүүх хуралдаанд мэдүүлэг өгөхдөө босож үг хэлэх, тайлбар гаргахаар хуульд туссаныг техникийн шаардлагын улмаас босоо байдлаар эсхүл суугаа байдлаар үг хэлэх, тайлбар өгөх эсэхийг тухай бүр шүүх хуралдаан даргалагч шийддэг байхаар төсөлд тусгав. Технологи хөгжиж байгаатай холбогдуулан бүхий шүүх хуралдааны дуу дүрс бичлэг цуг авагддаг болсон, уг техник хэрэгсэл нь ихэнхдээ суугаа байрлалтайд зориулагдсан байдаг учир энэхүү өөрчлөлтийг тусгав.
<b>92 дугаар зүйл. Татгалзан гаргах хүсэлт гаргах</b>			
14		Хэсэг нэмэх 92 дугаар зүйлийн 92.9. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдуулан шүүгч захирамж, шүүх бүрэлдэхүүн тогтоол гаргасан нь шүүгчийг татгалзан гаргах үндэслэл болохгүй.	Үндсэн хуулийн 47-р зүйлийн 1-д зааснаар Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ гэсэн. Энэхүү эрх мэдэл нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад болон хэргийг хянан шийдвэрлэж шүүх бүрэлдэхүүн шийдвэр (захирамж, тогтоол, шийдвэр) гаргахыг ойлгодог. Харин шийдвэр хууль тогтоомжид нийцээгүй, хүний эрхийг зөрчсөн бол давж заалдах журмаар шүүхийн шийдвэр хүчингүй болох, өөрчлөгдөх боломжтой байдаг. Энэ нь шүүх эрх мэдлийн үндсэн зарчим юм.

		<p>Хэсэг нэмэх</p> <p>92.10. Энэ хуулийн 92.9-д заасныг зөрчиж гаргасан шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг татгалзан гаргах хүсэлтийг гаргаагүйд тооцон, шүүх хуралдааныг үргэлжлүүлнэ.</p>	<p>Тиймээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгч, шүүх бүрэлдэхүүн шийдвэр гаргасныг шүүх эрх мэдлийг хэрэгжүүлж байгаатай утгачлан ойлгож болох тул эрх мэдлээ хэрэгжүүлсэн нь тухайн шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг татгалзан гаргах үндэслэл болохгүй талаар төсөлд тусгав.</p>
<b>94 дүгээр зүйл.Шийдвэрийг зөвлөлдөх тасалгаанд гаргах</b>			
15		<p>Хэсэг нэмэх</p> <p>94 дугаар зүйлийн 94.3.Хэрэг, маргааныг шийдвэрлэхдээ зөвлөлдөх тасалгаанд дараахь асуудал тус бүрийг хэлэлцэнэ:</p> <p>94.3.1.нэхэмжлэлийн үндэслэл;  94.3.2.хариу тайлбарын үндэслэл;  94.3.3.гуравдагч этгээдтэй хэргийн тухайд гуравдагч этгээдийн тайлбарын үндэслэл;  94.3.4.шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгч оролцсон бол түүний дүгнэлт;  94.3.5.хууль хэрэглээний асуудал.</p>	<p>Түүнчлэн тухайн хэрэг маргааныг хянан шийдвэрлэсэн шүүх зөвлөлдөхдөө талуудын гаргасан тайлбар, үндэслэл, шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгч оролцсон бол түүний дүгнэлт, цаашлаад хууль хэрэглээний асуудлыг зайлшгүй хэлэлцэн дүгнэх талаар төсөлд тусгалаа. Шүүхийн өмнө хүн эрх тэгш буюу мэтгэлцэгч талуудын тэгш байдлыг хангах гол нөхцөл нь маргалдагч талуудын дүгнэлт, гаргалгаа, тайлбарыг шүүх зайлшгүй хэлэлцэж, дүгнэж хариулт өгөхөд оршдог бөгөөд энэ нь шүүх хөндлөнгийн байх зарчимд хамааралтай юм. Маргалдагч талуудын тайлбар, үндэслэлийг хүлээн авсан, няцаасан бол тухайн шийдэлдээ шүүх тайлбар хийхгүй орхих нь иргэдийн шүүхэд үл итгэх байдлыг үүсгэдэг. Тиймээс иргэний хэрэг хянан шийдвэрлэх процессийн эрх зүйд шүүх зөвлөлдөх тасалгаанд яг ямар асуудал хэлэлцэх талаар зохицуулалтгүй байсныг тодорхой болгохоор төсөлд тусгалаа.</p>
<b>104 дүгээр зүйл.Хэргийн оролцогчийн эрх, үүргийг тайлбарлах</b>			

16	<p>104 дүгээр зүйлийн 104.1.Шүүх хуралдаан даргалагч хэргийн оролцогчдод хуульд заасан эрх, үүргийг нь тайлбарлан өгнө.</p>	<p>Зүйл өөрчлөн найруулах</p> <p>104 дүгээр зүйл.Хэргийн оролцогчийн эрх, үүргийг тайлбарлах</p> <p>104 дүгээр зүйлийн 104.1.Хэргийн оролцогч энэ хуулийн 67.1.1-д заасны дагуу эрх, үүрэгтэй танилцаж баримтжуулсан эсэхийг шүүх хуралдаан даргалагч шалгана.</p> <p>104.2.Хэргийн оролцогчид эрх, үүрэгтэй танилцаагүй бол эрх, үүргийг тайлбарлан өгч энэ тухай баримтжуулна.</p> <p>104.3.Хэргийн оролцогчдоос эрх, үүргээс ойлгоогүй зүйл байвал энэ талаар шүүх хуралдаан даргалагч нэмж тайлбарлаж өгнө.</p>	<p>Зохигч тал нэгэнт эрх, үүрэгтэй танилцсан бол шүүх хуралдаан эхлэхийг өмнө энэ талаар шалгаж, танилцаагүй бол нэмж танилцуулах, тодруулах зүйлийг нэмж тайлбарлаж өгдөг байхаар төсөлд тусгав.</p> <p>Түүнчлэн хэргийн оролцогч, бусад оролцогчид эрх, үүрэгтэй танилцаагүй бол эрх, үүргийг тайлбарлан өгч, энэ тухай баримтжуулах, эрх, үүргээс ойлгоогүй зүйл байвал энэ талаар шүүх хуралдаан даргалагч нэмж тайлбарлаж өгөхөөр төсөлд тусгав.</p>
<p><b>105 дугаар зүйл.Хэргийн оролцогчоос гаргасан хүсэлтийг шийдвэрлэх</b></p>			
17	<p>105.1.Шинэ нотлох баримт бүрдүүлэх ба хэрэг хянан шийдвэрлэхтэй</p>	<p>Зүйл өөрчлөн найруулах</p>	<p>Төсөлд урьдчилсан хэлэлцүүлэг гэсэн шинэ зохицуулалт тусгасантай холбогдуулан маргааныг хянан шийдвэрлэх шүүх хуралдааны өмнө хэргийн оролцогчоос гаргах хүсэлтийн хүрээ хязгаарыг</p>

<p>холбогдсон бусад асуудлын талаар хэргийн оролцогчоос гаргасан хүсэлтийг бусад оролцогчийн саналыг сонсмогц шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч даруй шийдвэрлэнэ.</p> <p>105.2.Хэрэг хянан шийдвэрлэхтэй холбогдолтой нэмэлт тайлбар, нотлох баримтыг урьд нь гаргах буюу санал болгох бололцоотой байсан боловч шүүх хуралдааны үед гаргасан нь хүндэтгэн үзэх шалтгаантай гэж шүүх үзвэл түүнийг хүлээн авч, шинжлэн судлах шаардлагатай бол шүүх хуралдааныг нэг удаа хойшлуулж болно.</p>	<p>105 дугаар зүйл.Хэргийн оролцогчоос гаргасан хүсэлтийг шийдвэрлэх</p> <p>105 дугаар зүйлийн 105.1.Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээс хойш шинэ нотлох баримт цугларсантай холбогдуулан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдсон асуудлаар хэргийн оролцогчийн гаргасан хүсэлтийг шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч даруй шийдвэрлэнэ.</p> <p>105 дугаар зүйлийн 105.2.Энэ хуулийн 105.1-д заасны дагуу гаргасан хүсэлтийг шүүх хүлээн авч шийдвэрлэсэн бол шүүх хуралдааныг <b>завсарлуулна</b>.</p> <p>105.3.Энэ хуулийн 105.2-т заасны дагуу шүүх хуралдааныг завсарлуулсан бол хэзээ үргэлжлэх, эсхүл тодорхойгүй хугацаагаар завсарласан бол энэ талаар хэргийн оролцогч болон тэдгээрийн өмгөөлөгчид мэдэгдэж энэ тухай баримтжуулна.</p> <p>105.4.Энэ хуулийн 105.2-т заасны дагуу завсарлуулсан шүүх</p>	<p>багасгахаар төсөлд тусгав. Уул хүсэлтүүдийг урьдчилсан хэлэлцүүлгээр шийдвэрлүүлэх боломжтой ийм зохицуулалтыг төсөлд тусгасан. Шүүх хуралдааны өмнө огт хүсэлт шийдвэрлэхгүй орхигдуулах нь талуудын тэгш байдлыг алдагдуулах эрсдэлтэй тул тодорхой асуудлаар хүсэлт гаргах эрхийг нээлттэй үлдээхээр төсөлд тусгав.</p> <p>Нэгэнт шүүх хуралдаан эхэлсэн хэдий ч түүнийг хойшлуулснаар тухайн шүүх хуралдаан дахин шинээр эхлэх болдог ба энэ нь хоёр ба түүнээс дээш давтагдах нөхцөл болдог. Тиймээс шүүх хуралдааны завсарлуулах гэсэн шинэ зохицуулалт төсөлт тусгахаар хэд хэдэн зүйлд оруулсан.</p> <p>Нэгэнт шүүх хуралдаан завсарласан бол түүнээс гарах үр дагавар, шийдэл, журмыг төсөлд тусгав.</p>
--	--	--

		хуралдааныг завсарласан үеэс нь үргэлжлүүлнэ.  105.5.Энэ хуульд заасны шүүх хуралдаан завсарласан нь шүүх бүрэлдэхүүнээс бусад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулах, өмгөөлөгч өөр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоход саад болохгүй.	
<b>112 дугаар зүйл.Хэргийн оролцогчоос нэмж тодруулах</b>			
18	112.1.Нотлох баримт шинжлэн судалсны дараа шүүх хуралдаан даргалагч нэмж тодруулах зүйл байгаа эсэхийг зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгчөөс асууна.	Зүйл өөрчлөн найруулах  112 дугаар зүйл.Хэргийн оролцогчоос нэмж тодруулах  112.1.Нотлох баримт шинжлэн судалсны дараа шүүх хуралдаан даргалагч нэмж тодруулах зүйл байгаа эсэхийг зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгчөөс асууна.  2.Нотлох баримт шинжлэн судалсантай холбогдуулан зайлшгүй нэмэлт нотлох баримт шаардлагатай талаар хэргийн оролцогчоос гаргасан хүсэлт үндэслэлтэй гэж үзвэл нотлох баримтыг гаргуулах, шинжлэн	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог нь уг ажиллагаанд удирдлага болгодог тусгай зарчим болох диспозитив буюу иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааг зохигчдын санаачилга, хүсэлтийн үндсэн дээр явуулах болон мэтгэлцэх зарчимд үндэслэдэг. Шүүх хуралдаан, хэлэлцүүлгийн дараа талуудад шинэ нотлох баримтын шаардлага үүсэж болно. Энэ тохиолдолд талуудад эрх тэгш байх боломжийг бүрдүүлэх үүднээс шүүхийн хэлэлцүүлгийн дараа шинэ нотлох баримт шаардлагатай байгаа эсэхийг дахин тодруулж, шаардлагатай гэж үзвэл тухайн завсарлуулж, уг асуудлыг шийдвэрлэх, шийдвэрлэж дууссаны дараа шүүх хуралдааныг завсарласан үеэс нь үргэлжлүүлдэг байхаар төсөлд тусгав. Энэ нь мэтгэлцээний үндсэн дээр бодит үнэнийг тогтоох диспозитив зарчимд нийцнэ гэж үзлээ.

		<p>судлахаар шүүх хуралдааныг завсарлуулж болно.</p> <p>112.3.Энэ хуулийн 112.2-т заасны дагуу завсарлуулсан шүүх хуралдааныг завсарласан үеэс нь үргэлжлүүлэх бөгөөд зөвхөн шинээр цугларсан нотлох баримтыг шинжлэн судална.</p>	
<b>114 дүгээр зүйл.Шүүх бүрэлдэхүүн зөвлөлдөх тасалгаанд орох</b>			
19	<p>114 дүгээр зүйлийн 114.2.Шүүх хуралдааны завсарлагаар зохигчийг гарч явахыг хориглоно.</p>	<p>Хэсэг өөрчлөн найруулах</p> <p>114 дүгээр зүйлийн 114.2.Шүүх зөвлөлдөх тасалгаанд орсон үед зохигч, өмгөөлөгчийг шүүх хуралдааныг орхиж явахыг хориглоно.</p>	<p>Шүүх хуралдаан богино ба урт хугацаагаар завсарлаж болно. Шүүх хуралдаан урт хугацаагаар завсарласан үед гарч явахаар хориглох нь өрөөсгөл бөгөөд зөвлөлдөх тасалгаанд хэрэг шийдвэрлэж байхад явцад шүүх хуралдааныг орхиж явахыг хориглох байдлаар төсөлд тусгав.</p>
20		<p>Хэсэг нэмэх</p> <p>114 дүгээр зүйлийн 114.4.Шүүх зөвлөлдөхөд хуралдааны тэмдэглэл шаардлагатай гэж үзвэл тэмдэглэл бичгээр бүрэн гарах хүртэл шүүх хуралдааныг завсарлуулж болно.</p>	<p>Шүүхийн хэлэлцүүлэг нь хэрэг маргааныг шүүх хөндлөнгийн байдлаар шийдвэрлэх зорилгоор шүүхээс зохион байгуулж буй албан ёсны хуралдааны үйл ажиллагаа юм. Энэ нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нэг зайлшгүй хэсэг бөгөөд талуудын байр суурийг сонсох, нотлох баримтыг судлах, хууль зүйн маргааныг шийдвэрлэх чухал үе шат болдог. Түүнчлэн гэрч, зохигч талууд, өмгөөлөгч шүүхийн хэлэлцүүлэгт хэлсэн үг нь нотлох баримт болох боломжтой байдаг. Нөгөө талаас шүүгч өндөр ой ухаан санамжтай байсан ч шүүх хуралдааны үед хэлсэн үг бүрийг нэг бүрчлэн санах боломжгүй, үг бүрийг тэмдэглэн хөтлөх боломжгүй байдаг. Энэ ч</p>

			<p>утгаараа шүүх хуралдаан бүрд тэмдэглэл хөтлөх нарийн бичгийн ажилтан ажилладаг. Тиймээс хэргийг шийдвэрлэхэд оролцогчдын мэдүүлэг, тайлбар, хууль зүйн дүгнэлт нэг бүрчлэн шаардлагатай гэж үзвэл шүүхээс хуралдааны тэмдэглэл гарах хүртэл хүртэл хугацаагаар хуралдааныг завсарлуулж, улмаар тэмдэглэл гарсны дараа шийдвэр гаргах боломжтой болох нөхцөлийг бүрдүүлэх үүднээс энэ зохицуулалтыг төсөлд шинээр тусгав. Энэ нь шүүх шийдвэр гаргахад талуудын оролцоо, байр суурийг хангахад чухал ач холбогдолтой гэж үзэв.</p>
<b>117 дугаар зүйл.Хэргийг хэрэгсэхгүй болгох</b>			
21		<p>Хэсэг нэмэх</p> <p>117 дугаар зүйлийн 117.2.Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр хэргийг хэрэгсэхгүй болгох асуудлыг хэлэлцэн шүүгчийн захирамж гарснаас хойш хэрэгт шинэ нотлох баримт цугларсан бол энэ хуулийн 117.1-ны дагуу хэргийг хэрэгсэхгүй болгох үндэслэл болно.</p>	<p>Төсөлд урьдчилсан хэлэлцүүлэг гэсэн шүүхийн өмнөх тодорхой шат шинээр бий болгож байгаатай холбогдуулан төсөлд энэ хэсгийг тусгав. Тодруулбал нэгэнт урьдчилсан хэлэлцүүлгээр шийдвэрлэсэн байхад тухайн асуудлаар дахин дахин шийдвэр гаргах нь шүүх хуралдааныг сунжруулах, талуудын тэгш байдал, хуульд дээдлэх зарчмыг алдагдуулах эрсдэлтэй гэж үзсэн.</p>
<b>118 дугаар зүйл.Шийдвэрийн агуулга</b>			

22	<p>118 дугаар зүйлийн 118.4.Үндэслэх хэсэгт хэрэгт байгаа болон шүүх хуралдаанаар хэлэлцэгдэж, хэргийг хянан шийдвэрлэхэд үндэс болсон нотлох баримтын хууль зүйн болон бодит үндэслэл, түүнийг шүүхээс хэрхэн үнэлж байгаа тухай заана.</p>	<p>Хэсэг өөрчлөн найруулах</p> <p>118 дугаар зүйлийн 118.4.Үндэслэх хэсэгт хэрэгт байгаа болон шүүх хуралдаанаар хэлэлцэгдэж, хэргийг хянан шийдвэрлэхэд үндэслэл болгосон нотлох баримтыг үнэлж дүгнэсэн байдал, шүүхийн шийдвэрийн үндэслэл болсон хууль, олон улсын гэрээ, хуульд заасны дагуу гаргасан Засгийн газрын хэм хэмжээ агуулсан, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн акт тэдгээрийг бодит нөхцөл байдалд хэрхэн тайлбарлаж хэрэглэсэн талаар тусгана.</p>	<p>Үндсэн хуулийн 49.1-д зааснаар шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдан шийдвэр гаргана. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 10.5-т “Монгол Улсын Үндсэн хуульд харшлахгүй бол шүүх олон улсын иргэний эрх зүйн холбогдолтой хэргийг хянан шийдвэрлэхдээ олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээг төсөөтэй хэрэглэж болно.” Иргэний хуулийн 3.2-т “Тухайн асуудлаар дотоодын хууль тогтоомж гаргах шаардлагатай гэж олон улсын гэрээнд зааснаас бусад тохиолдолд иргэний эрх зүйн харилцаанд Монгол Улсын олон улсын гэрээг хэрэглэнэ.”, 3.5-д “Хуульд заасан тохиолдолд Засгийн газар энэ хуульд нийцүүлэн гаргасан, иргэний эрх зүйн хэм хэмжээ агуулсан, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актыг хэрэглэж болно.”, 3.6-д “Хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актыг зөвхөн хуулийн хэм хэмжээг нөхөн зохицуулсан тохиолдолд хэрэглэнэ.” гэж мөн тус тус заасан.</p> <p>Үндсэн хуулийн цэцийн 2003 оны 01 тогтоолд “Монгол Улсын Иргэний хуулийн 3 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн заалт нь иргэний эрх зүйн хэм хэмжээ тогтоох эрхийг хэт өргөжүүлэн хавтгайруулсан байна. Ингэснээрээ шүүхээс хууль тогтоомж хэрэглэх эрх хэмжээ, Үндсэн хуулийн агуулгатай зөрчилдсөн байна. Үндсэн хуулиар тодорхойлсон хууль дээдлэх зарчим болон шүүгч асуудлыг шийдэхдээ зөвхөн хуульд захирагдах тухай суурь ойлголтод хууль хэрэглэх үйл ажиллагаа бүрнээ нийцэж байх ёстой. Эрх бүхий төрийн байгууллага, албан тушаалтнаас гаргаж буй эрх зүйн акт Шүүхэд маргаан шийдвэрлэх явцад нотлох</p>
----	--	---	---

			баримтын ач холбогдолтой хэрэгсэл болно.” гэж дүгнэсэн байдаг.  Тиймээс энэхүү зохицуулалтыг тодорхой болгох үүднээс тухайн хэрэгт хуулиас гадна олон улсын гэрээ, хэм хэмжээний актыг хэрэглэсэн бол тухайн эрх зүй актыг тогтоох хэсэгт мөн дурдаж байхаар төсөлд тусгав.
23	118 дугаар зүйлийн 118.5.Тогтоох хэсэгт хэргийг хянан шийдвэрлэхэд баримталсан <b>хуулийн</b> нэр, зүйл, хэсэг, заалтыг тодорхой зааж, шүүхэд гаргасан нэхэмжлэл болон сөрөг нэхэмжлэлийг хангасан, эсхүл зарим хэсгийг хангаж, заримыг хэрэгсэхгүй болгосон, нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон, мөн улсын тэмдэгтийн хураамж, шүүхийн зардал төлүүлэх, эд мөрийн баримтыг хэрхэх, хэрэгт хэд хэдэн нэхэмжлэгч, хариуцагч оролцсон бол нэхэмжлэгч, хариуцагч бүр ямар эрх эдэлж, үүрэг хүлээхийг тусгана. Шийдвэр гүйцэтгэх арга,	Үг өөрчлөх  118 дугаар зүйлийн 118.5.Тогтоох хэсэгт хэргийг хянан шийдвэрлэхэд баримталсан <b>хууль, олон улсын гэрээ, хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актын</b> нэр, зүйл, хэсэг, заалтыг тодорхой зааж, шүүхэд гаргасан нэхэмжлэл болон сөрөг нэхэмжлэлийг хангасан, эсхүл зарим хэсгийг хангаж, заримыг хэрэгсэхгүй болгосон, нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон, мөн улсын тэмдэгтийн хураамж, шүүхийн зардал төлүүлэх, эд мөрийн баримтыг хэрхэх, хэрэгт хэд хэдэн нэхэмжлэгч, хариуцагч оролцсон бол нэхэмжлэгч, хариуцагч бүр ямар эрх эдэлж, үүрэг хүлээхийг тусгана. Шийдвэр гүйцэтгэх арга, журмыг зааж, хүний орон байр,	Дээрхтэй агуулга ижил.

	<p>журмыг зааж, хүний орон байр, бусад газарт нэвтрэх, төлбөр төлөгчийн бие, орон байр, бусад газар, эд хөрөнгөд үзлэг, нэгжлэг хийх, эд хөрөнгө битүүмжлэх, албадан барьцаалах, хураах, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулахад шаардагдах бусад зөвшөөрөл олгоно.</p>	<p>бусад газарт нэвтрэх, төлбөр төлөгчийн бие, орон байр, бусад газар, эд хөрөнгөд үзлэг, нэгжлэг хийх, эд хөрөнгө битүүмжлэх, албадан барьцаалах, хураах, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулахад шаардагдах бусад зөвшөөрөл олгоно.</p>	
<p><b>166 дугаар зүйл. Давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэх</b></p>			
<p>24</p>	<p>166 дугаар зүйлийн 166.4. Давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэж буй шүүх зөвхөн гомдолд дурдсан үндэслэлээр хязгаарлалгүй хэргийг бүхэлд нь хянан үзнэ.</p>	<p>Хэсэг өөрчлөн найруулах</p> <p>166 дугаар зүйлийн 166.4. Давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэж буй шүүх зөвхөн гомдол, <b>тайлбарт</b> дурдсан үндэслэлээр хязгаарлалгүй хэргийг бүхэлд нь хянан үзэх <b>бөгөөд давж заалдах шатны шүүх хуралдаанаар хэлэлцээгүй асуудлыг шийдвэрийн үндэслэл болгохгүй.</b></p>	<p>Шүүх нь Үндсэн хуулиар тогтоосон зарчим болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тусгай зарчимд захирагдаж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулдаг. Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим болдог бол хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх, шүүгч хараат бус байж гагцхүү хуульд захирагдах, хэрэг маргааныг хамтын зарчмаар шийдвэрлэх гэсэн зарчмууд нь шүүх эрх мэдлийн Үндсэн хуулийн зарчимд хамаардаг. Харин талуудын зарчим, мэтгэлцэх буюу шүүх хөндлөнгийн байх, шүүх хуралдааныг нээлттэй, тасралтгүй явуулах, монгол хэл дээр явуулах, эх хэлээрээ мэдүүлэг тайлбар өгөх, шүүхийн шийдвэр заавал биелэгдэх гэсэн зарчмууд нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тусгай зарчим гэж үздэг. Эдгээр</p>

			<p>зарчмууд нь шүүхийн бүх шатанд хангагдаж байж шударга шүүхийн үндсэн шинж хадгалагдана. Шүүх хуралдаанаар хэлэлцээгүй асуудлаар шүүх шийдвэр гаргах нь шүүх хөндлөнгийн байх зарчимд үл нийцнэ. Ялангуяа давж заалдах шатны журмаар хэрэг хянан шийдвэрлэх үед шүүх хуралдаанаар хэлэлцээгүй асуудлаар шүүх шийдвэр гаргах нь хэргийн оролцогч нөгөө талын давж заалдах гомдол гаргах үндсэн эрхтэй зөрчилдөнө. Нөгөө талаас шүүх нь мөрдөн шалгах чиг үүргийг хүлээдэггүй дурдах нь зүйтэй. Тиймээс давж заалдах шатны шүүх хуралдаанаар хэлэлцээгүй асуудал давж заалдах шатны шүүхийн шийдвэрийн үндэслэл болохгүй байх талаар төсөлд тусгав.</p>
<p><b>170 дугаар зүйл.Шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, шийтгэвэрт гомдол гаргах</b></p>			
25	<p>170 дугаар зүйлийн 170.1.Зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч энэ хуулийн 20.1, 38.9, 65.1.1-65.1.8, 65.1.10, 69.1, 92.4, 97.1, 100.2 дахь хэсэг, 80, 117, 124 дүгээр зүйлд заасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, шийтгэвэрт гарсан өдрөөс нь хойш 10 хоногийн дотор тухайн шатны шүүхэд гомдол гаргаж болно.</p>	<p>Үг /заалт/ нэмэх</p> <p>170 дугаар зүйлийн 170.1.Зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч энэ хуулийн 20.1, 38.9, 65.1.1-65.1.8, 65.1.10, <b>65.1.11</b>, 69.1, 92.4, 97.1, 100.2 дахь хэсэг, 80, 117, 124 дүгээр зүйлд заасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, шийтгэвэрт гарсан өдрөөс нь хойш 10 хоногийн дотор тухайн шатны шүүхэд гомдол гаргаж болно.</p>	<p>Нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангалттай гэж үзсэн бол бүрдүүлбэр дутуу үндэслэлээр нэхэмжлэл хүлээн авахаас татгалзсан шүүгчийн захирамжид гомдол гаргах эрхийг нээж өгөхөөр төсөлд тусгав. Энэ нь шүүхэд мэдүүлэх эрх Үндсэн хуулиар баталгаажсан хүний үндсэн эрхэд хамаардаг тул уг эрхийг бататгах, хамгаалахад тустай гэж үзсэн.</p>

26		<p>Хэсэг нэмэх</p> <p>170 дугаар зүйлийн 170.3.Энэ хуулийн 170.1-д заасан гомдлыг хянан шийдвэрлэхэд тухайн шатны шүүхийн бүрэлдэхүүн хүрэлцэхгүй бол тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс тойргийн журмаар томилогдсон шүүгч дангаар хянан шийдвэрлэж болно.</p>	<p>Шүүхийн ачааллаас шалтгаалан зарим анхан шатны шүүхүүд гомдлын шүүх хуралдааныг хийхэд бүрэлдэхүүн хүрэлцэхгүй байх тохиолдол байдаг. Тиймээс энэ тохиолдолд гомдлыг тухайн шүүгчдийн зөвлөгөөнөөс томилогдсон аль нэг шүүгч дангаар шийдвэрлэж болохоор төсөлд тусгав.</p>
<p><b>171 дүгээр зүйл.Шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, шийтгэвэрт гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх</b></p>			
	<p>171.2.Энэ хуулийн 171.1-д заасан тогтоол нь эцсийн шийдвэр болно.</p>	<p>Үг нэмэх</p> <p>171 дүгээр зүйлийн 171.2. <b>Энэ хуульд өөрөөр заагаагүй бол</b> энэ хуулийн 171.1-д заасан тогтоол нь эцсийн шийдвэр болно.</p>	<p>Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсэн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах эрх нь иргэний Үндсэн хуулиар баталгаажсан үндсэн эрх юм. Шүүхэд гаргасан гомдлыг шүүх хүлээн авахаас татгалзаж, тэрхүү шийдвэр нь тухайн шатандаа эцсийн болдог эрх зүйн зохицуулалт одоо үйлчилж байна. Үүнээс шалтгаалан нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан анхан шатны шүүхийн шийдэл нь давж заалдах болон хяналтын шатны шүүхийн хяналтын гадна үлддэг. Улмаар анхан шатны шүүхийн шийдэл буруу тохиолдолд иргэн “шүүхэд гомдол мэдүүлэх” Үндсэн хуулиар баталгаажсан эрхээ нэхэмжлэгч этгээд эдэлж чадахгүй хүрдэг. Харин нэхэмжлэл хүлээн авахаас татгалзсан бусад анхан шатны шүүхийн шийдвэрээс бусад процессийн үед гаргасан анхан шатны шүүхийн шийдвэр нь процессийн хувьд давж заалдах болон хяналтын шатанд хянагдах боломжтой байдаг.</p>

			Тиймээс нэхэмжлэл хүлээн авахаас татгалзсан шүүгчийн захирамж нь давж заалдах болон хяналтын шатны шүүхэд хянагдах боломжийг нээн төсөлд тусгалаа.
		Хэсэг нэмэх  171.3.Нэхэмжлэл хүлээн авахаас татгалзсан шүүгчийн захирамжид гаргасан гомдлыг хангахгүй орхисон бол нэхэмжлэгч давж заалдах шатны болон хяналтын журмаар гомдол гаргах эрхтэй.	Дээр дурдсантай агуулга ижил.
<b>172 дугаар зүйл.Хяналтын журмаар гомдол гаргах</b>			
27		Заалт нэмэх  172 дугаар зүйлийн 172.2.5.хууль зөрчсөн	Үндсэн хуулийн цэцийн 2017-04-12-ны өдрийн 03 дүгнэлтэд "...Хяналтын шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зөвхөн анхан болон давж заалдах шатны шүүх эрүүгийн хэргийг шийдвэрлэхдээ Эрүүгийн хуулийг зөв хэрэглэсэн эсэх, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн эсэх тухай хууль хэрэглээний асуудлыг хянан хэлэлцдэг онцлогоос хамаарч..." гэсэн байдаг. Өөрөөр хэлбэл эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд хяналтын шатны шүүхийн хяналтын цар хүрээнд хуулийг зөв хэрэглэсэн эсэх нь зайлшгүй багтдаг. Тиймээс хуулийг зөв хэрэглэсэн эсэх талаарх асуудлаар буюу хууль зөрчсөн эсэх асуудлаар хяналтын шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй байдлаар төсөлд тусгав.
28		Хэсэг нэмэх	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд энэ талаар өөрчлөлт оруулахаар тусгасан тул хууль

		172 дугаар зүйлийн 172.5.Шийдвэрийг хүчингүй болгож дахин шийдвэрлүүлэхээр анхан шатны шүүхэд буцаасан магадлалд хяналтын журмаар гомдол гаргахгүй.	хоорондын ялгамжтай байдал үүсгэхгүй үүднээс энэ заалтыг өөрчлөхөөр мөн төсөлд тусгасан. Аливаа хэрэг маргааныг агуулгын хувьд давж заалдах шатны шүүх хянан шийдвэрлээгүй байхад тухайн хэрэг маргааныг хяналтын журмаар шийдвэрлэх нь талуудын тэгш байдал, хэргийн талаар тайлбар мэдүүлэг гаргах талуудын хууль ёсны ашиг сонирхол, бүх шатны шүүх хөндлөнгийн байх зарчим, шүүхийн шийдвэр давж заалдах эрхэд нийцэхгүй гэж үзэн энэхүү өөрчлөлтийг тусгав. Өөрөөр хэлбэл шүүх хэрэг маргааныг агуулгын хувьд бүрэн шийдвэрлэсний дараа дараагийн шатны шүүх доод шатны шүүхийн шийдвэрийг хянан үздэг байх нь хэрэг маргааны үнэн зөв шийдэх чухал ач холбогдолтой гэж үзэв. Үүнээс гадна давж заалдах шатны шүүх хэргийг агуулгын хувьд бүрэн хянан шийдвэрлээгүй байхад хяналтын журмаар гомдол гаргах, хяналтын шатны шүүх гомдлыг хэлэлцэхээс татгалзах, анхан шатны шүүхээр дахин хэлэлцэх зэрэгт дунджаар 2-3 сар зарцуулагддаг нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа уртсах үндсэн нөхцөл болдог.
<b>173 дугаар зүйл.Хяналтын журмаар гаргасан гомдол хүлээж авах</b>			
29	173 дугаар зүйлийн 173.5.Хяналтын шатны шүүх гомдлыг хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор танхимын нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцэж дөрөв, түүнээс дээш шүүгч хяналтын	Хэсэг өөрчлөн найруулах 173 дугаар зүйлийн 173.5. Хяналтын шатны шүүх гомдол, эсэргүүцлийг хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор <b>энэ хуулийн 172.2.1-172.2.5-т заасан үндэслэлээр гомдол</b>	Үндсэн хуулийн цэцийн гишүүний 2020 оны 07-р тогтоолд дурдагдсан Хууль зүйн сургуулийн профессор, хууль зүйн ухааны доктор Д.Баярсайхан дүгнэлтэд "1.Эрүүгийн процессын эрх зүйн шинжлэх ухаанд эрүүгийн хэргийг хяналтын журмаар хүлээн авч шийдвэрлэх Улсын дээд шүүхийн бүрэн эрхийг: а)Процедурын болон завсрын шийдвэр гаргах, б)Хэргийг эцэслэх буюу сүүлчийн шийдвэр гаргах гэж

	<p>шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх талаар санал гаргавал энэ тухай тогтоол гаргана.</p>	<p><b>гаргасан эсэхийг</b> танхимын нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцэж, хуульд заасан үндэслэл, журмын дагуу гомдол гаргасан гэж дөрөв, түүнээс дээш шүүгч санал гаргавал хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тогтоол гаргана.</p>	<p>хоёр ангилалд ялган авч үздэг. Завсрын процесс гэдэг нь хяналтын журмаар гомдол эсэргүүцлийг Улсын дээд шүүхэд гаргасныг хуульд заасан харьяаллын болон түүний шаардлагыг хангасан эсэхийг урьдчилан хянаж хэсэгчлэн томилсон бүрэлдэхүүн бүхий шүүгч нарын (3 шүүгч) хэлэлцүүлгээр оруулж, Улсын дээд шүүхийн чиглэлийн шүүгч нарын хуралдаанд оруулах эсэхийг шийдвэрлэнэ. Энэ нь хэргийг шийдэх процесс биш, зөвхөн тухайн гомдол, эсэргүүцлийг хуульд заасан харьяаллын дагуу гаргасан эсэхийг хянан тогтооход чиглэгдсэн үйл явц юм. Харин хэргийг эцэслэн шийдэх Улсын дээд шүүхийн хуралдаан болон түүнээс гарах шийдвэр нь Улсын дээд шүүхийн эцсийн шийдвэр болно.” гэж дүгнэсэн байдаг. Тиймээс хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцэх эсэх асуудлыг шийдвэрлэхдээ хуульд заасан үндэслэлээр гомдол гаргасан эсэхийг хянадаг байдлыг тодруулан төсөлд тусгав. Одоо байгаа хуулийн үйлчлэл нь тодорхойгүй, хуульд заасан үндэслэлээр гомдол гаргасан эсэх нь ач холбогдолгүй байхаар хуульчлагдсан.</p>
<p><b>176 дугаар зүйл.Хяналтын шатны шүүх хуралдаан</b></p>			
30	<p>176 дугаар зүйлийн 176.2.Шүүх хяналтын журмаар хэргийг дараахь байдлаар хянан шийдвэрлэж тогтоол гаргана:</p>	<p>Хэсэг өөрчлөн найруулах</p> <p>176 дугаар зүйлийн 176.2.Хяналтын шатны шүүх хяналтын журмаар гаргасан гомдлын үндэслэл, шаардлагын хүрээнд хэргийг дараахь</p>	<p>Шүүх хөндлөнгийн байх зарчим нь шүүхийн аль ч шатанд хамаатай. Анхан шатны шүүх л хөндлөнгийн, дээд шатны шүүх нь өөрийн үзэмжээр маргааныг хянан шийдвэрлэх нь хөндлөнгийн байх зарчим үл нийцнэ. Өөрөөр хэлбэл оролцогчийн маргаагүй асуудлыг шүүх санаачилгаараа авч шийдвэрлэх нь хөндлөнгийн байх зарчмыг ноцтой алдагдуулдаг. Тиймээс хяналтын шатны шүүх гомдлын үндэслэл,</p>

		байдлаар хянан шийдвэрлэж тогтоол гаргана:	шаардлагын хүрээнд хэргийг хуульд заасан журмаар шийдвэрлэхээр төсөлд тусгав.
	176.4.Хяналтын шатны тогтоол шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд тогтоолд гомдол гаргахгүй.	176.4.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хяналтын шатны тогтоол шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд тогтоолд гомдол гаргахгүй.	Үндсэн хуульд зааснаар Үндсэн хуулийн цэцийн хяналтад Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Ерөнхий прокурор байдаг. Гэвч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Үндсэн хууль, хүний үндсэн эрх зөрчигдсөн тохиолдолд шүүх хэрхэн хамгаалах, хангах талаар зохицуулалтгүй үлдэн, улмаар энэхүү зөрчил Цэцийн хяналтын гадна үлддэг. Тиймээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүний үндсэн эрх зөрчигдсөн тохиолдолд Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчид гомдол гаргах талаар төсөлд тусгасантай холбогдуулан энэхүү заалтад энэ хуульд өөрөөр заагаагүй бол гэж тодруулан тусгав.
31		Хэсэг нэмэх  176 дугаар зүйлийн 176.7. Хяналтын журмаар гаргасан гомдол, тайлбарт дурдагдаагүй, түүнчлэн хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцээгүй асуудлыг зөвлөлдөх тасалгаанд хэлэлцэхгүй бөгөөд бөгөөд шийдвэрийн үндэслэл болгохгүй.	Гомдолд дурдаагаагүй, түүнчлэн шүүх хуралдаанаар хэлэлцээгүй асуудлаар шүүх зөвлөлдөж шийдвэрлэх нь талуудын мэтгэлцэх зарчим, тухайн асуудлаар шүүхэд тайлбар мэдүүлэг гаргах боломжийг ноцтой алдагдуулна. Тиймээс гомдол, тайлбарт дурдагдаагүйгээс гадна шүүх хуралдаанаар хэлэлцээгүй асуудлаар зөвлөлдөхгүй, хэлэлцэхгүй байхаар төсөлд тусгав.
<b>176<sup>1</sup> дугаар зүйл. Хяналтын шатны шүүхийн шийдвэрт гомдол гаргах</b>			
32		Зүйл нэмэх	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шатанд хүний үндсэн эрх буюу Үндсэн хуулийн холбогдох зохицуулалт зөрчигдсөн тохиолдолд уг эрхийг хэрхэн хангах, хамгаалах талаар хуульд тусгагдахгүй байсаар өнөөдрийг хүрсэн. Үүнээс шалтгаалж хэрэг

		<p><b>176<sup>1</sup> дугаар зүйл. Хяналтын шатны шүүхийн шийдвэрт гомдол гаргах</b></p> <p>176<sup>1</sup> дугаар зүйлийн 1.Хяналтын шатны шүүхийн шийдвэр Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн гэж үзвэл хэргийн оролцогч уг шийдвэрийг гардан авснаас хойш 30 хоногийн дотор Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчид гомдол гаргаж болно.</p> <p>176<sup>1</sup>.2.Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч гомдлыг хянан үзэж 30 хоногийн дотор дүгнэлт гаргана. Дүгнэлтэд гомдол үндэслэлтэй, эсхүл үндэслэлгүй талаар тусгасан байна.</p> <p>176<sup>1</sup>.3.Гомдол үндэслэлтэй гэж дүгнэлт гарсан бол Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн дүгнэлтийг хэлэлцэнэ.</p> <p>176<sup>1</sup>.4. Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн дүгнэлт үндэслэлтэй гэж Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаас үзвэл дагуу</p>	<p>хянан шийдвэрлэх эрх бүхий этгээдийн зүгээс үндсэн эрхийг буюу Үндсэн хуулийг “үл ойшоох” хандлага ажиглагддаг. Энэ ч үүднээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шатанд үндсэн эрх зөрчигдөх тохиолдолд Үндсэн хуулийн 66.2.3 дахь заалтад Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Үндсэн хууль зөрчсөн эсэх асуудлыг Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэхээр заасан байдаг. Энэ нь Үндсэн хууль нь хэрэг хянан шийдвэрлэх бүх шатанд бүрнээ хэрэгжих, түүний хэлбэрэлтгүй дагаж мөрдөн үндэс болдог. Тиймээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Үндсэн хууль зөрчигдсэн, тэр нь залруулагдаагүй тохиолдолд Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчид гомдол гаргах, Ерөнхий шүүгч дүгнэлт гаргах, Үндсэн хуулийн цэцэд тухайн асуудлаар өргөдөл гаргаж хүний үндсэн эрхийг хамгаалах боломжийг бүрдүүлэхээр төсөлд тусгав.</p>
--	--	--	--

	<p>хяналтын шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгоно.</p> <p>176<sup>1</sup>.5. Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн дүгнэлт Үндсэн хууль зөрчсөн эсэх маргааныг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд заасан журмын дагуу хянан шийдвэрлэнэ.</p> <p>176<sup>1</sup>6. Улсын дээд шүүхийн шийдвэр эцсийн байна. Улсын дээд шүүхийн шийдвэр хуульд харшилбал түүнийг Улсын дээд шүүх өөрөө хүчингүй болгоно.</p>	
--	--	--

**ЗАХИРГААНЫ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

№	Хууль	Төсөл	Танилцуулга
<b>1 дүгээр зүйл. Хуулийн зорилт</b>			
1	<p>1 дүгээр зүйлийн 1.1.Энэ хуулийн зорилт нь хүн, хуулийн этгээдээс захиргааны байгууллагын хууль бус үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар, түүнчлэн нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд, хуульд заасан бол захиргааны байгууллагаас гаргасан нэхэмжлэлийн дагуу захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p>	<p>Үг өөрчлөх 1 дүгээр зүйлийн 1.1.Энэ хуулийн зорилт нь хүн, хуулийн этгээдээс захиргааны байгууллагын хууль бус үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар, түүнчлэн нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд, хуульд заасан бол захиргааны байгууллагаас гаргасан нэхэмжлэлийн дагуу захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх, хэргийн оролцогчийн шударгаар шүүлгэх эрхийг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p>	<p>Үндсэн хуулийн 16-р зүйлийн 14-т “шударга шүүхээр шүүлгэх” эрхийг баталгаажуулсан. Энэхүү эрхийг Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 10-р зүйлд заасан “шударгаар шүүлгэх” эрхтэй ижил агуулгатай гэж Үндсэн хуулийн цэц 2021 оны 07 дүгнэлтэд туссан байдаг. Шударга шүүх буюу шударгаар шүүлгэх гэдэг нь хуулийн болон ёс суртахууны хувьд тухайн хэрэг, маргааныг тэгш, тал засалгүй, баримт нотолгоонд тулгуурлан, хуулийн дагуу шийдвэрлэхийг хэлэх бөгөөд Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль нь бүхэлдээ иргэний шударга шүүхээр шүүлгэх эрхийг хангатай холбоотой харилцаа юм. Тиймээс хуулийн зорилтод энэхүү зарчмыг оруулахаар төсөлд тусгав.</p>
<b>10 дугаар зүйл. Шүүх хуралдааныг тасралтгүй явуулах</b>			

2	<p>10 дугаар зүйлийн 10.1.Бүх шатны шүүхийн шүүх хуралдааныг <b>өдрийн цагаар</b>, амрах зайлшгүй шаардлагатайгаас бусад цагт тасралтгүй явуулна.</p> <p>10.2.Шүүгч, шүүх бүрэлдэхүүн шүүх хуралдаанаар нэгэнт хэлэлцэж эхэлсэн хэргийг хянан шийдвэрлэж дуусах болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хойшлуулах, түдгэлзүүлэх хүртэл өөр хэргийг хянан шийдвэрлэх эрхгүй.</p>	<p>Үг өөрчлөх</p> <p>10 дугаар зүйлийн 10.1.Бүх шатны шүүхийн шүүх хуралдааныг <b>ажлын цагаар явуулах ба энэ хуульд заасны дагуу шүүх хуралдааныг завсарлуулсан болон</b> амрах зайлшгүй шаардлагатайгаас бусад цагт тасралтгүй явуулна.</p> <p>Өгүүлбэр нэмэх</p> <p>10.2.Шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч шүүх хуралдаанаар нэгэнт хэлэлцэж эхэлсэн хэргийг хянан шийдвэрлэж дуусах буюу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хойшлуулах, түдгэлзүүлэх, <b>энэ хуульд заасны дагуу шүүх хуралдааныг завсарлуулах</b> хүртэл өөр хэргийг хянан шийдвэрлэх эрхгүй.</p>	<p>Шүүх хуралдааныг энэ хуульд өөрөөр заагаагүй бол зөвхөн ажлын цагаар явуулахаар төсөлд тусгалаа. Шүүх хуралдаан нь зөвхөн шүүгчийн хөдөлмөрийн асуудал биш ба хуралдаанд оролцож байгаа оролцогч тус бүрийн хөдөлмөрийн асуудал мөн хөндөгдөнө. Хөдөлмөрийн тухай хуульд нэг хоногт ажиллах ажлын цагийг 8 цаг байхаар тогтоосон байдаг. Үүнээс гадна шүүх хуралдаан хуульд заасан үндэслэл, нөхцөл байдал, давагдашгүй нөхцөл байдлын улмаас тодорхой хугацаагаар завсарлаж болдог. Хуралдаан завсарласан үеийг шүүх хуралдаан тасралтгүй үргэлжилж байна гэж үзэх үндэслэл болохгүй. Тиймээс шүүх хуралдаан завсарлах, амрах шаардлагатайгаас бусад цагт шүүх хуралдаан тасралтгүй явуулах талаар төсөлд тусгав.</p>
<p><b>52 дугаар зүйл. Нэхэмжлэл гаргах, нэхэмжлэлийн хэлбэр, бүрдүүлбэр</b></p>			
3	<p>52 дугаар зүйлийн 52.2.7.холбоо барих утас, факс, цахим хаяг.</p>	<p>Үг нэмэх</p> <p>52 дугаар зүйлийн 52.2.7.холбоо барих утас, факс, цахим хаяг, <b>цахим сүлжээн дэх харилцаа холбооны программ</b></p>	<p>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд энэ талаар өөрчлөлт оруулахаар тусгасан тул хууль хоорондын ялгамжтай байдал үүсгэхгүй үүднээс энэ заалтыг өөрчлөхөөр төсөлд тусгав.</p>

		<b>хангамжид холбогдсон утасны дугаар.</b>	
<b>56 дугаар зүйл. Захиргааны хэрэг үүсгэсэн шүүгчийн ажиллагаа</b>			
4	56 дугаар зүйлийн 56.1.2.хэргийн <b>оролцогчид</b> эрх, үүргийг нь тайлбарлан өгч, энэ тухайгаа баримтжуулах;	Үг өөрчлөх  56 дугаар зүйлийн 56.1.2.хэргийн <b>оролцогчийг дуудан ирүүлж</b> эрх, үүргийг нь тайлбарлан өгч, энэ тухайгаа баримтжуулах;	Дийлэнх тохиолдолд зохигчид шүүх хуралдаанд эсхүл өмнө нь эрх үүрэгтэйгээ танилцаж, шүүхээр шийдвэрлүүлэх шаардлагатай хүсэлтээ шүүх хуралдаанд гаргадаг. Тиймээс зохигч талуудын хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх үүднээс хэрэг үүсгэсэн шүүгчийн ажиллагааны хүрээнд талуудыг дуудан ирүүлж, эрх үүргийг танилцуулан энэ талаар албажуулах шаардлагатай талаар төсөлд тусгав.
<b>59 дүгээр зүйл. Шүүхэд дуудан ирүүлэх</b>			
5	59 дүгээр зүйлийн 59.2.Шүүх хуралдаанд ирвэл зохих оролцогчдод шүүх хуралдаан хэзээ, <b>хаана болохыг</b> шүүхийн мэдэгдэх хуудсаар тэдгээрийн оршин суугаа газрын, эсхүл ажлын газрын хаягаар мэдэгдэнэ.  59.3.Шүүхийн мэдэгдэх хуудсыг ирвэл зохих оролцогчийн оршин суугаа болон ажлын газрын хаягийн дагуу шуудангаар, эсхүл шүүхийн ажилтнаар	Үг өөрчлөх  59 дүгээр зүйлийн 59.2.Шүүх хуралдаанд ирвэл зохих оролцогчдод шүүх хуралдаан хэзээ, <b>“хаана болох, үргэлжлэх талаар”</b> шүүхийн мэдэгдэх хуудсаар тэдгээрийн оршин суугаа газрын, эсхүл ажлын газрын хаягаар мэдэгдэнэ.  Үг нэмэх  59 дүгээр зүйлийн 59.3.Шүүхийн мэдэгдэх хуудсыг ирвэл зохих оролцогчийн оршин суугаа болон ажлын газрын хаягийн	Орчин үед харилцаа холбооны шинэ цахим хэлбэрүүд үүсэж байгаатай холбогдуулан шүүх ба хэргийн оролцогч хоорондын харилцаа холбоог хялбар, түргэн болгох боломжтой болгох үүднээс энэхүү заалтыг хуульд нэмэлт оруулахаар төсөлд тусгав.

	<p>биечлэн хүргүүлэх, эсхүл утас, факс, цахим шуудан, цахилгаан болон хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан мэдэгдэж болох бөгөөд мэдэгдсэнээ баримтжуулна.</p>	<p>дагуу шуудангаар, эсхүл шүүхийн ажилтнаар биечлэн хүргүүлэх, эсхүл утас, мессеж, факс, цахим шуудан, <b>цахим сүлжээн дэх харилцаа холбооны программ хангамж</b>, цахилгаан болон хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан мэдэгдэж болох бөгөөд мэдэгдсэнээ баримтжуулна.</p>	
<p><b>71 дүгээр зүйл. Шүүх хуралдааныг товлон зарлах</b></p>			
6	<p>71 дүгээр зүйлийн 71.1. <b>Шүүгч захиргааны хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцэхэд хангалттай нотлох баримт цугларсан гэж үзсэн, эсхүл энэ хуулийн 63 дугаар зүйлд заасан хугацаа дууссан, түүнчлэн шаардлагатай бусад тохиолдолд шүүх хуралдааныг хэзээ, хаана болохыг урьдчилсан хэлэлцүүлгийн журмаар товлж, долоо, түүнээс доошгүй хоногийн өмнө зарлаж, хэргийн оролцогч,</b></p>	<p>Хэсэг өөрчлөн найруулах</p> <p>71 дүгээр зүйлийн 71.1. <b>Хариуцагч хариу тайлбараа ирүүлсэн, эсхүл хуульд заасан 14 хоногийн дотор буюу шүүгчээс тогтоосон хугацаанд хариу тайлбараа ирүүлээгүй, түүнчлэн шаардлагатай бусад тохиолдолд шүүх хуралдааныг хэзээ, хаана болохыг урьдчилсан хэлэлцүүлгийн журмаар товлж, долоо, түүнээс доошгүй хоногийн өмнө зарлаж, хэргийн оролцогч, бусад оролцогчид хурлын товыг мэдэгдэнэ.</b></p>	<p>Нэхэмжлэл гардаж авсан хариуцагч хариу тайлбарыг 14 хоногт гаргаж өгөх үүрэгтэй байдаг. Энэ хугацаанд хариуцагч тайлбар гаргаж өгсөн хэдий ч шүүхээс хуульд хугацаандаа баригдан буюу 60+30 хоногт багтаан шүүх хуралдааныг товлон зарлах нь дийлэнх болдог. Тухайн хугацаанд шүүх хуралдаан зарлагдсан байсан тодорхой шалтгааны улмаас дахин дахин шүүх хуралдаан хойшилж болдог ба үүнээс шалтгаалж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа үр дүнгүйгээр буюу механикаар уртсах үндэслэл болдог. Нөгөө талаас хариуцагч хариу тайлбараа заасан хугацаанд ирүүлээгүй бол нэхэмжлэлийн шаардлага хүлээн зөвшөөрсөнд тооцохоор хуульд заасан хэдий ч энэ зохицуулалт тэр бүр хэрэгждэггүй. Тиймээс нэгэнт хариуцагч хариу тайлбараа ирүүлсэн, эсхүл хуульд заасан 14 хоногийн дотор буюу шүүгчээс тогтоосон хугацаанд хариу тайлбараа ирүүлээгүй, шүүхийн урьдчилсан</p>

	бусад оролцогчид хурлын товыг мэдэгдэнэ.		хэлэлцүүлэг явуулах хүсэлт ирүүлээгүй бол шүүх хуралдааныг товлон зарлаж байх нь зохигч талууд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүндэтгэлтэй хандах, хариуцлагатай хандах нөхцөл болно гэж үзэв.
<b>82 дугаар зүйл. Шүүх хуралдааны нийтлэг журам</b>			
7	82 дугаар зүйлийн 82.2.Шүүх хуралдаанд оролцогч тайлбар, мэдүүлэг өгөх, дүгнэлт гаргахдаа суудлаасаа босно. Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас суудлаасаа босч чадахгүй бол хуралдаан даргалагчийн зөвшөөрлөөр суугаагаар үг хэлж болно.	Хэсэг өөрчлөн найруулах  82 дугаар зүйлийн 82.2. Шүүхийн хуралдааны танхимын зохион байгуулалт, техникийн шаардлагын улмаас шүүх хуралдаанд оролцогч тайлбар, мэдүүлэг өгөх, дүгнэлт гаргахдаа шүүх хуралдаан даргалагчийн зөвшөөрснөөр босож эсхүл суудлаасаа мэдүүлэг өгнө.	Оролцогчид шүүх хуралдаанд мэдүүлэг өгөхдөө босож үг хэлэх, тайлбар гаргахаар хуульд туссаныг техникийн шаардлагын улмаас босоо байдлаар эсхүл суугаа байдлаар үг хэлэх, тайлбар өгөх эсэхийг тухай бүр шүүх хуралдаан даргалагч шийддэг байхаар төсөлд тусгав. Технологи хөгжиж байгаатай холбогдуулан бүхий шүүх хуралдааны дуу дүрс бичлэг цуг авагддаг болсон, уг техник хэрэгсэл нь ихэнхдээ суугаа байрлалтайд зориулагдсан байдаг учир энэхүү өөрчлөлтийг тусгав.
<b>85 дугаар зүйл. Татгалзан гаргах хүсэлтийг шийдвэрлэх журам</b>			
8		Хэсэг нэмэх  85 дугаар зүйлийн 85.8.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдуулан шүүгч захирамж, шүүх бүрэлдэхүүн тогтоол гаргасан нь	Үндсэн хуулийн 47-р зүйлийн 1-д зааснаар Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ гэсэн. Энэхүү эрх мэдэл нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад болон хэргийг хянан шийдвэрлэж шүүх бүрэлдэхүүн шийдвэр (захирамж, тогтоол, шийдвэр) гаргахыг ойлгодог. Харин шийдвэр хууль тогтоомжид нийцээгүй, хүний эрхийг зөрчсөн бол давж заалдах журмаар шүүхийн

		<p>шүүгчийг татгалзан гаргах үндэслэл болохгүй.</p> <p>Хэсэг нэмэх</p> <p>85.9. Энэ хуулийн 85.8-д заасныг зөрчиж гаргасан шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг татгалзан гаргах хүсэлтийг гаргаагүйд тооцон, шүүх хуралдааныг үргэлжлүүлнэ.</p>	<p>шийдвэр хүчингүй болох, өөрчлөгдөх боломжтой байдаг. Энэ нь шүүх эрх мэдлийн үндсэн зарчим юм. Тиймээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгч, шүүх бүрэлдэхүүн шийдвэр гаргасныг шүүх эрх мэдлийг хэрэгжүүлж байгаатай утгачлан ойлгож болох тул эрх мэдлээ хэрэгжүүлсэн нь тухайн шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг татгалзан гаргах үндэслэл болохгүй талаар төсөлд тусгав.</p>
<b>95 дугаар зүйл.Хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгчид эрх, үүргийг тайлбарлах</b>			
9	<p>95 дугаар зүйлийн 95.1.Шүүх хуралдаан даргалагч хэргийн оролцогч, бусад оролцогчид хуульд заасан эрх, үүргийг нь тайлбарлан өгнө.</p>	<p><b>Зүйл өөрчлөн найруулах</b></p> <p>95 дугаар зүйлийн 95.1.Хэргийн оролцогч энэ хуулийн 56.1.2-т заасны дагуу эрх, үүрэгтэй танилцаж холбогдох баримтад гарын үсэг зурсан эсэхийг шүүх хуралдаан даргалагч шалгана.</p> <p>95.2.Хэргийн оролцогч, бусад оролцогчид эрх, үүрэгтэй танилцаагүй бол эрх, үүргийг тайлбарлан өгч, энэ тухай баримтжуулна.</p> <p>95.3.Хэргийн оролцогчдоос эрх, үүргээс ойлгоогүй зүйл байвал энэ талаар шүүх хуралдаан</p>	<p>Хэргийн оролцогч нэгэнт эрх, үүрэгтэй танилцсан бол шүүх хуралдаан эхлэхийг өмнө энэ талаар шалгаж, танилцаагүй бол нэмж танилцуулах, тодруулах зүйлийг нэмж тайлбарлаж өгдөг байхаар төсөлд тусгав.</p> <p>Түүнчлэн хэргийн оролцогч, бусад оролцогчид эрх, үүрэгтэй танилцаагүй бол эрх, үүргийг тайлбарлан өгч, энэ тухай баримтжуулах, эрх, үүргээс ойлгоогүй зүйл байвал энэ талаар шүүх хуралдаан даргалагч нэмж тайлбарлаж өгөхөөр төсөлд тусгав.</p>

		даргалагч нэмж тайлбарлаж өгнө.	
<b>96 дугаар зүйл. Хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтийг шийдвэрлэх</b>			
10	<p>96 дугаар зүйлийн 96.1.Шүүх хуралдааны явцад шинээр нотлох баримт шаардагдвал шүүх хуралдааныг <b>нэг удаа хойшлуулах</b> бөгөөд нотлох баримттай холбоотойгоос бусад асуудлын талаар хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчөөс гаргасан хүсэлтийг сонсмогц шүүгч, шүүх бүрэлдэхүүн даруй шийдвэрлэнэ. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр шийдвэрлэсэн асуудлаар шүүх хуралдаан дээр дахин хүсэлт гаргах эрхгүй.</p> <p>96.2.шүүх хуралдаанд ирээгүй оролцогчийг зайлшгүй оролцуулах шаардлагатай гэж үзвэл шүүх хуралдааныг 14 хүртэл хоногоор хойшлуулж болно.</p>	<p>Зүйл өөрчлөн найруулах</p> <p>96 дугаар зүйлийн 96.1. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээс хойш шинэ нотлох баримт цугларсантай холбогдуулан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдсон асуудлаар хэргийн оролцогчийн гаргасан хүсэлтийг шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч даруй шийдвэрлэнэ.</p> <p>96.2. Энэ хуулийн 96.1-д заасны дагуу гаргасан хүсэлтийг шүүх хүлээн авч шийдвэрлэсэн бол шүүх хуралдааныг завсарлуулна.</p> <p>96.3.Энэ хуулийн 96.2-т заасны дагуу шүүх хуралдааныг завсарлуулсан бол хэзээ үргэлжлэх, эсхүл тодорхойгүй хугацаагаар завсарласан бол энэ талаар хэргийн оролцогч болон тэдгээрийн өмгөөлөгчид</p>	<p>Урьдчилсан хэлэлцүүлгээр баримт гаргуулах болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой бусад асуудлыг шийдвэрлэх боломжтой тул шүүх хуралдааны өмнө хэргийн оролцогчоос гаргах хүсэлтийн хүрээ хязгаарыг багасгахаар төсөлд тусгав. Шүүх хуралдааны өмнө огт хүсэлт шийдвэрлэхгүй орхигдуулах нь талуудын тэгш байдлыг алдагдуулах эрсдэлтэй тул тодорхой асуудлаар хүсэлт гаргах эрхийг нээлттэй үлдээхээр төсөлд тусгав.</p>

	<p>96 дугаар зүйлийн 96.3.Шүүх хуралдааны явцад шинэ нотлох баримт зайлшгүй шаардлагатай гэж үзвэл шүүх хуралдааныг 30 хүртэл хоногоор <b>хойшлуулж</b> болно.</p>	<p>мэдэгдэж энэ тухай баримтжуулна.</p> <p>96.4.Энэ хуулийн 96.2-т заасны дагуу завсарлуулсан шүүх хуралдааныг завсарласан үеэс нь үргэлжлүүлнэ.</p> <p>96.5.Энэ хуульд заасны шүүх хуралдаан завсарласан нь шүүх бүрэлдэхүүнээс бусад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулах, өмгөөлөгч өөр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоход саад болохгүй.</p>	
<p><b>105 дугаар зүйл. Шүүх хуралдаан завсарлах</b></p>			
<p>11</p>	<p>105 дугаар зүйлийн 105.2.<b>Шүүх хуралдааны завсарлагаар</b> хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч шүүх хуралдааныг орхиж явахыг хориглоно.</p>	<p>Зүйл өөрчлөн найруулах</p> <p>105 дугаар зүйл. 105.1.Шүүх хуралдаан даргалагч шүүх хуралдаан завсарласныг мэдэгдэж, шүүх бүрэлдэхүүн шийдвэрээ гаргахын тулд зөвлөлдөх тасалгаанд орно.</p> <p><b>105.2.Шүүх зөвлөлдөх тасалгаанд орсон үед</b> хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийг шүүх хуралдааныг орхиж явахыг хориглоно.</p>	<p>Шүүх хуралдаан богино ба урт хугацаагаар завсарлаж болно. Шүүх хуралдаан урт хугацаагаар завсарласан үед гарч явахаар хориглох нь өрөөсгөл бөгөөд зөвлөлдөх тасалгаанд хэрэг шийдвэрлэж байхад явцад шүүх хуралдааныг орхиж явахыг хориглох байдлаар төсөлд тусгав.</p> <p>Шүүхийн хэлэлцүүлэг нь хэрэг маргааныг шүүх хөндлөнгийн байдлаар шийдвэрлэх зорилгоор шүүхээс зохион байгуулж буй албан ёсны хуралдааны үйл ажиллагаа юм. Энэ нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нэг зайлшгүй хэсэг бөгөөд талуудын байр суурийг сонсох, нотлох баримтыг судлах, хууль зүйн маргааныг шийдвэрлэх чухал үе шат болдог. Түүнчлэн гэрч,</p>

		<p>105.3.Хуулийн 105.1-д зааснаас бусад тохиолдолд шүүх хуралдаан завсарласан нь шүүх бүрэлдэхүүнээс бусад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулах, өмгөөлөгч өөр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоход саад болохгүй.</p> <p>105.4.Шүүх зөвлөлдөхөд хуралдааны тэмдэглэл шаардлагатай гэж үзвэл тэмдэглэл бичгээр бүрэн гарах хүртэл шүүх хуралдааныг завсарлуулж болно.</p> <p>105.5.Хэрэг, маргааныг шийдвэрлэхдээ зөвлөлдөх тасалгаанд дараахь асуудал тус бүрийг хэлэлцэнэ:</p> <p>105.5.1.нэхэмжлэлийн үндэслэл; 105.5.2.хариу тайлбарын үндэслэл; 105.5.3.гуравдагч этгээдтэй хэргийн тухайд гуравдагч этгээдийн тайлбарын үндэслэл; 105.5.4.шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгч оролцсон бол түүний дүгнэлт; 105.5.5.хууль хэрэглээний асуудал.</p>	<p>зохигч талууд, өмгөөлөгч шүүхийн хэлэлцүүлэгт хэлсэн үг нь нотлох баримт болох боломжтой байдаг. Нөгөө талаас шүүгч өндөр ой ухаан санамжтай байсан ч шүүх хуралдааны үед хэлсэн үг бүрийг нэг бүрчлэн санах боломжгүй, үг бүрийг тэмдэглэн хөтлөх боломжгүй байдаг. Энэ ч утгаараа шүүх хуралдаан бүрд тэмдэглэл хөтлөх нарийн бичгийн ажилтан ажилладаг. Тиймээс хэргийг шийдвэрлэхэд оролцогчдын мэдүүлэг, тайлбар, хууль зүйн дүгнэлт нэг бүрчлэн шаардлагатай гэж үзвэл шүүхээс хуралдааны тэмдэглэл гарах хүртэл хүртэл хугацаагаар хуралдааныг завсарлуулж, улмаар тэмдэглэл гарсны дараа шийдвэр гаргах боломжтой болох нөхцөлийг бүрдүүлэх үүднээс энэ зохицуулалтыг төсөлд шинээр тусгав. Энэ нь шүүх шийдвэр гаргахад талуудын оролцоо, шүүхийн өмнө тэгш байдлыг хангах, шүүх хөндлөнгийн байх зарчмыг хангахад чухал ач холбогдолтой гэж үзэв. Түүнчлэн тухайн хэрэг маргааныг хянан шийдвэрлэсэн шүүх зөвлөлдөхдөө талуудын гаргасан тайлбар, үндэслэл, шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгч оролцсон бол түүний дүгнэлт, цаашлаад хууль хэрэглээний асуудлыг зайлшгүй хэлэлцэн дүгнэх талаар төсөлд тусгалаа. Шүүхийн өмнө хүн эрх тэгш буюу мэтгэлцэгч талуудын тэгш байдлыг хангах гол нөхцөл нь маргалдагч талуудын дүгнэлт, гаргалгаа, тайлбарыг шүүх зайлшгүй хэлэлцэж, дүгнэж хариулт өгөхөд оршдог бөгөөд энэ нь шүүх хөндлөнгийн байх зарчимд хамааралтай юм. Маргалдагч талуудын тайлбар, үндэслэлийг хүлээн авсан, няцаасан бол тухайн шийдэлдээ шүүх тайлбар хийхгүй орхих нь иргэдийн шүүхэд үл итгэх байдлыг үүсгэдэг. Тиймээс захиргааны хэрэг хянан</p>
--	--	---	--

			шийдвэрлэх процессийн эрх зүйд шүүх зөвлөлдөх тасалгаанд яг ямар асуудал хэлэлцэх талаар зохицуулалтгүй байсныг тодорхой болгохоор төсөлд тусгалаа.
<b>107 дугаар зүйл. Шүүхийн шийдвэрийн агуулга</b>			
12	<p>107 дугаар зүйлийн 107.4.Үндэслэх хэсэгт хэрэгт байгаа болон шүүх хуралдаанаар хэлэлцэгдэж, хэргийг хянан шийдвэрлэхэд үндэслэл болгосон нотлох баримтыг үнэлж дүгнэсэн байдал, захиргааны актын хууль зүйн үндэслэл, түүнд өгөх тайлбар, шүүхийн шийдвэрийн үндэслэл болсон <b>хэм хэмжээ</b>, тэдгээрийг хэргийн бодит нөхцөл байдалд хэрхэн тайлбарлаж хэрэглэсэн тухайгаа тусгана.</p> <p>107 дугаар зүйлийн 107.5.Тогтоох хэсэгт хэргийг хянан шийдвэрлэхэд баримталсан <b>хуулийн</b> нэр,</p>	<p>Үг өөрчлөх</p> <p>107 дугаар зүйлийн 107.4.Үндэслэх хэсэгт хэрэгт байгаа болон шүүх хуралдаанаар хэлэлцэгдэж, хэргийг хянан шийдвэрлэхэд үндэслэл болгосон нотлох баримтыг үнэлж дүгнэсэн байдал, захиргааны актын хууль зүйн үндэслэл, түүнд өгөх тайлбар, шүүхийн шийдвэрийн үндэслэл болсон <b>хууль, олон улсын гэрээ, хуульд заасны дагуу гаргасан Засгийн газрын хэм хэмжээ агуулсан, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн акт</b>, тэдгээрийг бодит нөхцөл байдалд хэрхэн тайлбарлаж хэрэглэсэн талаар тусгана.</p> <p>Үг өөрчлөх</p> <p>107.5.Тогтоох хэсэгт хэргийг хянан шийдвэрлэхэд баримталсан <b>хууль, олон</b></p>	<p>Үндсэн хуулийн 49.1-д зааснаар шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдан шийдвэр гаргана. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 11.1 “Шүүх хэрэг хянан шийдвэрлэхэд Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжийг хэрэглэнэ.” Гэж заасан.</p> <p>Түүнчлэн Үндсэн хуулийн цэцийн 2003 оны 01 тогтоолд “Монгол Улсын Иргэний хуулийн 3 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн заалт нь иргэний эрх зүйн хэм хэмжээ тогтоох эрхийг хэт өргөжүүлэн хавтгайруулсан байна. Ингэснээрээ шүүхээс хууль тогтоомж хэрэглэх эрх хэмжээ, Үндсэн хуулийн агуулгатай зөрчилдсөн байна. Үндсэн хуулиар тодорхойлсон хууль дээдлэх зарчим болон шүүгч асуудлыг шийдэхдээ зөвхөн хуульд захирагдах тухай суурь ойлголтод хууль хэрэглэх үйл ажиллагаа бүрнээ нийцэж байх ёстой. Эрх бүхий төрийн байгууллага, албан тушаалтнаас гаргаж буй эрх зүйн акт Шүүхэд маргаан шийдвэрлэх явцад нотлох баримтын ач холбогдолтой хэрэгсэл болно.” гэж дүгнэсэн байдаг.</p> <p>Тиймээс энэхүү зохицуулалтыг тодорхой болгох үүднээс тухайн хэрэгт хуулиас гадна олон улсын гэрээ, хэм хэмжээний актыг хэрэглэсэн бол тухайн</p>

	<p>зүйл, хэсэг, заалтыг тодорхой зааж, шүүхэд гаргасан нэхэмжлэл болон сөрөг нэхэмжлэлийг хангасан, эсхүл зарим хэсгийг хангаж, заримыг хэрэгсэхгүй болгосон, нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон, түүнчлэн нөхөн төлүүлэх шүүхийн зардал, улсын тэмдэгтийн хураамжийг хуваарилсан байдал, эд мөрийн баримтыг хэрхэх, хэрэгт хэд хэдэн нэхэмжлэгч, хариуцагч оролцсон бол нэхэмжлэгч, хариуцагч тус бүр ямар эрх эдэлж, үүрэг хүлээхийг тусгана. Шийдвэр гүйцэтгүүлэх арга, журам, хугацаа, шийдвэрийг давж заалдах журам, хугацааг заана.</p>	<p><b>улсын гэрээ, хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актын</b> нэр, зүйл, хэсэг, заалтыг тодорхой зааж, шүүхэд гаргасан нэхэмжлэл болон сөрөг нэхэмжлэлийг хангасан, эсхүл зарим хэсгийг хангаж, заримыг хэрэгсэхгүй болгосон, нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон, түүнчлэн нөхөн төлүүлэх шүүхийн зардал, улсын тэмдэгтийн хураамжийг хуваарилсан байдал, эд мөрийн баримтыг хэрхэх, хэрэгт хэд хэдэн нэхэмжлэгч, хариуцагч оролцсон бол нэхэмжлэгч, хариуцагч тус бүр ямар эрх эдэлж, үүрэг хүлээхийг тусгана. Шийдвэр гүйцэтгүүлэх арга, журам, хугацаа, шийдвэрийг давж заалдах журам, хугацааг заана.</p>	<p>эрх зүй актыг тогтоох хэсэгт мөн дурдаж байхаар төсөлд тусгав.”</p>
<p><b>118 дугаар зүйл. Давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэх</b></p>			
<p>13</p>	<p>118 дугаар зүйлийн 118.3.Давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэж байгаа шүүх зөвхөн гомдолд дурдсан үндэслэлээр</p>	<p>Хэсэг өөрчлөн найруулах 118 дугаар зүйлийн 118.3.Давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэж байгаа шүүх зөвхөн гомдол, <b>тайлбарт</b> дурдсан</p>	<p>Шүүх нь Үндсэн хуулиар тогтоосон зарчим болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тусгай зарчимд захирагдаж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулдаг. Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны</p>

	<p>хязгаарлалгүй хэргийг бүхэлд нь хянан үзнэ.</p>	<p>үндэслэлээр хязгаарлалгүй хэргийг бүхэлд нь хянан үзэх бөгөөд давж заалдах шатны шүүх хуралдаанаар хэлэлцээгүй асуудлыг шийдвэрийн үндэслэл болгохгүй.</p>	<p>үндсэн зарчим болдог бол хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх, шүүгч хараат бус байж гагцхүү хуульд захирагдах, хэрэг маргааныг хамтын зарчмаар шийдвэрлэх гэсэн зарчмууд нь шүүх эрх мэдлийн Үндсэн хуулийн зарчимд хамаардаг. Харин талуудын зарчим, мэтгэлцэх буюу шүүх хөндлөнгийн байх, шүүх хуралдааныг нээлттэй, тасралтгүй явуулах, монгол хэл дээр явуулах, эх хэлээрээ мэдүүлэг тайлбар өгөх, шүүхийн шийдвэр заавал биелэгдэх гэсэн зарчмууд нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тусгай зарчим гэж үздэг. Эдгээр зарчмууд нь шүүхийн бүх шатанд хангагдаж байж шударга шүүхийн үндсэн шинж хадгалагдана. Шүүх хуралдаанаар хэлэлцээгүй асуудлаар шүүх шийдвэр гаргах нь шүүх хөндлөнгийн байх зарчимд үл нийцнэ. Ялангуяа давж заалдах шатны журмаар хэрэг хянан шийдвэрлэх үед шүүх хуралдаанаар хэлэлцээгүй асуудлаар шүүх шийдвэр гаргах нь хэргийн оролцогч нөгөө талын давж заалдах гомдол гаргах үндсэн эрхтэй зөрчилдөнө. Нөгөө талаас шүүх нь мөрдөн шалгах чиг үүргийг хүлээдэггүй дурдах нь зүйтэй. Тиймээс давж заалдах шатны шүүх хуралдаанаар хэлэлцээгүй асуудал давж заалдах шатны шүүхийн шийдвэрийн үндэслэл болохгүй байх талаар төсөлд тусгав.</p>
<p><b>122 дугаар зүйл. Шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд гомдол гаргах</b></p>			
14	<p>122.6.Энэ хуулийн 122.1-д заасны дагуу гаргасан гомдлыг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор <b>давж заалдах шатны</b></p>	<p>Үг өөрчлөх</p> <p>122.6.Энэ хуулийн 122.1-д заасны дагуу гаргасан гомдлыг</p>	<p>Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргасан шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд тухайн шатны шүүхэд гомдол гаргаж шийдвэрлэдэг байхаар төсөлд тусгав. Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд зааснаар иргэний процесст</p>

	<p><b>Шүүх</b> гурван шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр шийдвэрлэж, дараахь тогтоол гаргана:</p>	<p>хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор <b>тухайн шатны шүүх гурван шүүгчийн</b> бүрэлдэхүүнтэйгээр шийдвэрлэж, дараахь тогтоол гаргана:</p>	<p>тухайн шатны гурван шүүгч, эрүүгийн процесст Ерөнхий шүүгч эсхүл түүнээс томилогдсон шүүгч дангаар энэ асуудлыг шийдвэрлэдэг. Тиймээс захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гарсан шүүхийн захирамж, тогтоолд гаргасан гомдлыг тухайн шатны 3 шүүгч шийдвэрлэдэг байхаар төсөлд тусгав.</p>
15	<p>122.7.Энэ хуулийн 122.6-д заасан тогтоол эцсийн шийдвэр байна.</p>	<p>Үг нэмэх 122 дугаар зүйлийн 122.7.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 122.6-д заасан тогтоол эцсийн шийдвэр байна.</p>	<p>Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах эрх нь иргэний Үндсэн хуулиар баталгаажсан үндсэн эрх юм. Шүүхэд гаргасан гомдлыг шүүх хүлээн авахаас татгалзаж, тэрхүү шийдвэр нь тухайн шатандаа эцсийн болдог эрх зүйн зохицуулалт одоо үйлчилж байна. Үүнээс шалтгаалан нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан анхан шатны шүүхийн шийдэл нь давж заалдах болон хяналтын шатны шүүхийн хяналтын гадна үлддэг. Улмаар анхан шатны шүүхийн шийдэл буруу тохиолдолд иргэн “шүүхэд гомдол мэдүүлэх” Үндсэн хуулиар баталгаажсан эрхээ нэхэмжлэгч этгээд эдэлж чадахгүй хүрдэг. Харин нэхэмжлэл хүлээн авахаас татгалзсан бусад анхан шатны шүүхийн шийдвэрээс бусад процессийн үед гаргасан анхан шатны шүүхийн шийдвэр нь процессийн хувьд давж заалдах болон хяналтын шатанд хянагдах боломжтой байдаг. Тиймээс нэхэмжлэл хүлээн авахаас татгалзсан шүүгчийн захирамж нь давж заалдах болон хяналтын шатны шүүхэд хянагдах боломжийг нээн төсөлд тусгалаа. Үндсэн хуулийн 48.1-д “Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно.” гэж заасан</p>

			байдаг. Нэхэмжлэл хүлээн авахаас татгалзсан шүүхийн шийдвэр нь доод шатандаа эцсийн болж, хяналтын шатны шүүх хянах боломжгүй болох нь Үндсэн хуулийн заалтад нийцдэггүй буюу дагнасан шүүхийн үйл ажиллагаа Улсын дээд шүүхийн хяналтын гадна үлддэг билээ.
16		Хэсэг нэмэх 122.8.Нэхэмжлэл хүлээн авахаас татгалзсан шүүгчийн захирамжид гаргасан гомдлыг хангахгүй орхисон бол нэхэмжлэгч давж заалдах шатны болон хяналтын журмаар гомдол гаргах эрхтэй.	Дээр дурдсантай агуулга ижил.
17		Хэсэг нэмэх  122.9.Энэ хуулийн 122.6-д заасан гомдлыг хянан шийдвэрлэхэд тухайн шатны шүүхийн бүрэлдэхүүн хүрэлцэхгүй бол тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс тойргийн журмаар томилогдсон шүүгч дангаар хянан шийдвэрлэж болно.	Захиргааны хэргийн дагнасан шүүхийн хүний нөөц, зохион байгуулалтаас шалтгаалан зарим анхан шатны шүүхүүд гомдлын шүүх хуралдааныг хийхэд бүрэлдэхүүн хүрэлцэхгүй байх тохиолдол байдаг. Тиймээс энэ тохиолдолд гомдлыг тухайн шүүгчдийн зөвлөгөөнөөс томилогдсон аль нэг шүүгч дангаар шийдвэрлэж болохоор төсөлд тусгав.
<b>123 дугаар зүйл. Хяналтын журмаар гомдол гаргах</b>			
18		Заалт нэмэх  123 дугаар зүйлийн 123.2.5.хууль зөрчсөн.	Үндсэн хуулийн цэцийн 2017-04-12-ны өдрийн 03 дүгнэлтэд "...Хяналтын шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зөвхөн анхан болон давж заалдах шатны шүүх эрүүгийн хэргийг

			<p>шийдвэрлэхдээ Эрүүгийн хуулийг зөв хэрэглэсэн эсэх, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн эсэх тухай хууль хэрэглээний асуудлыг хянан хэлэлцдэг онцлогоос хамаарч..." гэсэн байдаг. Өөрөөр хэлбэл эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд хяналтын шатны шүүхийн хяналтын цар хүрээнд хуулийг зөв хэрэглэсэн эсэх нь зайлшгүй багтдаг. Тиймээс хуулийг зөв хэрэглэсэн эсэх талаарх асуудлаар буюу хууль зөрчсөн эсэх асуудлаар хяналтын шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй байдлаар төсөлд тусгав.</p>
19		<p>Хэсэг нэмэх</p> <p>123 дугаар зүйлийн 123.8.Шийдвэрийг хүчингүй болгож дахин шийдвэрлүүлэхээр анхан шатны шүүхэд буцаасан магадлалд хяналтын журмаар гомдол гаргахгүй.</p>	<p>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд энэ талаар өөрчлөлт оруулахаар тусгасан тул хууль хоорондын ялгамжтай байдал үүсгэхгүй үүднээс энэ заалтыг өөрчлөхөөр мөн төсөлд тусгасан. Аливаа хэрэг маргааныг агуулгын хувьд давж заалдах шатны шүүх хянан шийдвэрлээгүй байхад тухайн хэрэг маргааныг хяналтын журмаар шийдвэрлэх нь талуудын тэгш байдал, хэргийн талаар тайлбар мэдүүлэг гаргах талуудын хууль ёсны ашиг сонирхол, бүх шатны шүүх хөндлөнгийн байх зарчим, шүүхийн шийдвэр давж заалдах эрхэд нийцэхгүй гэж үзэн энэхүү өөрчлөлтийг тусгав. Өөрөөр хэлбэл шүүх хэрэг маргааныг агуулгын хувьд бүрэн шийдвэрлэсний дараа дараагийн шатны шүүх доод шатны шүүхийн шийдвэрийг хянан үздэг байх нь хэрэг маргааны үнэн зөв шийдэх чухал ач холбогдолтой гэж үзэв. Үүнээс гадна давж заалдах шатны шүүх хэргийг агуулгын хувьд бүрэн хянан шийдвэрлээгүй байхад хяналтын журмаар гомдол гаргах, хяналтын шатны шүүх гомдлыг хэлэлцэхээс татгалзах, анхан шатны шүүхээр дахин хэлэлцэх зэрэгт дунджаар 2-3 сар зарцуулагддаг нь</p>

			хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа уртсах үндсэн нөхцөл болдог.
<b>124 дүгээр зүйл. Хяналтын журмаар гаргасан гомдол хүлээж авах</b>			
20	124 дүгээр зүйлийн 124.3.Хяналтын шатны шүүх гомдлыг хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор танхимын нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцэж дөрөв, түүнээс дээш шүүгч хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх талаар санал гаргавал энэ тухай тогтоол гаргана.	Өгүүлбэр нэмэх 124 дүгээр дугаар зүйлийн 124.3.Хяналтын шатны шүүх гомдлыг хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор <b>энэ хуулийн 123.2.1-123.2.5-т заасан үндэслэлээр гомдол гаргасан эсэхийг</b> танхимын нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцэж, хуульд заасан үндэслэл, журмын дагуу гомдол гаргасан гэж дөрөв, түүнээс дээш шүүгч санал гаргавал хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тогтоол гаргана.	Үндсэн хуулийн цэцийн гишүүний 2020 оны 07-р тогтоолд дурдагдсан Хууль зүйн сургуулийн профессор, хууль зүйн ухааны доктор Д.Баярсайхан дүгнэлтэд "1.Эрүүгийн процессын эрх зүйн шинжлэх ухаанд эрүүгийн хэргийг хяналтын журмаар хүлээн авч шийдвэрлэх Улсын дээд шүүхийн бүрэн эрхийг: а)Процедурын болон завсрын шийдвэр гаргах, б)Хэргийг эцэслэх буюу сүүлчийн шийдвэр гаргах гэж хоёр ангилалд ялган авч үздэг. Завсрын процесс гэдэг нь хяналтын журмаар гомдол эсэргүүцлийг Улсын дээд шүүхэд гаргасныг хуульд заасан харьяаллын болон түүний шаардлагыг хангасан эсэхийг урьдчилан хянаж хэсэгчлэн томилсон бүрэлдэхүүн бүхий шүүгч нарын (3 шүүгч) хэлэлцүүлгээр оруулж, Улсын дээд шүүхийн чиглэлийн шүүгч нарын хуралдаанд оруулах эсэхийг шийдвэрлэнэ. Энэ нь хэргийг шийдэх процесс биш, зөвхөн тухайн гомдол, эсэргүүцлийг хуульд заасан харьяаллын дагуу гаргасан эсэхийг хянан тогтооход чиглэгдсэн үйл явц юм. Харин хэргийг эцэслэн шийдэх Улсын дээд шүүхийн хуралдаан болон түүнээс гарах шийдвэр нь Улсын дээд шүүхийн эцсийн шийдвэр болно." гэж дүгнэсэн байдаг. Тиймээс хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцэх эсэх асуудлыг шийдвэрлэхдээ хуульд заасан үндэслэлээр гомдол гаргасан эсэхийг хянадаг байдлыг тодруулан төсөлд тусгав. Одоо байгаа хуулийн үйлчлэл нь

			тодорхойгүй, хуульд заасан үндэслэлээр гомдол гаргасан эсэх нь ач холбогдолгүй байхаар хуульчлагдсан.
<b>127 дугаар зүйл. Хяналтын шатны шүүх хуралдаан</b>			
21	127 дугаар зүйлийн 127.2.Шүүх хяналтын журмаар хэргийг дараахь байдлаар хянан шийдвэрлэж тогтоол гаргана:	Хэсэг өөрчлөн найруулах  127 дугаар зүйлийн 127.2.Хяналтын шатны шүүх хяналтын журмаар <b>гаргасан гомдлын шаардлагын хүрээнд</b> хэргийг дараахь байдлаар хянан шийдвэрлэж тогтоол гаргана:	Шүүх хөндлөнгийн байх зарчим нь шүүхийн аль ч шатанд хамаатай. Анхан шатны шүүх л хөндлөнгийн, дээд шатны шүүх нь өөрийн үзэмжээр маргааныг хянан шийдвэрлэх нь хөндлөнгийн байх зарчим үл нийцнэ. Өөрөөр хэлбэл оролцогчийн маргаагүй асуудлыг шүүх санаачилгаараа авч шийдвэрлэх нь хөндлөнгийн байх зарчмыг ноцтой алдагдуулдаг. Тиймээс хяналтын шатны шүүх гомдлын үндэслэл, шаардлагын хүрээнд хэргийг хуульд заасан журмаар шийдвэрлэхээр төсөлд тусгав.
22	127.5.Хяналтын шатны тогтоол шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд тогтоолд гомдол гаргахгүй.	Үг нэмэх 127 дугаар зүйлийн 127.5. <b>Энэ хуульд өөрөөр заагаагүй бол</b> хяналтын шатны тогтоол шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд тогтоолд гомдол гаргахгүй.	Үндсэн хуульд зааснаар Үндсэн хуулийн цэцийн хяналтад Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Ерөнхий прокурор байдаг. Гэвч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Үндсэн хууль, хүний үндсэн эрх зөрчигдсөн тохиолдолд шүүх хэрхэн хамгаалах, хангах талаар зохицуулалтгүй үлдэн, улмаар энэхүү зөрчил Цэцийн хяналтын гадна үлддэг. Тиймээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүний үндсэн эрх зөрчигдсөн тохиолдолд Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчид гомдол гаргах талаар төсөлд тусгасантай холбогдуулан энэхүү заалтад энэ хуульд өөрөөр заагаагүй бол гэж тодруулан тусгав.
23		Хэсэг нэмэх	Гомдолд дурдагдаагүй, түүнчлэн шүүх хуралдаанаар хэлэлцээгүй асуудлаар шүүх

		127 дугаар зүйлийн 127.7. Хяналтын журмаар гаргасан гомдол, тайлбарт дурдагдаагүй, түүнчлэн хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцээгүй асуудлыг зөвлөлдөх тасалгаанд хэлэлцэхгүй бөгөөд шийдвэрийн үндэслэл болгохгүй.	зөвлөлдөж шийдвэрлэх нь талуудын мэтгэлцэх зарчим, тухайн асуудлаар шүүхэд тайлбар мэдүүлэг гаргах боломжийг ноцтой алдагдуулна. Тиймээс гомдол, тайлбарт дурдагдаагүйгээс гадна шүүх хуралдаанаар хэлэлцээгүй асуудлаар зөвлөлдөхгүй, хэлэлцэхгүй байхаар төсөлд тусгав.
<b>128 дугаар зүйл. Хяналтын шатны шүүхийн шийдвэрт гомдол гаргах</b>			
24		<p>Зүйл нэмэх</p> <p><b>128 дугаар зүйл. Хяналтын шатны шүүхийн шийдвэрт гомдол гаргах</b></p> <p>128.1.Хяналтын шатны шүүхийн шийдвэр Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн гэж үзвэл хэргийн оролцогч уг шийдвэрийг гардан авснаас хойш 30 хоногийн дотор Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчид гомдол гаргаж болно.</p> <p>128.2.Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч гомдлыг хянан үзэж 30 хоногийн дотор дүгнэлт гаргана. Дүгнэлтэд гомдол</p>	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шатанд хүний үндсэн эрх буюу Үндсэн хуулийн холбогдох зохицуулалт зөрчигдсөн тохиолдолд уг эрхийг хэрхэн хангах, хамгаалах талаар хуульд тусгагдахгүй байсаар өнөөдрийг хүрсэн. Үүнээс шалтгаалж хэрэг хянан шийдвэрлэх эрх бүхий этгээдийн зүгээс үндсэн эрхийг буюу Үндсэн хуулийг “үл ойшоох” хандлага ажиглагддаг. Энэ ч үүднээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шатанд үндсэн эрх зөрчигдөх тохиолдолд Үндсэн хуулийн 66.2.3 дахь заалтад Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Үндсэн хууль зөрчсөн эсэх асуудлыг Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэхээр заасан байдаг. Энэ нь Үндсэн хууль нь хэрэг хянан шийдвэрлэх бүх шатанд бүрнээ хэрэгжих, түүний хэлбэрэлтгүй дагаж мөрдөн үндэс болдог. Тиймээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Үндсэн хууль зөрчигдсөн, тэр нь залруулагдаагүй тохиолдолд Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчид гомдол гаргах, Ерөнхий шүүгч дүгнэлт гаргах, Үндсэн хуулийн цэцэд тухайн асуудлаар өргөдөл

		<p>үндэслэлтэй, эсхүл үндэслэлгүй талаар тусгасан байна.</p> <p>128.3.Гомдол үндэслэлтэй гэж дүгнэлт гарсан бол Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн дүгнэлтийг хэлэлцэнэ.</p> <p>128.4. Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн дүгнэлт үндэслэлтэй гэж Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаас үзвэл дагуу хяналтын шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгоно.</p> <p>128.5.Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн дүгнэлт Үндсэн хууль зөрчсөн эсэх маргааныг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд заасан журмын дагуу хянан шийдвэрлэнэ.</p> <p>128.6. Улсын дээд шүүхийн шийдвэр эцсийн байна. Улсын дээд шүүхийн шийдвэр хуульд харшилбал түүнийг Улсын дээд шүүх өөрөө хүчингүй болгоно.</p>	<p>гаргаж хүний үндсэн эрхийг хамгаалах боломжийг бүрдүүлэхээр төсөлд тусгав.</p>
--	--	---	---

## ӨМГӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

	Хууль	Төсөл	Танилцуулга
<b>13 дугаар зүйл.Өмгөөлөгчийн эрх</b>			
1		<p>Заалт нэмэх                      13 дугаар зүйлийн 13.1.15.Шүүх шинжилгээний тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан шинжилгээ хийх эрх бүхий бусад этгээд өөрөө зөвшөөрсөн тохиолдолд өмгөөлөгч шинжилгээ хийлгэх хүсэлт гаргах.</p>	<p>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд Шүүх шинжилгээний тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан шинжилгээ хийх эрх бүхий бусад этгээдийн өөрийнх нь зөвшөөрснөөр шинжилгээ хийлгэх, дүгнэлт гаргуулах талаар тусгасантай холбогдуулан энэ хэсгийг Өмгөөллийн тухай хуульд нэмэлт оруулахаар тусгав.</p>

**ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

№	Хууль	Төсөл	Танилцуулга
<b>6 дугаар зүйл.Шүүх шинжилгээ хийх үндэслэл</b>			
1		<p>Хэсэг нэмэх 6 дугаар зүйлийн 6.2.Энэ хуулийн 10 дугаар зүйлд заасан шинжилгээ хийх эрх бүхий бусад этгээд өөрөө зөвшөөрсөн тохиолдолд өмгөөлөгч шинжилгээ хийлгэх хүсэлт гаргах эрхтэй.</p>	<p>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд Шүүх шинжилгээний тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан шинжилгээ хийх эрх бүхий бусад этгээдийн өөрийнх нь зөвшөөрснөөр шинжилгээ хийлгэх, дүгнэлт гаргуулах талаар тусгасантай холбогдуулан энэ хэсгийг Шүүх шинжилгээний тухай хуульд нэмэлт оруулахаар тусгав.</p>

**МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

Хууль	Төсөл	Танилцуулга
25 дугаар зүйл.Улсын дээд шүүх, түүний бүрэн эрх		
1	<p>Заалт нэмэх</p> <p>25 дугаар зүйлийн 25.7.5.д.хууль зөрчсөн эсэх.</p> <p>Заалт нэмэх</p> <p>25.7.6.Ерөнхий шүүгчийн дүгнэлт.</p>	<p>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд төстэй харилцаанд өөрчлөлт оруулахаар тусгасан тул адилтгах, хууль хоорондын зөрчилдөөн үүсгэхгүйн тулд Шүүхийн тухай хуульд мөн нэмэлт оруулахаар төсөлд тусгав.</p> <p>Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүний үндсэн эрх зөрчигдсөн эсэх асуудлаар Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчид гомдол гаргах, Ерөнхий шүүгчээс дүгнэлт гаргахтай холбоотой харилцааг нэмж тусгахаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлд тус тус тусгасан. Үүнтэй холбоотойгоор Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар Ерөнхий шүүгчийн дүгнэлтийг хэлэлцэх талаар төсөлд тусав.</p>
26 дугаар зүйл.Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаан		
26.1.Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаар энэ хуулийн 25.7.3, 25.7.4, 25.8-д заасан асуудлыг хэлэлцэн	<p>Үг нэмэх /заалт/</p> <p>26.1.Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаар энэ хуулийн 25.7.3, 25.7.4, 25.8, <b>25.7.6</b>-д заасан асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоол гаргана.</p>	Дээрхтэй агуулга ижил.

шийдвэрлэж, тогтоол гаргана.		
101 дүгээр зүйл.Шүүгчид холбогдох сахилгын хэргийг хянан шийдвэрлэх ерөнхий нөхцөл		
	<p>Хэсэг нэмэх</p> <p>101 дүгээр зүйлийн 101.7.Хэрэг, маргааныг хянан шийдвэрлэж гарсан шүүхийн шийдвэрийг Сахилгын хороо хянан шалгахгүй.</p>	<p>Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ гэж Үндсэн хуулийн 47.1 дэх хэсэгт заасан. Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлж гаргасан шүүхийн шийдвэрийг хянан үзэж шийдвэр гаргах эрх мэдэл зөвхөн Үндсэн хууль, хуульд заасны дагуу байгуулагдсан дээд шатны шүүхэд хадгалагдах нь дэлхийн нийтээр хүлээн зөвшөөрсөн эрх мэдэл хуваарилах зарчим юм. Энэ ч агуулгаар Үндсэн хуулийн 47.2 дахь хэсэгт ямар ч нөхцөлд шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглохоор заасан байдаг. Харин практикт шүүхийн шийдвэрийг шүүхийн сахилгын хороо хянан шалгах үзэгдэл гарсаар байна. Тухайлбал Үндсэн хуулийн цэцийн 2024-11-01-ны өдрийн 23 магадлалд “...Шүүхийн сахилгын хороо... сахилгын зөрчлийн тухай өргөдөл, мэдээлэл, гомдол, эсэргүүцлийг хянан шийдвэрлэхдээ шүүхийн шийдвэрийн үндэслэл хэсэг, шүүгчийн дотоод итгэлээрээ шийдвэрлэх асуудлыг хянан шалгаж... байгаа нь иргэдээс Үндсэн хуулийн цэцэд хандаж мэдээлэл гаргах үндэслэл болсон гэж үзэхээр байна... Сахилгын хэргийг шалган шийдвэрлэх ажиллагааны онцлогийг харгалзан холбогдох зохицуулалтыг нарийвчлан хуульчлах, эрх зүйн хэм хэмжээний давхардал, хийдлийг арилгах, шүүгчид холбогдох хэргийг шалгах, хянан шийдвэрлэх үндэслэл, журмыг нарийвчлан зохицуулах шаардлага байгааг дурдах нь зүйтэй байна.” Гэжээ.</p>

			<p>Хэрэв шүүх түүнээс гаргасан шийдвэрийг Үндсэн хууль, хуульд заасны дагуу байгуулагдсан дээд шатны шүүхээс өөр этгээд хянан шалгаж эхэлбэл нь энэ нь шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлэх зарчим алдагдана. Шүүгч хараат байвал энэ нь иргэний шударга шүүхээр шүүлгэх үндсэн эрхэд ноцтой хохирол учирна. Үндсэн хуульд зааснаар сахилгын хороо нь шүүх биш юм. Шүүхийн шийдвэр нь шүүх биш этгээдийн хяналтад байх нь шударга шүүхийн зарчимд үл нийцнэ. Тиймээс хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг шүүхийн захиргааны байгууллага болох сахилгын хороо хянан шалгахгүй, шийдвэрлэхгүй байхаар төсөлд тусгав.</p>
--	--	--	---

## ПРОКУРОРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Хууль	Төсөл	Танилцуулга
6 дугаар зүйл.Нэгдмэл төвлөрсөн удирдлагатай байх		
1	<p>6 дугаар зүйлийн 6.1.Прокурор дээд шатны прокурорын өмнө ажлаа хариуцна. Прокурор дээд шатны прокурорын хууль ёсны шийдвэр, даалгаврыг заавал биелүүлнэ.</p>	<p>Өгүүлбэр хасах 6 дугаар зүйлийн 6.1.Прокурор дээд шатны прокурорын хууль ёсны шийдвэр, даалгаврыг заавал биелүүлнэ.</p> <p>“Монгол Улсын төрийн байгуулал” гэсэн Үндсэн хуулийн 3-р бүлгийн “Шүүх эрх мэдэл” гэсэн дэд бүлэгт прокурорыг хамааруулан заасан. Өөрөөр хэлбэл Үндсэн хуулийн төрийн эрх мэдлийн хуваарилалтаар прокурор нь шүүх эрх мэдэлд хамаардгийг илэрхийлдэг. Шүүх эрх мэдлийн үндсэн зарчим нь хараат бус байж гагцхүү хуульд захирагдахад байдаг. Хараат бус зарчим нь эрх мэдлийг хэрэгжүүлж байгаа этгээд хооронд захирах, захирагдах ёс үйлчилдэггүй ба гагцхүү хуульд захирагдаж шийдвэр гаргахад оршдог. Энэ ч агуулгаар Прокурорын тухай хуулийн 3.1.4 дэх заалт, 7-р зүйлд тус тус прокурорын хараат бус байдлыг баталгаажуулсан. Харин уг хуулийн 6.1-д прокурор дээд шатны прокурорын өмнө ажлаа хариуцах талаар заасан нь хараат бус, бие даасан зарчимтай зөрчилдөж байгаа тул хасахаар төсөлд тусгав. Энэ нь Үндсэн хуулийн эрх мэдэл хуваарилах зарчимд мөн нийцнэ гэж үзэв.</p>

## ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

	Хууль	Төсөл	Танилцуулга
1.4 дүгээр зүйл.Гэм буруугийн зарчим			
1		<p>Хэсэг нэмэх 1.4 дүгээр зүйлийн 5. Нийтийн албан тушаалтан нь хууль болон эрх зүйн ухамсрыг удирдлага болгож баримт мэдээллийг өөрийн дотоод итгэлээр үнэлж шийдвэр гаргасны төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй.</p>	<p>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгч, прокурор, мөрдөгч нь нотлох баримтыг тал бүрээс нь нягт нямбай, бүрэн гүйцэд, бодит байдлаар нь хянаж үзсэний үндсэн дээр нотлох баримтыг өөрийн дотоод итгэлээр үнэлж шийдвэр гаргасанд хариуцлага хүлээлгэдэггүй. Харин энэхүү зарчим нь зөвхөн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд, зөвхөн шүүгч, прокурор, мөрдөгчид хамааралтай гэж үзэх нь учир дутагдалтай. Нийтийн буюу төрийн аливаа албан хаагч өөрт хамаарах хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх явцдаа тодорхой нотлох баримтыг итгэл үнэмшлийн дагуу үнэлж, хууль зөрчихгүйгээр шийдвэр гаргах нь нийтлэг харилцаа юм. Хүн бүр хуулийн өмнө эрх тэгш байх нь Үндсэн хуулийн үндсэн зарчим юм.</p>
22.1 дүгээр зүйл.Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах			
2	<p>22.1 дүгээр зүйлийн 1.Нийтийн албан тушаалтан албан үүрэг, бүрэн эрх, албан</p>	<p>Өгүүлбэр өөрчлөх 22.1 дүгээр зүйлийн 1.Нийтийн албан тушаалтан албан үүрэг, бүрэн эрх, албан тушаалын</p>	<p>Монгол Улс нь “Авилгалын эсрэг нэгдсэн үндэстний байгууллагын конвенц”-д 2005 онд нэгдэн орсон. Конвенцийн “Хамрах хүрээ” гэсэн 3-р зүйлийн 1-д “Энэхүү</p>

<p>тушаалын байдлаа урвуулан ашиглаж, эсхүл зориуд хэрэгжүүлэхгүй байж өөртөө, эсхүл бусдад давуу байдал бий болгосон бол нийтийн албанд ажиллах эрхийг хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хасаж нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> <p>22.1 дүгээр зүйлийн 2.Нийтийн албан тушаалтан албан үүрэг, бүрэн эрх, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж их хэмжээний хохирол учруулсан бол нийтийн албанд ажиллах эрхийг хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хасаж хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> <p>Тайлбар:</p>	<p>байдлаа хэрэгжүүлэх явцад өөртөө эсхүл бусдад шууд буюу шууд бусаар зүй бус давуу тал олгох зорилгоор аливаа үйлдлийг санаатайгаар хууль тогтоомж зөрчин гүйцэтгэсэн буюу гүйцэтгээгүй бол нийтийн албанд ажиллах эрхийг хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хасаж нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p>	<p>конвенцийн дагуу авилгалаас урьдчилан сэргийлэх, түүнийг мөрдөн байцаах, яллах... -д энэхүү конвенцыг хэрэглэнэ.” Гэсэн. Мөн 19-р зүйлд “Оролцогч улс бүр төрийн албан тушаалтан өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэх явцад өөртөө эсхүл өөр этгээд буюу байгууллагад шууд буюу шууд бусаар зүй бус давуу тал олгох зорилгоор чиг үүрэг буюу албан тушаалаа урвуулан ашиглах, өөрөөр хэлбэл, аливаа үйлдлийг хууль тогтоомж зөрчин гүйцэтгэх буюу гүйцэтгэхгүй байх үйлдлийг санаатайгаар үйлдсэнийг гэмт хэрэг гэж тогтооход шаардлагатай байж болох хууль тогтоох болон бусад арга хэмжээг авах асуудлыг авч үзнэ.” Гэж дэлгэрэнгүй тусгасан байдаг. Тиймээс Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлд “урвуулан ашиглах” гэсэн томъёоллыг “Авилгалын эсрэг нэгдсэн үндэстний байгууллагын конвенц”-д нийцүүлэн дэлгэрэнгүй байдлаар өөрчлөхөөр төсөлд тусгав. Авлига нь нийгмийн тогтвортой болон аюулгүй байдалд үүсэж буй бэрхшээл, аюул занал нь ардчилсан тогтолцоо, үнэт зүйлс, түүнчлэн ёс зүйн үнэт зүйлс, шударга ёсыг сулруулж, тогтвортой хөгжил, хууль дээдлэх ёсонд хохирол учруулдаг гэдгийг НҮБ-аас хүлээн зөвшөөрч улмаар олон улс нэгдэн орсны нэг нь Монгол Улс юм. Хуулийн зохицуулалт ялангуяа Эрүүгийн хуульд гэмт хэргийг тодорхойлж байгаа хэм хэмжээ ерөнхий байх нь тухайн хуулийг хэрэгжүүлж байгаа</p>
--	---	---

<p>Энэ хуульд заасан “урвуулан ашиглах” гэж албан үүрэг, албан тушаал, албан тушаалын байдлын эрх мэдлээ албаны эрх ашгийн эсрэг, эсхүл хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх зорилгод ашиглаж хийх ёстой үйлдлийг хийхгүй байх, хийх ёсгүй үйлдэл хийх, эрх мэдлээ хэтрүүлэхийг ойлгоно.</p>		<p>этгээдийн тухайд үзэмжээрээ асуудалд хандах нөхцөл болдог. Авлигын эсрэг тэмцлийг үр дүнтэй болгох, олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар биелүүлэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх үүднээс энэ зохицуулалтыг төсөлд тусгав. Хуулийн зохицуулалт дэлгэрэнгүй, нарийвчилсан байх нь хүний шударгаар шүүлгэх эрхэд мөн онцгой хамааралтай гэж үзэв.</p> <p>Түүнчлэн хуульд нэг өөрөөр тусгаж, түүнийгээ дахин хуулийн тайлбараар тайлбарлан дурдах нь хууль хэрэгжүүлэх этгээдийн дур зоргоор аашлах нөхцөлийг бүрдүүлж болзошгүй байдлыг харгалзан хуулийн зохицуулалт, тайлбарыг нэгтгэн олон улсын гэрээнд нийцүүлэн өөрчлөхөөр төсөлд тусгав.</p>
--	--	--

## ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Хууль	Төсөл	Танилцуулга
<b>15.37 дугаар зүйл.Өмгөөллийн тухай хууль зөрчих</b>		
1	<p>Зүйл нэмэх 15.37 дугаар зүйл.Өмгөөллийн тухай хууль зөрчих</p> <p>15.37 зүйлийн 1.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа өмгөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагаагаа эрхлэхэд нь дарамт шахалт үзүүлсэн, саад учруулсан, заналхийлсэн, хөндлөнгөөс нөлөөлөхийг оролдсон бол хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p>	<p>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд хүний эрх, эрх чөлөөг хамгаалан ажиллаж байгаа өмгөөлөгчийн эрх зүйн байдлыг дээрдүүлэх, баталгаажуулах талаар зохицуулалтууд нэмж тусгасан. Тиймээс өмгөөллийн үйл ажиллагааг баталгааг хангах үүднээс өмгөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагаагаа эрхлэхэд нь дарамт шахалт үзүүлсэн, саад учруулсан, заналхийлсэн, хөндлөнгөөс нөлөөлөхийг оролдсон этгээдэд зөрчлийн хариуцлага хүлээлгэхээр төсөлд тусгав.</p>

**УЛСЫН ТЭМДЭГГИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН  
ТАНИЛЦУУЛГА**

	Хууль	Төсөл	Танилцуулга
41 дүгээр зүйл.Тэмдэгтийн хураамжаас чөлөөлөх, хөнгөлөх			
1		<p>Заалт нэмэх 41 дүгээр зүйлийн 41.1.17.гэм хор учруулснаас үүсэх үүргийг биелүүлэх тухай нэхэмжлэл.</p>	<p>Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-т иргэн нь бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй гэж заасан. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 41.1.7-д зааснаар гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг арилгуулахаар гаргасан нэхэмжлэл тэмдэгтийн хураамжаас чөлөөлдөг. Харин Эрүүгийн хуулийн 1.4-р зүйлийн 2-т заасан тохиолдолд буюу гэм буруугүйгээр энэ хуульд заасан хохирол, хор уршиг учруулсан тохиолдолд учирсан хохирлын талаар нэхэмжлэл гаргахад улс тэмдэгтийн хураамжаас чөлөөлөгддөггүй. Тиймээс хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчмын хүрээнд гэм буруугүйгээр гэм хор учруулснаас үүсэх үүргийн биелүүлэх нэхэмжлэлийг тэмдэгтийн хураамжаас чөлөөлөхөөр төсөлд тусгав.</p>

**ХУУЛЬ САНААЧЛАГЧ**